



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 06 ДУГААР САРЫН 20-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-9
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	10-59
1.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, яаралтай хэлэлцэх эсэх, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасны дагуу/	11-12
2.“Эрчим хүч-3 төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын Зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.05.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах, үргэлжлэв/	12-20
3.Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар 2025.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, яаралтай хэлэлцэх эсэх, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасны дагуу/	20-21
4.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.05.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	21-59

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
06 дугаар сарын 20-ны өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 65 гишүүн хүрэлцэн ирж, 51.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 10 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: М.Бадамсүрэн, Д.Батбаяр, Х.Баттулга, П.Батчимэг, Г.Ганбаатар, Ж.Ганбаатар, Ц.Даваасүрэн, Л.Мөнхбаясгалан, П.Мөнхтулга, Н.Наранбаатар, Р.Сэддорж, Ц.Туваан, Да.Цогтбаатар;

Чөлөөтэй: Х.Булгантуяа, М.Ганхүлэг, Л.Оюун-Эрдэнэ, А.Ундраа, Л.Энхнасан, М.Энхцэцэг, С.Эрдэнэбат;

Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Баатархүү, Ж.Батжаргал, Л.Гантөмөр, Т.Мөнхсайхан, З.Мэндсайхан, Д.Энхтүвшин;

Тасалсан: А.Ганбаатар, С.Одонтуяа;

Хоцорсон: Ж.Алдаржавхлан -06 минут, Н.Алтаншагай -06 минут, Б.Батбаатар -39 минут, Р.Батболд -03 минут, Н.Батсүмбэрэл -39 минут, Б.Батцэцэг -39 минут, Ж.Бат-Эрдэнэ -39 минут, Ж.Баясгалан -10 минут, Ш.Бямбасүрэн -39 минут, С.Ганбаатар -39 минут, Г.Дамдинням -20 минут, Б.Дэлгэрсайхан -18 минут, Х.Жангабыл -24 минут, Б.Жаргалан -16 минут, Д.Жаргалсайхан -39 минут, С.Лүндэг -16 минут, Ц.Мөнхбат -20 минут, Ц.Мөнхтуяа -11 минут, Б.Найдалаа -1 цаг 08 минут, Э.Одбаяр -39 минут, У.Отгонбаяр -01 минут, Б.Пунсалмаа -20 минут, Б.Тулга -24 минут, Г.Тэмүүлэн -39 минут, Г.Уянгахишиг -39 минут, Б.Хэрлэн -24 минут, Д.Цогтбаатар -2 цаг 20 минут, С.Цэнгүүн -01 минут, Б.Чойжилсүрэн -18 минут, Б.Энхбаяр -34 минут, Ж.Энхбаяр -38 минут, Р.Эрдэнэбүрэн -1 цаг 58 минут.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан нэгдсэн хуралдаан цагтаа эхлэхэд Улсын Их Хурлын гишүүд хариуцлагатай хандахыг сануулж, цагтаа ирээгүй Улсын Их Хурлын гишүүдийн нэрийг дуудав./10:08-10:10/

Өргөн мэдүүлсэн хуулийн төслийг танилцуулах

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа байлцав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 9 гишүүнээс 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд;

Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 9 гишүүнээс 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд;

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 9 гишүүнээс 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Хууль зүйн байнгын хороонд;

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ нарын 10 гишүүнээс 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Төрийн байгуулалтын байнгын хороонд;

Монгол Улсын Засгийн газраас 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг Төсвийн байнгын хороонд;

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж нарын 5 гишүүнээс 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Төсвийн байнгын хороонд;

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж нарын 4 гишүүнээс 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Төсвийн байнгын хороонд;

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа нарын 9 гишүүнээс 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Төрийн байгуулалтын байнгын хороонд;

Монгол Улсын Засгийн газраас 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Төсвийн байнгын хороонд тус тус хуваарилсныг танилцуулав./10:14/

Нэг.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, яаралтай хэлэлцэх эсэх, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасны дагуу/

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Монгол Улсын Засгийн газраас үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлснийг танилцуулав.

Д.Амарбаясгалан: Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	48
Татгалзсан:	22
Бүгд:	70

68.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар яаралтай хэлэлцэхээр шийдвэрлэсэн тул Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 18 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Эрчим хүч-3 төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын Зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.05.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах, үргэлжлэв/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, мөн яамны Стратеги, төлөвлөлтийн хэлтсийн дарга Г.Энхтүвшин, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, мөн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн Судалгаа, хөгжүүлэлтийн хэлтсийн дарга Б.Лхагвадэмбэрэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ч.Батбямба, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн нар байлцав.

“Эрчим хүч-3 төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын Зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийн хэлэлцүүлэг Улсын Их Хурлын гишүүдийн асуулт асууж, үг хэлэхээр үргэлжлэв.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, Д.Пүрэвдаваа, Н.Алтаншагай нарын тавьсан асуултад Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа үг хэлэв.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар “Эрчим хүч-3 төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын Зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66

Татгалзсан: 19

Бүгд: 85

77.6 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Уг асуудлыг 10 цаг 49 минутад хэлэлцэж дуусав.

Үдээс өмнөх хуралдаан 39 минут үргэлжилж, 10 цаг 49 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 05 минутад эхлэв.

Өргөн мэдүүлсэн хуулийн төслийг танилцуулах

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар 2025.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг Төрийн байгуулалтын байнгын хороонд хуваарилсныг танилцуулав./14:06/

Гурав.Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар 2025.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, яаралтай хэлэлцэх эсэх, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасны дагуу/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа байлцав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Монгол Улсын Засгийн газраас үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлснийг танилцуулав.

Д.Амарбаясгалан: Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийг яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 43
Бүгд: 95
54.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийг гишүүдийн олонхын саналаар яаралтай хэлэлцэхээр шийдвэрлэсэн тул Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 14 цаг 17 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.05.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Монгол Улсын Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга Б.Батбямба, Үндэсний итгэмжлэлийн төвийн дарга С.Ням-Эрдэнэ, мөн төвийн Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга З.Мөнхбат, Стандарт, хэмжил зүйн газрын дарга С.Батбаатар, мөн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Батзориг, Захиргаа, удирдлагын газрын дарга Б.Ууганбаяр, Сорьцын хяналтын газрын дарга Д.Бэхбат, Стандартчилал, тохирлын үнэлгээний бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Тулгаа, Нийслэлийн лабораторийн дарга Д.Эрдэнэтуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн дарга Б.Нарангэрэл, мөн хэлтсийн зөвлөх Бат.Баярмаа, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл, П.Сайнзориг, О.Саранчулуун, О.Номинчимэг, Ц.Идэрбат, Б.Уянга, Д.Үүрийнтуяа, Г.Очирбат, Г.Хосбаяр, М.Мандхай, Б.Пунсалмаа, Б.Хэрлэн, Г.Уянгахишиг нарын тавьсан асуултад Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Стандарт, хэмжил зүйн газрын дарга С.Батбаатар нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж 15 цаг 43 минутаас хуралдааныг даргалав.

Б.Пүрэвдорж: 1.Байнгын хорооны саналаар Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51
Татгалзсан: 45
Бүгд: 96
53.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

2.Байнгын хорооны саналаар Автотээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 43
Бүгд: 96

55.2 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Байнгын хорооны саналаар Байгаль орчныг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54

Татгалзсан: 42

Бүгд: 96

56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Байнгын хорооны саналаар Баяжуулсан хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54

Татгалзсан: 42

Бүгд: 96

56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Байнгын хорооны саналаар Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54

Татгалзсан: 42

Бүгд: 96

56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Байнгын хорооны саналаар Монгол хэлний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53

Татгалзсан: 43

Бүгд: 96

55.2 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Байнгын хорооны саналаар Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54

Татгалзсан: 42

Бүгд: 96

56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Байнгын хорооны саналаар Тамхины хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 42
Бүгд: 96
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Байнгын хорооны саналаар Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 44
Бүгд: 96
54.2 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Байнгын хорооны саналаар Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55
Татгалзсан: 41
Бүгд: 96
57.3 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Байнгын хорооны саналаар Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 43
Бүгд: 96
55.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 37 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 3 цаг 11 минут үргэлжилж, 126 гишүүнээс 98 гишүүн хүрэлцэн ирж, 77.8 хувийн ирцтэйгээр 16 цаг 37 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 06 дугаар сарын 20-ны өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 08 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Ирцдээ оръё, чуулганы хуралдаан эхлэх цаг 8 минут өнгөрч байна. Ирээгүй гишүүд Жуковын Алдаржавхлан, Наранцэцэгийн Алтаншагай, Цэндийн Баатархүү. Энэ Батын Батбаатар гишүүн түрүүн ордонд явж байсан энэ ирцдээ яагаад орохгүй яваад байна? Далайн Батбаяр, Ринчиндоржийн Батболд, Нацагдоржийн Батсүмбэрэл, Батмөнхийн Батцэцэг, Жадамбын Баясгалан, Буланы Бейсен, Шинэбаярын Бямбасүрэн, Сайнхүүгийн Ганбаатар, Амгаланбаатарын Ганбаатар, Гомбын Ганбаатар, Даваасамбуугийн Ганмаа, Гонгорын Дамдинням, Борхүүгийн Дэлгэрсайхан, Батбаярын Жаргалан, Дамдинсүрэнгийн Жаргалсайхан, Сүрэнжавын Лүндэг, Загджавын Мэндсайхан, Цагаанхүүгийн Мөнхбат, Пүрэвбаатарын Мөнхтулга, Мөнхтулга чинь гадаадад томилолттой явж байгаа. Цэндсүрэнгийн Мөнхтуяа, Бадрахын Найдалаа, Нанзадын Наранбаатар, Эрдэнэбилэгийн Одбаяр, Салдангийн Одонтуяа, Ухнаагийн Отгонбаяр, Бадамдоржийн Пунсалмаа, Буяагийн Тулга, Ганзоригийн Тэмүүлэн, Агваанлуvsангийн Ундраа гишүүн чөлөө авсан байгаа. Гончигдоржийн Уянгахишиг, Бадарчийн Хэрлэн, Дамдины Цогтбаатар, Саруулсайханы Цэнгүүн, Баттогтохын Чойжилсүрэн, Баттөмөрийн Энхбаяр, Жадамбын Энхбаяр, Сүхбаатарын Эрдэнэбат, Равжихын Эрдэнэбүрэн гэсэн сайд нар ирээгүй байх юм. Энэ чуулганы хуралдаан цагтаа эхэлдэг гэдэг дээр Улсын Их Хурлын гишүүд хариуцлагатай хандана шүү. Ойрд ингэж чуулган 10 минутаар хоцорч эхлээгүй байгаа. Дандаа цагтаа эхэлсэн. Баатаржавын Мөнхсоёл гишүүн ирцдээ орчихсон байсан уу?

Ирц 65 гишүүн бүртгэгдэж, 51,6 хувьтай болсон байна. 2025 оны хаврын ээлжит чуулганы 2025 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанаар 3 асуудал хэлэлцэнэ. Үдээс өмнөх хуралдаанаар 1 дүгээрт Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцэхийг, хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ. 2 дугаарт “Эрчим хүч 3 төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ. Үдээс хойших чуулганы нэгдсэн хуралдаанаар 14 цагаас Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29.1-д Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог, хэрэв тухайн төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол Зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож, нэгдсэн хуралдаанд

мэдээлнэ гэж заасан. Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар танилцуулъя.

1 дүгээрт Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын гишүүн Мэндбаярын Мандхай нарын 9 гишүүн 2025 оны 6 дугаар сарын 19-ний өдөр өргөн мэдүүлснийг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд;

2.Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын гишүүн Мэндбаярын Мандхай нарын 9 гишүүн 2025 оны 6 дугаар сарын 19-ний өдөр өргөн мэдүүлснийг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд;

3.Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг нарын 9 гишүүн 2025 оны 6 дугаар сарын 19-ний өдөр өргөн мэдүүлснийг Хууль зүйн байнгын хороонд;

4.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Бат-Өлзийн Бат-Эрдэнэ нарын 10 гишүүн 2025 оны 6 дугаар сарын 19-ний өдөр өргөн мэдүүлснийг Төрийн байгуулалтын байнгын хороонд;

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг Засгийн газраас 2025 оны 6 дугаар сарын 19-ний өдөр өргөн мэдүүлснийг Төсвийн байнгын хороонд;

6.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж нарын 5 гишүүн 2025 оны 6 дугаар сарын 19-ний өдөр өргөн мэдүүлснийг Төсвийн байнгын хороонд;

7.Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж нарын 4 гишүүн 2025 оны 6 дугаар сарын 19-ний өдөр өргөн мэдүүлснийг Төсвийн байнгын хороонд;

8.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Аюушийн Ариунзаяа нарын 9 гишүүн 2025 оны 6 дугаар сарын 19-ний өдөр өргөн мэдүүлснийг Төрийн байгуулалтын байнгын хороонд;

9.Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг ЗГ-аас 2025 оны 6 дугаар сарын 19-ний өдөр өргөн мэдүүлснийг Төсвийн байнгын хороонд тус тус хуваарилсан. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.06.19-ний өдөр өргөн

*мэдүүлсэн, яаралтай хэлэлцэх эсэх, Монгол Улсын Их Хурлын чуулганы
хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасны дагуу/*

Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д Засгийн газрын хуралдааны шийдвэрийг үндэслэн Ерөнхий сайд Үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд бичгээр хүсэлт тавьсан бол Их Хурлын дарга төслийг чуулганы хуралдаанаар яаралтай хэлэлцэх эсэхийг нэгдсэн хуралдаанд оруулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлүүлнэ гэж заасны дагуу ЗГ-аас 2025 оны 6 дугаар сарын 19-ний өдөр Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Төслийг Улсын Их Хурлын гишүүдэд танилцуулахаар тараасан байгаа. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Энхбаяр сайд хаана байна вэ?

Би өмнөөс нь танилцуулга хийчихье. Ер нь гаалийн албан татвараас чөлөөлсөн гурилын импорттой холбоотой асуудал өмнө нь Улсын Их Хурлаар орж ирж хэлэлцэгдээд, 64 гишүүний дэмжлэг авч чадаагүйгээр унаад буцсан байгаа. Тэгээд ЗГ-ын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Жадамбын Энхбаярт Улсын Их Хурлын даргын зүгээс үүрэг болгосон. Улсын Их Хурал дээр гаалийн албан татвараас гурилыг чөлөөлсөнтэй холбоотойгоор үүссэн нөхцөл байдал 2 талтай. Мэдээж дотоодын үйлдвэрлэгч нарт хүндрэл бэрхшээл учирч байна. Улаан буудай тариалдаг тариаланчдад тодорхой хэмжээний хүндрэлүүд үүсэж байна. Бүүр цаашлаад хэрэглэгчдэд энэ гурилын үнийн өсөлт гэдэг дарамт ирдэг учраас энэ дээр тодорхой хэмжээний зохицуулалтыг хий гэж үүрэг өгсөн. Үүнтэй холбогдуулаад Энхбаяр сайд гаалийн албан татвараас чөлөөлсөн шийдвэрийг бол зохицуулалт тохируулга хийж өргөн барихад бол Гаалийн албан татварын тухай хуульд хүндрэл байна. Тийм учраас энэ хуулиа өмнө нь өргөн барьснаараа хэвээр нь өргөн барья, харин дагаад авч хэрэгжүүлэх арга хэмжээний тогтоолыг Улсын Их Хурлаас баталж өгөөч гэдэг хүсэлт тавьсан.

Тийм учраас 2024 онд Гаалийн албан татвараас чөлөөлөх хууль батлагдаж байх үед дагаж гарсан тогтоолыг хүчингүй болсонд тооцоод, шинээр энэ хууль эргэж хүчингүй болж байгаатай холбогдуулан тогтоолын төсөл өргөн барьж батлуулъя гэдэг хүсэлтийг тавьсан. Тэгээд энэ тогтоолын төслийг нь хамт хүлээж авч хэлэлцэх нь зүйтэй гэж үзсэн учраас яаралтай горимоор хэлэлцэхийг нь өнөөдөр Улсын Их Хурлын чуулганд оруулж, яаралтайгаар хэлэлцэх эсэхийг шийдүүлэхээр өнөөдөр оруулж ирж байгаа юм.

Гишүүд санал хураалтад бэлтгэе. Бэлэн болсон уу? Тэгвэл ЗГ-аас яаралтайгаар өргөн барьсан Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг яаралтай горимоор хэлэлцэх эсэхийг дэмжих талаар санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад оролцсон гишүүдийн 48 буюу 68,6 хувиар яаралтай хэлэлцэх эсэх асуудлыг дэмжлээ. Хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг

нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

10.18 цаг

Хоёр. “Эрчим хүч-3 төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын Зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.05.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах, үргэлжлэв/

Дараагийн асуудалд оръё. Эрчим хүч 3 төслийг хэрэгжүүлэх Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ. Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдөр Хэрэг эрхлэх газрын 1563 дугаартай албан бичгээр Эрчим хүч 3 төслийг хэрэгжүүлэх Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын зээлийн хэлэлцээр дэх бичвэрийн алдааг залруулж ирүүлснийг гишүүдэд тараасан байна.

Одоо Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан үргэлжлүүлэн асуулт асууж, үг хэлнэ. Гишүүдийн нэр урьдчилан ирсэн байгаа. Дарааллын дагуу асуулт асууж, үг хэлнэ. Дарааллын дагуу Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууж, үг хэлье.

Ц.Идэрбат: Өглөөний мэнд хүргэе. Эрчим хүчний салбарын улс орны нөхцөл байдлыг хүн бүхэн мэдэж байгаа. Миний хувьд энэ зүүн бүстэй холбоотой эрчим хүчний найдвартай эх үүсвэр, аюулгүй байдал гэсэн 3 асуулт асуух төлөвлөж байна. 1 дүгээрт энэ 10 аймагт хэрэгжих энэ дулааны цахилгаан станцын асуудлууд ер нь дулааны станцын асуудлууд юу болж байгаа вэ? Тэгээд Солонгос компани нь дампуурсан гэсэн. Тэгээд тэр дампуурсан тэр хугацаанд Монгол Улс тэр зээлийнхээ хүүг төлөөд явж байгаа гэдэг нэг ийм нэг зүйлийг ярьсан. Тэгэхээр энэ манай зүүн бүсэд Хэнтий, Сүхбаатар аймгуудад 2 станц баригдаж байгаа юм. Тэгээд энэ ямар байдалтай байгаа вэ? 2 сарын өмнө ярихад 5 сарын 12 гэхэд ер нь асуудал нь шийдэгдээд, ажил цаашаа үргэлжилнэ гэсэн ийм зүйлийг чуулганы хуралдаан дээр танилцуулж байсан юм. Тэгэхээр би энийг асуух гэж байгаа юм?

2 дугаарт өнөөдрийн энэ хэлэлцээр бол эрчим хүчний дамжуулах шугам баригдах ийм зүйл. Ер нь манай зүүн бүсэд Багануур-Чойбалсан чиглэлийн 220квт-ын шугамын ажил хийгдэхэд зураг төсөв, бүх юм, судалгаа юмнууд нь хийгдчихсэн байгаа. Тэгэхээр Зүүн бүсэд эрчим хүчний эх үүсвэрийн дутагдал огт байхгүй. Сая энэ 50мвт өнгөрсөн онд Хүрэлсүх Ерөнхий сайд байхдаа хийсэн энэ станц бол зүүн бүсийн эх үүсвэрийг ойрын хэдэн жилдээ сайн хангахаар байгаа. Одоо бидний өмнө тулгамдаад байгаа асуудал энэ шугамууд байгаа. Мөн дээрээс нь Багануураас Чойбалсан чиглэлийн энэ 220квт-ын шугамын асуудал ямар түвшинд явж байгаа вэ гэдгийг асуух байна?

3 дугаарт энэ Дорнод аймгаас Дорнодын цахилгаан станцаас бидэнд асуулт тавиад байгаа. Ялангуяа ирэх өвөл станцын хэвийн үйл ажиллагааг хангахад энэ нүүрсний үнийн ойлголцлууд байна. Эрчим хүчний зохицуулах зөвлөл дээр энэ үнийн асуудлыг яаж үзэж байгаа вэ? Уурхай, станц хоёрын хооронд үнийн 2 ч санал дээр зөрөөтэй байдалтай байгаа юм байна. Тэгэхээр энэ дээр Эрчим хүчний

зохицуулах зөвлөл ямархуу байр суурь барьж байгаа вэ гэсэн үндсэн 3 асуулт тодруулъя гэж бодож байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье, 4 дүгээр индэр.

О.Хуягцогт: Идэрбат гишүүний асуултад хариулъя. Эрчим хүчний яамнаас Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Хуягцогт. Багануур, Өндөрхаан, Чойбалсан чиглэлийн 220квт-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг барьж байгуулах хэрэгцээ байгаа. Энэ ЗГ-ын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт туссан. Энэ шугамуудыг эрэмбэлж, улсын хөгжлийн төлөвлөгөө ирэх онуудын төлөвлөлтөд оруулах чиглэлээр яамнаас Эрчим хүчний яамнаас саналаа Эдийн засгийн хөгжлийн яам болон Сангийн яам, бусад энэ донор байгууллагуудад тавьж, эх үүсвэрийг шийдвэрлэх чиглэлээр ажиллаж байна.

10 аймгийн дулааны станц төсөл 2018 онд зээлийн хэлэлцээр байгуулаад ингээд хэрэгжсэн. Гүйцэтгэгч компаниас болоод үүссэн хүндрэлийн талаар өмнөх хуралдаан дээр танилцуулагдсан. Ингээд 6 сардаа багтаж энэ Бүгд найрамдах солонгос улсад явагдаж байгаа шүүхийн шийдвэр гармагц тэндээс хамааран энэ гүйцэтгэгчийг солих, дараагийн гүйцэтгэгчийг сонгож, шаардлагатай эх үүсвэрийг тодорхойлж, төслийг хэрэгжүүлэх чиглэлээр ажлууд зохион байгуулж байна. Энэ процессоос болоод 6 сарын, 6 сараас нэг жилийн хугацаатай хоцрогдол үүссэн. Анх 2026 онд багтаан ашиглалтад оруулахаар төлөвлөж байсан.

3 дахь асуултын хувьд Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨК дээр нүүрсний асуудал тулгамдсан ийм хүндрэлтэй асуудал үүсэж байгаа. Энэ Адуун чулууны нүүрсний орд дээр үйл ажиллагаа явж байгаа уурхайнууд дээр үнийн асуудлыг нэлээн огцом өсгөх ийм саналууд ирээд, энэ нь Эрчим хүчний зохицуулах хороогоор хянагдаж, шийдвэрлэгдэх дээр хугацаа орж байгаа. Үнийн энэ өсөлтийг хэрхэн шийдвэрлэх вэ гэдэг дээр шийдэл гарвал энэ өвөлжилтийн бэлтгэл хангах хүрээнд Эрчим хүчний сайдаас тодорхой чиглэлүүд өгөөд, Эрчим хүчний зохицуулах хороо энэ компанийн зүгээс энэ уурхайнуудтай хэлэлцээр хийж байна.

Д.Амарбаясгалан: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн тодруулж асууя.

Ц.Идэрбат: Тийм, энэ 10 аймгийн энэ цахилгаан станцыг барих ийм том төсөл дээр шалгарсан компани нь 2 жил болоод дампуурчихдаг. Тэгээд ямар учир шалтгаанаар ийм найдваргүй компани ингээд шалгаруулчихсан байдаг юм бэ? Энэ дээр ер нь Монголын тал манай тал ер нь ямар үүрэг хариуцлага хүлээх юм бэ 1 дүгээрт?

2 дугаарт та нар Эрчим хүчний зохицуулах хороо хэрвээ энэ үнэ ханшныхаа асуудлыг шийдэх гэж байгаа бол энэ төсөв хөрөнгө батлахаас өмнө тодорхой шийдэлд хүрээрэй. Тэгээд баталчихсаны дараа эсвэл төсвийн процесс явчихсаны дараа үнэ ханш хөдөлдөг, уурхай үнээ нэмдэг, дагаад нөгөө хэрэглэгч нарын үнэ нэмэгдэх гээд байдаг, тэгээд төсөв дээр дарамт үүсдэг. Ингээд өрийн гинжин урвал үүсдэг шүү. Тэгэхээр өнөөдөр Эрчим хүчний зохицуулах хороо ингээд шийднэ гэж ярихаасаа илүүтэйгээр шийдэж байгаа процесс нь хурдан явах тал дээр би Эрчим хүчний яамыг анхаараасай гэж ингэж үзэж байгаа. Тэгэхээр тэр 10, бүхэл бүтэн 10 аймгийн станцыг барих тэр.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмж хариулт өгье, 4 дүгээр индэр.

О.Хуягцогт: Нэмэлт хариулт өгье. 10 аймгийн дулааны станцын зээл бол БНСУ-ын зээл Эксим банкны. Энэ зээлийн нэг нөхцөл нь тендерийг зөвхөн Солонгос улсын гүйцэтгэгч компаниудын дунд шалгаруулна гэдэг нөхцөлтэй байсан. Ингээд харамсалтай энэ тендер 21 онд зарлагдаад, 22 онд гүйцэтгэгч шалгарсан. Энэ шалгарсан гүйцэтгэгч маань ийм чадахгүй компани байсан дээр бид Солонгосын талд асуудал тавьж байгаа.

Юуны хувьд нүүрсний үнийн хувьд тэнд Дорнод бүсийн эрчим хүчний систем компанийн хувьд тодорхой үйл ажиллагаа тогтвортой явуулж байгаа нэг компани байгаа тэр компаниас хамааралтай ийм асуудал байгаа учраас хэлэлцээр нэлээн хүнд байна. Тэгэхдээ энэ бол төсөвт шууд нөлөөлөхгүй. Тариф, үнэ тарифтай холбоотой нөлөөлөх учраас энэ Эрчим хүчний зохицуулах хороо энэ эрчим хүч.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууя, үг хэлье.

А.Ариунзаяа: Цаг хугацааны ач холбогдлын хувьд миний үг хэр байх юм бол? Улс төрийн гацаа нөхцөл байдал үүссэн үед яг энэ үг хэлэх эрхээ авч байсан. Засгийн газар шинээр бүрэлдэхүүн үүссэн Засгийн газар бүтэц, бүрэлдэхүүнд ажлуудаа цаг хугацаанд нь яаралтай шуурхай хийдэг байхыг даатгамаар байна. Энэ Монгол Улс Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банкны хоорондын Эрчим хүч 3 төслийн зээлийн хэлэлцээрийг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн байнгын хороо, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороогоор 25 оны 1 сард оруулж хэлэлцсэн байгаа юм. Түүгээрээ хэлэлцээд зөвшөөрлөө өгөөд, 25 оны 2 сард Ерөнхий сайд гарын үсгээ зурж, энэхүү хэлэлцээрийг байгуулсан.

Хэлэлцээр хүчин төгөлдөр болох эцсийн хугацаа 180 хоног гэж байгаа юм. Тэгэхээр эцсийн хугацаа нь 8 сард, гарын үсэг 2 сард зурсан 8 сард эцсийн байдлаар хүчин төгөлдөр болох ёстой. Одоо амжихгүй бол энэ зээлийн хэлэлцээр хүчингүй болно л гэсэн үг. Тэгээд яг энэ тухайн үедээ бэлтгэгдэж байсан Монгол Улсад өгч байгаа итгэл дээр нь суурилсан энэ хүү, хэмжээ, зээлийн хэмжээ, хүүгийн хэмжээ яг ийм хэмжээгээрээ байж чадах уу, үгүй юү гэдэгт эргэлзэж байгаа. Ийм учраас энэ боломжоо ашиглаад бид шуурхай энийг соёрхон батлах ёстой. Тэгж байж Монгол Улсын эрх ашиг хангагдана.

Бид бас нэг энэ улс төрийн гацаанаас болж энэ Казахстаны хэлэлцээрийг унагаасан, соёрхон батлахыг унагаасан. Энэ маш их эрсдэлийг дагуулж байгаа. Энийг Аубакир сайд шуурхай яаралтай оруулж ирэх ёстой. Энэ бол Казахстан улсад ажиллаж байгаа Монгол иргэд тэнд тэтгэврээ тогтоолгох эрхийн тухай асуудал. Бид өнөөдөр хойшлуулах тусам өнөөдөр тэтгэвэртээ гарах байсан иргэний асуудлыг бид хохироож байгаа шүү. Ийм учраас үүнийг Аубакир сайд яаралтай оруулж ирэх хэрэгцээ шаардлага байгаа юм. Бид 2018 оноос хойш Монгол Улс Казахстанас 17 удаагийн хэлэлцээр хийж, энэхүү асуудлыг зөвшөөрч өгөөч гэдэг асуудлаар санал тавьж ажилласан. Тэгээд улс төрөөс болж энэхүү хэлэлцээрийг соёрхон батлахыг унагаасан Улсын Их Хурлын гишүүд өнөөдөр тэтгэврээ тогтоолгож чадахгүй байгаа тэр иргэдийн хохирлыг барагдуулах уу, үгүй шүү дээ. Казахстан бол 98 оноос хойш хуримтлалын тогтолцоонд шилжсэн байгаа, энэ бол бодит мөнгөний асуудал ярьж байгаа бид. Тэгэхээр эдгээр иргэний аж амьдралтай холбоотой асуудал дээр улс төрөөс ангид байж, иргэнийхээ төлөө Монгол төр ажиллах ёстой юм шүү. Аубакир гишүүн сайд нэн яаралтай энэ соёрхон батлах асуудлыг оруулж ир. Түүнийг

яаралтай батлах хэрэгтэй. Дипломат шугамаар хүргэгдсэнээс хойш дахиад 2 тал хоёулаа соёрхон баталсны дараа дипломат шуудангаар хүргэгдсэнээс хойш 2 сарын дараа үйлчилж эхэлнэ. Цаг, минут, өдөр болгон үнэ цэнтэй байгаа шүү гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн асуулт асууж, үг хэлье.

Д.Пүрэвдаваа: Өглөөний мэнд хүргэе. 2 асуулт байна. 1 дүгээрт ажлын хэсгээс эдийн засгийн бөгөөд санхүүгийн өгөөжийг хэрхэн тооцсон юм бэ? Ялангуяа энэ Багануур, Чойрын чиглэл 188км гээд. Энэ нь эдийн засгийн хувьд зах зээлийн үнээс өндөр байна уу, эсвэл яг дундаж үнэ байна уу, энэ үнийнхээ тооцооллыг олон нийтэд ил болгосон юм уу? Хөндлөнгийн экспертүүдээс зөвлөгөө, чиглэл авагдсан юм уу гэдгийг нэг асуумаар байна.

2 дугаарт тэр нэг хариуцлагын асуудал. Нэг бичвэрийн алдаа гарсан. Түүн дээр хэн гэдэг хүн хариуцлага үүрсэн юм бэ? Тэрний талаар тодорхой мэдээлэл авъя. Тэгээд тодруулъя.

Д.Амарбаясгалан: Баттогтохын Чойжилсүрэн сайд хариулт өгье.

Б.Чойжилсүрэн: Пүрэвдаваа гишүүний асуултад хариулъя. Үнийнхээ тооцооллын бид Дэлхийн банк, Олон улсын санхүүгийн корпорацтай хамтраад хийдэг, тэр жишгээрээ л явж байгаа. Энэ зээлийн хэлэлцээр Улсын Их Хурал соёрхон батлагдсаны дараа олон улсын нээлттэй тендер зарлагдана. Тэгэхээр зах зээлийн үнэ яг тэнд өөрөө тогтоно гэсэн үг. Бид нээлттэй зарлах ийм тооцоололтой байгаа.

Бичвэрийн хувьд Сангийн яам дээрээс орчуулгын хувьд тодорхой алдаа гараад энийгээ залруулсан байгаа.

Д.Амарбаясгалан: Хассуурийн Ганхуяг гишүүн алга байна. Наранцэцэгийн Алтаншагай гишүүн асуулт асууя, үг хэлье.

Н.Алтаншагай: Гишүүддээ өдрийн мэнд хүргэе. Хэдэн тодруулах зүйл, асуух зүйл байна. Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банкны хооронд Эрчим хүчний 3 төсөл томоохон зээл авах гэж байна. Тэгээд энэ төсөл хэрэгжсэнээрээ яг Улаанбаатар хотод үр өгөөж нь ирэх үү 1 дүгээрт?

2 дугаарт энэ гэр хорооллын нөхцөл байдал маш хүнд байгаа шүү дээ, эрчим хүчний уналттай, өргөтгөл шинэчлэл бага хийсэн. Ялангуяа энэ Улаанбаатар хот тойрсон тэлсэн энэ суурьшлын бүсийн гэр хорооллын эрчим хүчний уналт маш их байгаа. 2000 он гараад Улаанбаатар хотод ирэхэд байсан нөхцөл байдал яг л хэвээрээ байгаа, 25 жилийн дараа өвөлдөө нэг лааны гэрэл шиг л юм байгаа шүү дээ гэр хорооллын гэрэл. Плитк дээрээ, халуун тогоон дээрээ хоол унд хийж болдоггүй түүхийрдэг. Өнөөдөр яг байгаа бодит нөхцөл байдал маань л энэ. Шинээр суурьшлын бүсэд үүссэн гэр хорооллын маань иргэд маань энэ цахилгаан эрчим хүчээ авахдаа айлын шон дээрээс, айлын тогны тэр утсан дээрээс ингээд залгаад л авч байгаа шүү дээ. Яг аалзны тор шиг. Энэ дээр яг тодорхой шийдлүүд гаргаж, энийг нэг талд нь шийдэхгүй бол маш их эрсдэл үүсдэг дагаад. Хүүхдүүд тогонд цохиулах, ил задгай утас ихтэй болчихсон байдаг. Хашаа хооронд, гудамж хооронд

татчихсан шугам машин явсаар байгаад шалбарчихсан кабелиуд нь ийм эрсдэлтэй байдал үүсчихсэн байдаг.

Энэ дээр нэг дорвитойхон шинэчлэлт хийж, яг энэ том зээл авч байгаа энэ эрчим хүчний реформ хийгдэж байгаа энэ үед бодит үр нөлөөлөл үзэж, энэ гэр хорооллын маань иргэд энэ өвлийн хүйтэнд мөн зарим нь хувийн орон сууцуудаа цахилгаанаар халаадаг болсон байгаа. Тэгээд эрчим хүчний дутагдалтай гээд өвөл бол гэр хороололд маш хүндрэлтэй байдаг. Мөн энэ өнгөрсөн өвөл маш их гэр хороололд хязгаарлалтуудыг хийлээ шүү дээ. Энэнээс ангижирч чадах уу гэдгийг асууж байна.

Д.Амарбаясгалан: Баттогтохын Чойжилсүрэн сайд.

Б.Чойжилсүрэн: Алтаншагай гишүүний асуултад хариулъя. Яг энэ шугам бол Улаанбаатар хотын цахилгаан хангамжийг өргөтгөх тал дээр шууд нөлөө байхгүй. Эсрэгээрээ энэ маань Багануураас Чойр луу 220 киловольтын хос цахилгаан дамжуулах шугам баригдана. Одоо Европын сэргээн босголт, хөгжлийн банкнаас бид Чойроос Сайншанд руу 220 киловольтын цахилгаан дамжуулах агаарын шугам бариад, тендер нь зарлагдаад ойрын өдрүүдэд ялагч тодорхой болох байх. Түүний дараа Сайншандаас Цагаан суварга руу дахиад 220 киловольтын цахилгаан дамжуулах агаарын шугамыг Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк 2-т санхүүжүүлээч гээд ийм хүсэлт тавьчихсан байгаа. Ойрын хугацаанд жилүүдэд шийдэгдэх болов уу гэсэн ийм найдлагатай байгаа юм. Гол нь энэ Оюу толгой төслийг бид Монголын эрчим хүчний системээс хангахад 2 эх үүсвэр 2 талын эх үүсвэр шаардлагатай. Нэг талын эх үүсвэрийг энэ талаас ингэж хангая гэсэн ийм тооцоололтой авч байгаа зээл гэдгийг хэлье.

2 дугаарт Улаанбаатар хотын цахилгаан хангамжийг 2035 он хүртэл өргөжүүлэхэд цахилгаан дамжуулах сүлжээ, цахилгаан түгээх сүлжээний өргөтгөл хийхэд 2 тэрбум орчим америк долларын хэрэгцээ байна гэсэн ийм судалгааны дүн гарсан. Эрчим хүчний яам, нийслэл Улаанбаатар хотын Засаг даргын Тамгын газартай хамтарсан ажлын хэсэг байгуулаад явж байна. Энэ 2 тэрбум доллароос эхний ээлжид 900 орчим сая доллар Монголын тал 100 сая долларыг гаргаад 1 тэрбумын санхүүжилтийг Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк санхүүжүүлэх бололцоотой гэдгээ хэлээд, саяхан одоогоос 1 сарын өмнө Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банкны төлөөлөгчид Монгол Улсад ирж уулзаад, холбогдох сайдууд, Ерөнхий сайдтай уулзаад явсан. Энэ жилдээ багтаагаад чадвал энэ хэлэлцээр байгуулагдах болов уу гэсэн ийм тооцоололтой яваа.

Түүнээс гадна Чайна Эксим банкттай 249 орчим сая долларын санхүүжилтийн эх үүсвэрийг санхүүжүүлэх бололцоо байна уу гэдэг хүсэлтийг бид явуулсан. Бололцоотой гэдэг зүйл яриад, бид техник, эдийн засгийн үндэслэл, төслийн бэлтгэл ажлуудыг хийгээд явж байгаа. Ийм байна. 3 дахь эх үүсвэр Дэлхийн Банк 2026, 2027 онуудынхаа Монгол Улсад олгох зээлийнхээ орон зайнд 200 орчим сая долларыг Улаанбаатар хотын дэд бүтэц, энэ цахилгаан хангамжийг үр шийдэхэд 200 орчим сая долларыг санхүүжүүлэх бололцоотой гэсэн ийм урьдчилсан тохиролцоотой. Энэ төслийг цаашаа хөгжүүлэх ийм бэлтгэл ажлууд хийгээд явж байгаа ийм байдалтай байгаа юм.

Таны яриад байгаа Улаанбаатар хотын гэр хороололд үнэндээ хүндрэлүүд бий. Сүүлийн 30 жил орчим Улаанбаатар хот маань төлөвлөлт муутай явснаас

шалтгаалаад нэг хэрэглэгчийн нэг тоолуурын нэг гэрээгээр 2, 3 хэрэглэгч авдаг, тохож авдаг ийм байдлууд явж байгаа. Манай эрчим хүчний салбарын хяналтын байцаагч яваад байгаа боловч заримдаа энэ ажлыг дийлж чадахгүй байгаа. Шаардлага тавиад засуулдаг, удахгүй байцаагч явахаар буцаагаад хуучин байдалдаа ордог ийм муур хулгана болсон тоглоом бол нууцгүй үнэнийг хэлэхэд явж байгаа гэдгийг хэлье. Ийм байдалтай байна.

Д.Амарбаясгалан: Алтаншагай гишүүн тодруулж асууя.

Н.Алтаншагай: Нөхцөл байдал яг энэ хэвээрээ л үргэлжилнэ л гэж ойлгогдож байна. Тэгээд 2025-аас 26 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд яг энэ гэр хороолол дээр яг онцгойлон анхаарсан ийм зүйл байна уу? Одоо бол яг энэ чигээрээ орвол ингээд л энэ өвөл маш хүндрэлтэй. Тэгээд эрчим хүчний үнэ нэмэгдсэн иргэд бүр бухимдал нь дээд цэгтэй тулчихсан ийм байгаа. Ядаж энэ авч байгаа энэ тогныхоо эрчим хүчнийхээ эх үүсвэрийг найдвартай авдаг баймаар байгаа юм. Тэгэхээр энэ дээр яг өнөөдөр хийгдэж байгаа бэлтгэл ажлын хүрээнд хийгдэж байгаа, өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд хийгдэж байгаа ажлыг та танилцуулаач, мэдээлэл өгөөч иргэдэд.

Д.Амарбаясгалан: Чойжилсүрэн сайд нэмж хариулъя.

Б.Чойжилсүрэн: Алтаншагай гишүүний асуултад хариулъя. Энэ өнгөрсөн 2024 оны 11 сарын 01-ний өдрөөс эхлээд цахилгаан эрчим хүчний үнийг өртөгт нь ойртуулах, өртөгтөө хүрээгүй шүү. Ойртуулах арга хэмжээ авсан. Энэ нэмэгдлийн хүрээнд 2025 ондоо жишээлбэл 546 орчим тэрбум төгрөг нэмэлтээр сар бүрд хуваагдаад ороод ирэх ийм тооцоолол бий. Энэний яаж зарцуулсан талаар гишүүд олон удаа асууж байгаа учраас энэ микрофон авснаа ашиглаад тайлагначихъя гэж бодож байна.

220 орчим тэрбум төгрөгөөр 2023, 2024, 2025 онуудад эрчим хүчний салбарын ажилтнуудын цалинг нэмэгдүүлэхгүй бол манай салбараас ажил хаяж явах, ажлаа өгөх тохиолдол асар өндөр нэмэгдсэн учраас 220 орчим тэрбум төгрөг цалингийн нэмэгдэлд зарцуулагдана. 110 орчим тэрбум төгрөг энэ нүүрсний үнэ.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмэлт минут өгье.

Б.Чойжилсүрэн: Нүүрсний уурхайнууд дээр байгаа нүүрс авч худалдан авч байгаа эрчим хүчний нүүрсний үнийг нэмэгдүүлэхэд зарцуулсан. Эрчим хүчний компаниудын хувьд 77 тэрбум төгрөгөөр 2025-аас 26 оны өвлийн өвөлжилтийн бэлтгэл ажилд нэмэлт эх үүсвэрээр энийг хийж байгаа юм. Өнгөрсөн 2023 он, 24 оныг дамнуулаад би Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороог даргалж байх үедээ танай Сонгинохайрхан дүүргийн 8 хороонд энэ гэр бүлийн, гэр хорооллын 04-ийн шугамын шинэчлэлийн өргөтгөлийн ажлыг хийсэн иймэрхүү байдалтай байна. Хийх ажлууд их байгаа. Харамсалтай нь санхүүгийнхээ боломж эх үүсвэртээ хязгаарлагдаад иймэрхүү байдалтай удаашралтай явж байгаа гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлдье. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Хурууныхаа хээг уншуулъя.

Хаврын чуулган өндөрлөх хугацаа ойртож байгаатай холбоотойгоор өнөөдөр Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөл хуралдаж, ирэх 3 долоо хугацаанд нэлээн шахуу олон хуулийн төсөл хэлэлцэхээр болсон. Тэгээд энэ хуваарийг гаргана. Үндсэндээ хаврын чуулган завсарлахаас өмнө хэлэлцэж батлах, хэлэлцэх эсэхийг шийдвэрлэх шаардлагатай 30 орчим хуулийн төсөл, тогтоолын төслүүд хүлээгдэж байгаа. Тэгэхээр өнөөдөр Даргын дэргэдэх зөвлөлийг 11 цаг 30 минутаас хуралдуулна. Манай Их хурлын Тамгын газар хурлын бэлтгэл ажлыг хангаж байх хэрэгтэй байна. Даргын дэргэдэх зөвлөлийн гишүүд хуралдаа бүрэн оролцож, хаврын чуулган завсарлахаас өмнө хэлэлцэж батлах хуулиудын хуваарийг гаргаж, цэгцлэхээр байгаа гэдгийг энэ ташрамд хэлье.

Мөн Засгийн газраас шинээр байгуулагдсантай холбоотойгоор хэд хэдэн хуулийн төслүүдийг яаралтай горимоор хэлэлцүүлэх асуудал байна. Мөн дээрээс нь наадмаасаа өмнө амжуулж төсвийн тодотгол өргөн барьж, хэлэлцүүлэх асуудлаар Ерөнхий сайд санал тавьж, хүсэлт тавьж байгаа. Эдгээр асуудлуудыг өнөөдөр бид Даргын дэргэдэх зөвлөл дээрээ ярилцаж, ямар цаг хугацаанд, хэрхэн, ямар өөрчлөлтүүд хийх вэ гэдэг асуудлыг ярилцах ийм нөхцөл байгаа гэдгийг гишүүддээ хэлье. Энэ соёрхон батлах асуудал 64 гишүүнээр батлагддаг. Гишүүд танхимдаа орж ирж, санал хураалтдаа оролцож, асуудлаа шийдвэрлэе. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Хуруугаа уншуулаарай, хээгээ хурууныхаа хээг уншуулаарай.

Нэг зарын шинж чанартай зүйл хэлээдэхье. Улсын Их Хурал Нээлттэй парламент хөтөлбөрийг өнгөрсөн намраас эхлээд хэрэгжүүлж эхэлсэн. Өнгөрсөн өвөл парламентад 100 оюутан, төгсөх ангийн оюутнууд цалинтай дадлагажих хөтөлбөрт хамрагдсан. Эдгээр оюутнууд үндсэндээ хууль, эрх зүй, эдийн засаг, бусад салбарын төлөөллүүдтэй төлөөллүүд оролцож ажилласан байгаа. Ингээд 100 оюутан дадлага хийсэнтэй холбогдуулаад оюутнуудын дунд дараа дараачийн сонгон шалгаруулалт, идэвхтэй ажиллах нөхцөл боломж, ажилласан байдалд нь Улсын Их Хурлын гишүүд, ажлын хэсгээс өгсөн үнэлгээ зэргийг харгалзан үзээд 100 оюутнаас өнөөдрийн байдлаар 9 оюутныг, төгсөж байгаа 9 оюутныг сонгож авч парламентын Тамгын газарт ажиллах нөхцөл боломжоор хангаж өгсөн. Ингээд үндсэндээ сая сургуулиа төгссөн 9 оюутан өөрсдийн идэвх чармайлтын үр дүнгээр парламентын Улсын Их Хурлын Тамгын газарт ажиллаж эхэлсэн гэдгийг та бүхэндээ дуулгахад таатай байна.

2 дахь хөтөлбөрийг нь манай Саранчулуун гишүүн ахалж, Ариунзаяа, Номинчимэг, Жаргалан зэрэг олон гишүүд оролцоод ахмадын, Рэгдэл гишүүн, Энхтуяа гишүүн ингээд гишүүд оролцож ажиллаад, ахмадуудын дунд парламентад энэ зуны туршид Улсын Их Хурлын гишүүдэд зөвлөх зорилгоор тодорхой хугацаанд ажиллах боломжийг хангаж байгаа. Ингээд нээлттэй зар тавьж, цахимаар бүртгэсний үндсэн дээр 120 ахмад өнөөдрийн байдлаар бүртгэгдээд, шалгараад байж байна. Тэгэхээр Улсын Их Хурлын гишүүд тэр шалгарсан байгаа 120 ахмадаас, ахмадын танилцуулгатай танилцаад аль ахмадтай хамтарч ажиллах сонголтоо хийх ёстой болж байгаа. Тэгэхээр Саранчулуун гишүүн зар тавьсан. Саранчулуун гишүүний тавьсан зарын дагуу линкээр орж аль ахмадтай хамтарч ажиллахыгаа сонголтоо өнөөдөр Улсын Их Хурлын гишүүд хийж өгөөрэй гэдгийг та бүхэндээ хэлье.

Ингээд үндсэндээ парламент Улсын Их Хурлын дэд дарга Булгантуяа ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд парламентын мэтгэлцээнийг

зохион байгуулсан. Тэдгээр сурагчдаар дамжуулж орон нутаг, 21 аймаг, 330 сумд парламентын үйл ажиллагааг сурталчлан таниулах, сурагч, хүүхэд багачуудын идэвхийг сайжруулах чиглэлээр ажлыг зохион байгуулаад ажиллаж байгаа гэдгийг та бүхэндээ хэлье.

Санал хураалтдаа оръё. Гишүүд санал хураалтдаа бэлд, хурууныхаа хээг уншуул. Ирц бүртгэлийн санал хураалт явуулъя. Санал хураалт. Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлдсэн байна. Санал хураалт. Байнгын хорооны саналаар “Эрчим хүч 3 төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын зээлийн хэлэлцээрийг соёрхон баталъя гэсэн саналын томьёолоор санал хураалт явуулна. Санал хураалт. 66 гишүүн дэмжиж, нийт гишүүдийн олонх нь дэмжлээ. Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн тул Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг эцэслэн баталсанд тооцлоо. Улсын Их Хурлын гишүүд, ажлын хэсэгт талархал дэвшүүлье.

10.49 цаг

Ингээд үдээс өмнөх чуулганы нэгдсэн хуралдаан өндөрлөлөө. 11 цаг 30 минутаас Даргын дэргэдэх зөвлөлийн хуралтай. 14 цагт чухал асуудлууд орох учраас гишүүд бүрэн ирцтэй байхыг хүсэж байна.

*2025 оны 06 дугаар сарын 20, Баасан гараг,
Төрийн ордон “Их хуралдай” танхим
14 цаг 05 минут.*

ҮДЭЭС ХОЙШИХ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Үдээс хойших чуулганы нэгдсэн хуралдаанаа эхлүүлье. Гишүүд танхимдаа цуглая. Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы 2025 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн үдээс хойших нэгдсэн хуралдаан эхэллээ. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29.1-д Улсын Их Хурлын дарга, хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог, хэрэв тухайн төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол Зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож нэгдсэн хуралдаанд мэдээлнэ гэж заасан.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар танилцуулъя. 1.Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хууль, тогтоолын төслүүдийг Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар 2025 оны 6 сарын 20-ны өдөр өргөн мэдүүлснийг Төрийн байгуулалтын байнгын хороонд хуваарилсан.

Гурав.Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар 2025.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, яаралтай хэлэлцэх эсэх, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасны дагуу/

Хэлэлцэх асуудалдаа оръё. Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ. Санал хураалт явуулна. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д Засгийн газрын хуралдааны шийдвэрийг үндэслэн Ерөнхий сайд Үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд бичгээр хүсэлт тавьсан бол Улсын Их Хурлын дарга төслийг чуулганаар яаралтай хэлэлцэх эсэхийг нэгдсэн хуралдаанд оруулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлүүлнэ гэж заасны дагуу Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар 2025 оны 6 дугаар сарын 20-ны өдөр Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хууль, тогтоолын төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Төслийг Улсын Их Хурлын гишүүдэд одоо тарааж өгнө. Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэх, хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулахаар байгаа. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалт. Ирц бүртгэлийн санал хураалт явуулъя. Гишүүд суудалдаа сууя. Батлут сайд суудалдаа сууя. Ирц бүртгэлийн санал хураалт. Бүртгэлд ороогүй гишүүн байна уу? Хосбаяр гишүүн, Лүндэг гишүүн. Саналын томъёоллыг уншиж танилцуулъя.

Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна. Санал хураалт. 52 гишүүн буюу 54,7 хувиар санал дэмжигдлээ. Хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг ТББХ-нд шилжүүллээ.

14.17 цаг

Дөрөв.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.05.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Дараагийн асуудалд оръё. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна. Хууль санаачлагчийн илтгэлийг ЗГ-ын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Сайнбуянгийн Амарсайхан танилцуулна. Индэрт урьж байна.

С.Амарсайхан: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-ын 2024-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд туссан үндсэн зорилтын хүрээнд хууль, эрх зүйн шинэчлэл, ялангуяа стандартын тогтолцоо, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэл зэрэг тогтвортой хөгжил, ард иргэдийн амьдралын

суурь хэрэглээний аюулгүй байдлыг шууд хангахтай холбоотой асуудалд дорвитой шинэчлэл хийх зайлшгүй шаардлага үндэслэлтэйгээр бий болж байна. ЗГ-аас дэвшүүлсэн нэг улс нэгдсэн стандарт, шинэ хөгжил шинэ боломж зорилтын гол цөм нь дотоодын үйлдвэрлэлийн өсөлтийг дэмжих, экспортын өрсөлдөх чадавхыг нэмэгдүүлэх, иргэдийн аюулгүй байдал, чанартай хэрэглээг хангах явдал юм. Үүний тулд бид бодлогын суурь тогтолцоог шинэ түвшинд гаргаж, өөрчлөлт шинэчлэлтийг энэ салбарт зайлшгүй хийх нөхцөлтэй нүүр тулж байна. Монгол Улсад мөрдөж буй нийт стандарт, тохирлын үнэлгээний эрх зүйн орчныг шинэчлэн боловсронгуй болгох хүрээнд өнөөдөр уг хуулийн шинэчилсэн найруулгын төслийг та бүхэнд танилцуулж байна.

Эрхэм гишүүд ээ, бид 2017 онд батлагдсан хуульд стандартыг сонгон хэрэглэх зарчмыг баримталж ирсэн. Гэвч амьдрал дээр энэхүү зохицуулалт нь иргэн, аж ахуйн нэгж төрийн хяналт зэрэг давхардсан олон ойлгомжгүй нөхцөл байдлыг иргэд, нийгмийн дунд бий болгож, ойлголтын зөрүү үүсгэж, хэрэгжилтийн тодорхойгүй байдал бий болгож, улмаар хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд бодит эрсдэл үүсгэсээр байна. Монгол Улсын Шадар сайдын Ажлын алба нь Стандарт, хэмжил зүйн газраас 2020 онд хийсэн судалгаагаар Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 6733 стандарт байгаа бөгөөд үүний 80 орчим хувь нь хэрэгжих боломжгүй, зайлшгүй шинэчлэх шаардлагатай, нийгмийн бүхий л салбарт өөрчлөн анхаарах зайлшгүй асуудал байна гэдэг нь тодорхой болсон.

Үүнээс зөвхөн 20 орчим хувь нь шинэчлэгдсэн нь илэрхий ч болсон. Жишээ нь эрүүл мэндийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа нийт 400 орчим лабораториос ердөө 35 нь стандартын шаардлага хангасан олон улсын итгэмжлэлийн нөхцөл байдлыг хангасан, хүнсний лабораторийн 35 хувь нь л итгэмжлэгдсэн байна. Хяналт баталгаажуулалтын тогтолцоо нэг мөр биш, олон эх сурвалжтай, давхардсан бүтэцтэй, эрх зүйн зөрчилтэй хэвээр байна. Үүнээс гадна эрүүл мэндийн салбарт 686 стандарт хэрэгжиж байгаа бол үүний 479 нь шинэчлэх шаардлагатай бөгөөд эмчилгээ оношилгооны чиглэлээр эмнэлгийн аюулгүй байдал, иргэдийн үйлчилгээний чанарыг хангах боломж нөхцөл бүрдээгүй байна. Барилгын 642 стандартаас чанар, аюулгүй байдал, норм дүрэмтэй холбоотой Барилга, хот байгуулалт, Байгаль орчин орон сууцын яам яаралтай шинэчлэх, үйлчлүүлэгч, хэрэглэгчийн аюулгүй байдлыг хангах зайлшгүй шинэчлэх 400 стандарт байна. Эрүүл мэндийн яам энэ батлагдаж шинэчлэгдээгүй 479 стандартаа нэн яаралтай шинэчлэн боловсруулах ажлыг эхлүүлэх шаардлагатай зэрэг асуудлууд байна. Эдгээр асуудлууд нь эрүүл мэнд, барилга, хүнс, аялал жуулчлал зэрэг стратегийн салбарууд олон улсын хөгжил дэвшлээс хэт хоцрох, өрсөлдөх чадвар, үндэсний үйлдвэрлэлийн итгэлцлийн суурь алдагдаж буй зэрэг олон асуудлуудыг давхар дагуулж байна.

Ийм нөхцөлд бид өнөөдрийн байдлыг өөрчлөх суурь шинэчлэл хийх, олон улсын түвшний тогтолцоонд шилжих шаардлагатай хэмээн үзэж, хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дараах зарчимд тулгуурлан боловсруулсан болно. 1 дүгээрт хуулийн шинэчилсэн найруулгын зорилго, үзэл баримтлал. Энэхүү хуулийн төсөл нь стандартыг сонголт биш заавал мөрдөх, сонгосон бол хэрэгжүүлдэг байх, чанар, стандарт, аюулгүй байдлыг хангадаг байх, үйлдвэрлэгч, бүтээгдэхүүн нийлүүлэгчдийн хариуцлага, хэрэглэгчийн аюулгүй байдлын асуудлаар хяналт, зохицуулалт, итгэмжлэлийн тогтолцоог мөн боловсронгуй болгох боломж нөхцөл бүрдэнэ. Үүний зэрэгцээ үндсэн болон олон улсын стандарт, техникийн зохицуулалтыг уялдуулан хэрэглэх нөхцөлийг ч бүрдүүлэх юм. Цахим

шилжилт, хиймэл оюун ухаанд суурилсан шинэ үеийн стандартын үйлчилгээний үндэс суурийг тавьж, импортоор орж ирж байгаа бараа, бүтээгдэхүүнүүдийг мэдээлэл, технологи, хиймэл оюун ухаан дээр суурилан хүний оролцоогүйгээр хянаж, шаардлагатай арга хэмжээг авах тогтсон нэгдсэн бүтцийг бий болгох боломж бүрдүүлнэ.

2.Хуулийн төсөлд туссан гол шинэчлэлүүд нь стандартыг дагаж мөрдөх зохицуулалтыг хуульчилж, хэрэгжилт, хяналтыг эрх бүхий байгууллагаар дамжуулан баталгаажуулахаас гадна мэргэжлийн байгууллагууд, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудаар ч хэрэгжүүлэх ажлуудын нэр, заалт, салбар, хэм хэмжээ маш тодорхой болох боломж бүрдэх юм. Стандартыг улсын хэмжээнд нэг мөр болгох, мөрдөх давхардалгүй нэгдсэн тогтолцоог ч бий болгоно. Стандарт, тохирлын үнэлгээ, итгэмжлэлийн байгууллагын эрх, үүргийг тодорхой болгож, орон нутгийн түвшинд, бүсийн түвшинд хэрэгжилтийг хариуцах бүтэц, хяналт, оролцоог нэмэгдүүлнэ. Олон улсын итгэмжлэл, магадлан итгэмжлэлийн байгууллагуудтай харилцан хүлээн зөвшөөрөгдөх эрх зүйн үндэс мөн бий болно. Техникийн шаардлагыг ч бид олон улсын стандарт хөгжлийн түвшинд хүргэх боломж бий болно.

3.Хуулийн хэрэгжилтийн үр нөлөө. Энэхүү шинэчлэл хийгдсэнээр иргэдийн хэрэглээний чанар, аюулгүй байдал, эрүүл мэнд, үндэсний аюулгүй байдал илүү баталгаатай болно. Дотоодын үйлдвэрлэл, экспорт, хилийн хяналтын нэвтрэлт сайжирч гаднын зах зээлд өрсөлдөх чадвар нэмэгдэнэ. Үндэсний үйлдвэрлэлийн эрчимтэй хөгжлийг ч бий болгоно. Авлигын эрсдэл буурч, төрийн хяналтын ил тод байдал, үйлчилгээний хүртээмж илүү сайжирна. Иргэд, ААН-үүдэд төрийн стандарт, шалгуур зохицуулалт ил тод, ойлгомжтой, нэг бүр хэрэгжих боломж бүрдэхээс гадна зах зээлийн зарчмаар нь иргэд хяналтаа тавьж, ААН, байгууллагууд хэрэгжүүлж, төр өөрөө ил тод, хүнд сурталгүй, авлигагүй системийг бий болгоход стандарт өөрөө асар өндөр ач холбогдлыг бий болгож үүргийг гүйцэтгэнэ гэж үзэж байгаа.

Эрхэм гишүүд ээ, стандарт бол хөгжлийн шалгуур, аюулгүй байдлын хэмжүүр билээ. Өнөөдөр бид хууль, эрх зүйн шинэчлэл хийх төдий бус соёлын шинэчлэлийг давхар хийж байна гэж ойлгох цаг нь болсон. Энэ цаг үеийн зааг дээр бид энэ соёлын болон амьдралын хэмнэл, дадал, өдөр тутмын ажил хэргийн хэл соёл, дадал зуршил болох стандартыг хэрэгжүүлснээр эмх цэгцгүй, эрээвэр хураавар олон асуудлууд эзэнтэй, хариуцлагатай болж ундуй сундуй айл шиг болсон салбар бүр богино хугацаанд эмх цэгцдээ орох боломж ч бүрдэх юм. Ард түмний амь нас, эрүүл мэндийн баталгаа ч нэмэгдэнэ, үндэсний аюулгүй байдлын бас нэгэн хөшүүрэг ч сайжирна. Экспортын өрсөлдөх чадварын түлхүүр нь өөрөө стандарт, үйлдвэрлэлийн хөгжил, чанарын шалгуур Монгол хүн бүрийн эрүүл, аюулгүй байдлын үндэс нь өөрөө энэ стандартын шинэчлэлийн асуудал учраас та бүхнийг хэлэлцэн дэмжиж өгөхийг хүсье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Өнөөдөр энэ хэлэлцэж байгаа асуудлаа хэлэлцэж дуусаад санал хураалт явуулахаар байгаа, 17 цагт санал хураалт явагдана, эртхэн зарлая. Гишүүд ажлаа зохицуулаад санал хураалтад оролцоно. Би өчигдөр хэлсэн байгаа. Чуулган завсарлах дөхөж байгаа учраас хуулиудыг яг хугацаанд нь санал хураалт явуулахгүй бол хэлэлцүүлэг хоорондын хугацаа долоо хоногоор сунгадаг учраас чуулган завсарлах хугацаа хойшилно. Хуулиа хэлэлцэж баталж амжихгүй нөхцөлд хүрэх талтай учраас бид цаг хугацаанд нь асуудлуудаа шийдээд явна. Төслүүдийн Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг

Улсын Их Хурлын гишүүн Отгоншарын Батнайрамдал уншиж танилцуулна. Индэрт урьж байна.

О.Батнайрамдал: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 5 сарын 16-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээ, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай шинэчилсэн найруулга хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2025 оны 6 сарын 10, 17-ны өдрийн хуралдаанд хэлэлцлээ. Монгол Улс өнөөгийн байдлаар 6730 стандарт хүчин төгөлдөр байгаа ч тэдгээр стандартыг дагаж мөрдөхгүй байгаагаас шалтгаалан хүн, малын эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, нийтийн ашиг сонирхолд сөрөг нөлөөллийг бий болгож, хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдөж байгаа бөгөөд цаашид стандартыг хэлбэрэлтгүй дагаж мөрдөх, нийгэм, нийгэмд уг соёл хандлагыг хэвшүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байгаа бөгөөд Монгол Улсын хөгжлийн баримт бичигт дурдсан стратеги чиг хандлагад нийцүүлэн улс орон, нийгэм, эдийн засгийн болоод хүн амын аюулгүй байдлыг хангаж, экспортыг нэмэгдүүлж, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээ, сорьцын хяналтын бодлогоор дэмжлэг үзүүлэх зорилгоор уг хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төслийг d.parliament.mn сайтад байршуулж иргэд, олон нийтийн саналыг авч байна. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Улсын Их Хурлын Тамгын газар хуулийн төсөлтэй холбогдуулан хууль зүйн дүгнэлт гаргаж, Байнгын хорооны хуралдаанд танилцуулсан билээ.

Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд хуулийн төсөлд стандартын байгууллага нь төлбөртэй ажил, үйлчилгээг эрхлэх, сургалт явуулах гэсэн тусгасан талаар болон тохирлын үнэлгээг төр, хувийн хэвшлийн түншлэлүүдийн хүрээнд хувийн хэвшил хийх боломжтой эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Цэнгүүн төрийн гүйцэтгэх зарим ажлуудыг мэргэжлийн байгууллагуудаар гүйцэтгүүлэх, олон улсын стандартуудыг үндэсний хэмжээнд стандарт болгоход тулгараад байгаа асуудлууд, тохирлын гэрчилгээ олголтын хугацааны талаар, Улсын Их Хурлын гишүүн Батчимэг өнөөдрийг хүртэл хэрэгжихгүй байгаа олон стандартыг хэрхэн цэгцэлж шийдвэрлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг одоо байгаа стандартыг шинэчлэх хөдөлгөөнийг мэргэжлийн холбоотой хамтарч хийх эсэх талаар, стандартын шаардлагыг хэрхэн хангаж ажиллах, стандартыг батлах үйл явцыг ил тод болгох, оролцоог нь хангахад анхаарах, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартуудыг хэрхэн нутагшуулах талаар, Улсын Их Хурлын гишүүн Мандхай баталгаажуулалтын схемийг хэн, хэрхэн батлах зохицуулалтын талаар, төсөл дэх тохирлын үнэлгээний байгууллага гэсэн тодорхойлолтуудын талаар асуулт асууж, хариулт авлаа.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Соронзонболд хувийн секторын хийж чадах ажлыг төр хийх нь зохисгүй тул уг асуудлыг төсөлд тусгахгүй байх, Улсын Их Хурлын гишүүн Мандхай нэр томъёоны хувьд аюулгүйн тэмдэг гэснийг баталгаат байдлын тэмдэг гэж өөрчлөх, техникийн зохицуулалт, хүн, мал, амьтан, ургамал гэсэн заалт

тусгах талаар, төслийн 17 дугаар зүйлд лаборатори гэсний өмнө лавлагаа гэж нэмэх талаар саналаа илэрхийлсэн болно.

Байнгын хорооны хуралдааны хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулахад Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээ, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн төслийг 77 хувь, Авто тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулсан тухай хуулийн төслийг 78,6 хувь, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн өөрчлөлтөд оруулах тухай хуулийн төслийг 71,4 хувь, Баяжуулсан хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 78,6 хувь, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийн өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 78,6 хувь, Монгол хэлний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 71,4 хувь, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг 66,7 хувь, Тамхины хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 80 хувь, Хот, суурин ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 80 хувь, Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 80 хувийн саналаар тус тус хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээ, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Авто тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Баяжуулсан хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол хэлний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Тамхины хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хот, суурин ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Хүнсний бүтээгдэхүүн, аюулгүй байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх талаар Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Сүхбаатарын Батбаатар Стандарт, хэмжил зүйн газрын дарга, Сэр-Одын Ням-Эрдэнэ Үндэсний итгэмжлэлийн төвийн дарга, Баярсайханы Ууганбаяр Стандарт, хэмжил зүйн газрын Захиргаа, удирдлагын газрын дарга, Гансүхийн Тулгаа Стандарт, хэмжил зүйн газрын Стандартчилал, тохирлын үнэлгээний бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ваанчигийн Ганзориг Стандарт, хэмжил зүйн газрын Бүтээгдэхүүн, тогтолцооны баталгаажуулалтын газрын дарга, Гомбодоржийн Батзориг Стандарт, хэмжил зүйн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Доржрагчаагийн Бэхбат Стандарт, хэмжил зүйн газрын Сорьцын хяналтын газрын дарга, Доржийн Эрдэнэтуяа Стандарт, хэмжил зүйн газрын Нийслэлийн лабораторийн дарга, Заанхүүгийн Мөнхбат Үндэсний итгэмжлэлийн төвийн Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга гэсэн бүрэлдэхүүн иржээ.

Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан урьдчилан ирүүлсэн нэрсийн дарааллын дагуу асуулт асууна. Дарааллын дагуу Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууя.

О.Цогтгэрэл: Стандартчиллын хуулийн хэлэлцэх эсэх явж байна. Хэлэлцэх эсэх гэдэг чинь хуулийн ер нь үзэл баримтлал өөрөө нийцэж байна уу, үзэл баримтлалыг дэмжиж байгаа эсэх гэдэг асуудал хэлэлцэх эсэх түвшиндээ яригддаг үзэл баримтлалыг нь. Тэгэхлээр энэ өргөн барьсан хууль дээр нэг жишээ нь үзэл баримтлалыг ярихад би 2 ойлголтыг нь эш татъя л даа. 1 дүгээрт нь төслийн танилцуулга дээр үзүүлснээр 6700 одоо байгаа стандартаас 80 хувь нь буюу 5000 гаруй нь орчин үеийн одоогийн хэрэгцээ шаардлагад нийцэхгүй байна гэж гарсан байна л даа. Тэгэхээр эдгээр стандартуудыг заавал дагаж мөрдөх хэлбэрт хуульчилна гэж. Тэгэхлээр одоо байгаа 6000 стандартын 80 хувь нь орчин үеийн хэрэгцээ шаардлагад нийцэхгүй байна. Тэгэхдээ энийг заавал дагаж мөрдүүлнэ. Энэ үзэл баримтлалын түвшинд жишээ нь энэ өөрөө яг яасан айхтар зөрчилтэй юм орж ирж байна вэ? Манай байгаа хэдэн мянган стандарт чинь шаардлага хангахгүй байна. Тэгэхдээ энийг заавал хуульчилж дагаж мөрдөх ёстой.

Тэгэхлээр энэний цаана чинь нөгөө бид нарын яриад байдаг энэ чинь 6 мянган тусгай зөвшөөрөл тэгвэл бий болчхож байна шүү дээ. 6700-аас бараг 5 мянга гаруй тусгай зөвшөөрлийг бид хуульчлаад заавал. Уг нь энэ стандарт гэдэг зүйл чинь миний ойлгож байгаагаар сонгож хэрэглэдэг. Нөгөө талд нь тэр техникийн зохицуулалт гэдэг зүйл нь заавал дагаж мөрдөхөөр байдаг. Тэгэхлээр энэ хуулийн гарц гаргалгаа олон зүйлүүд чинь харин энд байгаа юм биш үү? Юуг заавал дагаж мөрдүүлэх юм бэ, юуг сонголтоор байх юм бэ, юуг тэр орчин үечүүлэх юм гэдэг энэ бүх зүйлүүд чинь байхад шууд хуулиар бид алх цохиод орчин үеийн хэрэгцээ шаардлагад, олон улсын хэрэгцээ шаардлагад нийцэхгүй байгаа стандартыг шинэчилж өөрчилж нийцүүлэхээсээ урьдаар энэ байгааг заавал дагаж мөрдүүлнэ гэхээр энэ үзэл баримтлалын түвшинд энэ чинь өөрөө ингээд хэрэгжихэд, хэрэгжүүлэхэд, хүчиндэж хэрэгжүүлснээрээ энэ улс оронд дахиад энэ өөрөө очиж буулга болж буудаг тэр бизнес эрхлэгчид дээр чинь бид нарын нэг гоё ярьдаг зөвшөөрлийг цөөлнө, төрийн зохицуулалтыг цөөлнө, төрийн оролцооноос гадна төрийн зохицуулалтыг цөөлнө гэдэг энэ бидний явж байгаа нийгэм, эдийн засгийн энэ үзэл баримтлалын чинь айхтар эсрэг ийм үзэл санаа энд орж ирээд байгаа юм шиг. Энэ дээр хууль санаачлагч нэг тайлбар өгөөч. Энэ чинь үнэхээр ингээд нэг ийм үзэл баримтлалын түвшинд асар ойлгомжгүй ийм зүйл л харагдаад байна. Аль эсвэл би буруу ойлгоод байна уу?

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Монгол Улсын Шадар сайд Сайнбуянгийн Амарсайхан.

С.Амарсайхан: Цогтгэрэл гишүүн жоохон буруу ойлгочих шиг боллоо мэдээллээ. Энэ 80 хувь нь хэрэгжихгүй байгаа, шинэчлэх шаардлагатай нь зайлшгүй үнэн, энэ бодит нөхцөл байдал 1 дүгээрт. 2 дугаарт энэ ямар нэгэн байдлаар хүчээр хэрэгжүүлэх тухай асуудал бид ярьж байгаа зүйл биш. Өнөөдөр хэрэглэгч, үйлдвэрлэгч, бүтээгдэхүүн, үйлчилгээ нийлүүлэгч бол стандартаа өөрөөр хэлбэл бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээ нийлүүлэх стандартаа сонгож авдаг хэдий ч тэрийгээ хэрэгжүүлэхээсээ хэрэгжүүлэхгүй нь их байдаг. Тэгэхээр бид нэгэнт сонгож авсан, харин ч хүчээр биш сонголтыг нь илүү тодорхой болгож өгч байгаа юм. Сонгоод авчихсан бол нэгэнт зах зээл, хэрэглэгчдэд бүтээгдэхүүн, үйлчилгээ

нийлүүлж байгаа бол өөрөө чанартай, аюулгүй, сэтгэл ханамжийн баталгаатай байх талаас нь сонгосон стандартаа заавал хэрэгжүүлдэг авдаг байя гэж 1 дүгээрт.

2 дугаарт та өөрөө бизнес аж ахуй эрхэлдэг, үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлдэг, шууд хүний хүнс, эрүүл мэндтэй холбоотой бараа, бүтээгдэхүүн үйлчилдэг туршлагатай хүн мэдэж байгаа байх. Стандартыг хамгийн сайн ойлгож байгаа хүн гэж би бодож, ойлгож явдаг. Тэгэхээр энэ хэрэглэгчийн баталгаатай хүнсний болон бусад бүх бараа, бүтээгдэхүүний аюулгүй байдал манайд алдагдсан, хяналт, зохицуулалт, төрийн болон хувийн хэвшлийн уялдаа холбоо байхгүй болсон. Дээрээс нь импортоор орж ирж байгаа бараа, бүтээгдэхүүн өөрөө хяналт, гарал үүсэл тодорхойгүй бөгөөд зарим нь эргэлзээтэй байдлууд бий болсон. Тэгэхээр бид 1994 онд Дэлхийн худалдааны байгууллагатай хийсэн гэрээ хэлэлцээр бол энэ зайлшгүй дагаж мөрдөх ийм олон улсын стандарт, итгэмжлэлийн тогтолцооны хэрэгжилтийг хангах асуудлууд ч энд мөрдөгдөж байгаа юм.

Тэгэхээр энэ бол өөрөө цаашлаад зөвхөн энэ хэн шаардлага хангахгүй 80 хувиа хийе гэх биш, ашигла гэх биш, энийг яаралтай шинэчилж, өөрчлөх тогтолцоог илүү тодорхой болгоод, энэ ашиглаж хэрэглэж болохгүй байгаагаа яаралтай шинэчлэхийг нь шинэчлээд, хүчингүй болгохыг нь болгоод ингээд явъя гэж байгаа юм. Тэгэхдээ стандартыг зөвхөн төр хийдэг юм биш. Иргэн, ААН, байгууллагууд, мөн хувийн хэвшлийнхэн бүгдээрээ шинжлэх ухааны нотолгоо суурин дээр үндэслэсэн аюулгүй байдал, хэрэглээг хангасан олон, сар, жилийн олон удаагийн туршилт нотолгоо дээр хийгддэгийг нь мэргэжлийн байгууллага буюу Стандарт, хэмжил зүйн газар нотолж, мэргэжлийн хүмүүс ТББ-ын оролцоотойгоор өөрөө энийгээ баталгаажуулах тэр боломж нөхцөлийг нь бүрдүүлээд, ингээд үндэсний аюулгүй байдал, хэрэглээний аюулгүй байдлыг хангая гэж байгаа юм. Энэ өөрөө түрүүн хэлсэн хэрэглээний аюулгүй байдал, хөгжлийн шалгуур, стандарт хаана байна тэнд аюулгүй байдал хангагдаж байдаг. Стандарт хаана байна тэнд сэтгэл ханамж байдаг. Стандарт байхгүй газар алхаа гишгээ, амьдарч байгаа орон сууц, ажиллаж байгаа ажлын байраасаа эхлээд бүгд эрсдэлтэй байгааг бид харсаар байгаад энэ асуудлыг хөндөхгүйгээр байдаг л юм байж л байгаа юм гээд орхиж явах боломжгүй юм гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Одонгийн Цогтгэрэл гишүүн тодруулж асууя.

О.Цогтгэрэл: Тийм ээ, стандартыг нь цаана чинь би тэр нэг заавал дагаж мөрдөх гэдэг хуульчлах дээр нь тэр техникийн зохицуулалт гэдэг бидэнд тийм том боломжууд тэрний цаана байгаа, одоо хуулиараа ч байгаа байх. Ер нь аливаа бизнесийн үйл ажиллагааны цаана хөрөнгө оруулагч, худалдан авагч талын шаардлага гэдэг өөрөө их онцлог гол зүйл. Тэгэхээр бид тэр худалдан авагч улсуудын магадгүй экспортын асуудал дээр худалдан авагч улсуудын стандарт олон, олон зүйлүүдийг сонгож хэрэглэх, тэр евро стандарт бусад стандартуудыг нь сонгож хэрэглэх, бусад асуудлууд дээр илүү энэ хуулийн үзэл баримтлалын түвшинд нэг тийм жоохон хаалттай болчихоод байгаа юм биш биз дээ? Энэ чинь 6000 авлигын 6000 тусгай зөвшөөрөл нэг албан хаагч, төрийн захиргааны байгууллагын асуудал болоод хувирах ийм үзэл санаа энэний цаана чинь харагдаад байгаа юм биш биз дээ гэж санаа зовнисон тэр талаасаа л асуудалд хандаж байна л даа. Тийм зүйл рүү яг энэ хууль алх зогссоны дараа ингээд тийм зүйл рүү бэлээхэн орчих ийм зүйл харагдаад байгаа юм шиг л.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууя.

П.Сайнзориг: Өдрийн мэнд хүргэе. Энэ хуулийг хэлэлцээд явах нь зүйтэй байх. Тэгээд ажлын хэсэг гаргаад тал талаас нь нэг сайтар хэлэлцээд явах нь зөв байх. Өмнөх хууль маань уг нь үзэл санааны хувьд хүчин төгөлдөр хууль маань гэсэн үг шүү дээ үзэл санааны хувьд зөв байгаа. Хэрэгжүүлэх тал дээр нэг жоохон асуудлууд байна уу даа гэж зүгээр бодогдох юм. Би зүгээр стандартыг дагаж мөрдүүлнэ гэдэг дээр яг Цогтгэрэл гишүүн, Байнгын хорооны түвшинд Хассуурийн Ганхуяг гишүүн хэлж байсантай санал нэг байгаа. Жоохон болгоомжтой байхгүй бол автоматаар 6700 орчим журам дахиад автоматаар орж ирэх гэж байна л гэсэн үг. Тэгэхээр дагаж мөрдөх гэхээсээ илүүтэй стандартыг хангуулж ажиллах гэдэг ойлголт байгаад байгаа. Хангуулж ажиллах тэр хангаж байгаа цэгээс дахиад илүү нөхцөлийг ч хэрэглэгчдэд санал болгож болох байхгүй юу. Тэгэхээр ер нь зүгээр цаашдаа стандартыг дагаж мөрдөх гэж биш, стандартыг хангаж, түүнээс илүү нөхцөлүүдийг хэрэглэгчид болон олон нийтэд санал болгох гэдэг л агуулгаар явбал зөв юм шиг зүгээр санагдаж байгаа юм. Энийг зүгээр ажлын хэсэг байгуулбал ярилцаад, анхаараасай гэж үзэж байгаа юм. Тэгээд яг мэргэжлийн хүмүүс энэ дээр юу гэж хэлж болох вэ?

Тэгээд стандарт гэдэг ер нь хэрэглэгч энэ авч байгаа бараа, ажил үйлчилгээндээ хяналт тавих л бололцоог олгож байгаа зүйл шүү дээ. Иргэний хууль буюу хууль зүйн талаас эрхийн доголдолгүй байх, эд хөрөнгийн доголдолгүй байх гэдэг зүйлийг худалдан авч байгаа тэр үйлчилгээг авч байгаа хүмүүс шалгаж авах ёстой. Энэ шалгаж авч байхдаа энэ ISO тэдэн мянга гэдэг стандарт байна гэвэл нийцэж байна уу гэдэг зүйлээ хэрэглэгч шалгаж авч байгаа талаас нь боломжийг стандарт олгож байгаа зүйл байгаад байгаа юм. Тэгэхээр би Шадар сайдыг хариулаасай гэж хүсэж байгаа нь зүгээр сая үзэл баримтлалын хувьд зүгээр 6700-н 5000 нь нэлээн хуучирсан гээд байгаа. Тэгэхээр Шадар сайдаа насжилтын хувьд ер нь энэ стандартууд социализмын үед батлагдсан гэдэг юм уу, 1990 оноос хойш хэчнээн стандарт батлагдсан стандарт одоо хүртэл дагаж мөрдөгдөөд байна вэ? Завсрын буюу нөгөө шилжилтийн үе, зах зээлийн эдийн засгийн шилжилтийн үед батлагдсан хэчнээн стандарт мөрдөгдөөд байна вэ? Энийг хэдүүлээ нэг компаничлаад та сая индэр дээрээс хэллээ. Эрүүл мэндийн салбар гэхэд 400 хэд гэххэв, нэлээн том стандартуудыг шинэчлэх update хийх ёстой шүү гээд хэлж байна. Тэгэхээр энэ энийг ингээд хугацаатай үүрэг өгөх гэдэг юм уу, нэг компаничлах байдлаар сайжруулах асуудлыг мэргэжлийн холбоотойгоо хийх бололцоо байна уу? Мэргэжилтнүүдтэйгээ оролцуулаад зохион байгуулалтын арга хэмжээ авах тал дээр хийж болох уу гэдэг нэг зүйл байна.

Зарим талаараа энэ Европын холбооны стандарт болон яг олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг шууд нутагшуулаад авах асуудал дээр жоохон процессыг нь ойлгомжтой болгомоор байгаа юм. Тийм зарчмыг бид хэд яриад байдаг боловч бас их төвөгтэй. Англи дээр шууд явахгүй. Төрийн албан ёсны хэл чинь Монгол хэл учраас Англи дээр байгаа стандартыг дагаж мөрдөхгүй ч гэдэг юм уу иймэрхүү зүгээр байдлууд байна. Тэгэхдээ би зүгээр Англи дээр байгаа юмыг шууд дагаж мөрдье гэж байгаа юм биш. Энийг илүү жоохон хялбарчлаад, ойлгомжтой болгох тэр талаас нь ямар арга хэмжээ авч болох вэ?

Тэгээд стандартыг нь батлах процесс жоохон ил тод бус байгаа юм, ойлгомжгүй. Захиргааны хэм хэмжээний актыг чинь нөгөө хууль тогтоогч буюу Улсын Их Хурлаас эрх олгосны дагуу хуулиар эрх олгосны дагуу баталж байгаа шүү дээ. Тэгээд энэ хэм хэмжээний актыг захиргааны шүүх хянаж байгаа, Засгийн

газрын баталж байгаа зарим хэм хэмжээний актыг бүүр Цэц ч хянаж байгаа. Дээд шатын албан тушаалтан бас хянадаг. Хэм хэмжээний акт дээр ийм олон хяналтууд байж байхад стандарт дээр ер нь ямар хяналтууд байдаг юм бэ? Энэ ерөөсөө нийцэхгүй стандарт баталчихжээ, update хийх шаардлагатай байна, ийм зүйлийг зөрчөөд байна гэдэг зүйлийг сонирхсон этгээдүүд хандвал хаана гомдол гаргадаг юм бэ? Би зүгээр олон нийтийг мэдээлэлжүүлэх зорилгоор асууж байгаа юм. Тэгэхээр энэ бүх зүйлүүдийг жоохон процессын хувьд энэ удаагийн хуулиар сайжруулах талаасаа анхааръя. Тэгээд энэ хуулийг хэлэлцээд явмаар байна. Энэ бизнесийн орчныг сайжруулах, эргээд зарим зүйлийг сайжруулахад маш чухал байгаа. Тэгээд.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Асуултад хариулъя 4 дүгээр индэр.

С.Батбаатар: Их Хурлын эрхэм гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Эрхэм гишүүн Сайнзоригийн асуултад хариулъя. Монгол Улсад одоогийн байдлаар 6730 стандарт хүчин төгөлдөр мөрдөж байгаа. Гол асуулт нь юу вэ гээд.../үг тасрав/

Д.Амарбаясгалан: Жоохон чанга яриарай.

С.Батбаатар: Монгол Улсад 6730 стандарт одоогийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. 1961-ээс 2000 он хүртэл нийт стандартын 28 хувь нь эзэлж байна. Энэ болохоор 1910 стандарт одоогийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөж байна. 2001-ээс 2010 он хүртэл 2145 стандарт буюу 31,7 хувь нь эзэлж байна. 2011 оноос 20 он хүртэл нийт стандартын боловсруулсан стандартын 30 хувийг нь эзэлж байгаа гэсэн ийм тоон мэдээ байна. Аль түрүүн Монгол Улсын Шадар сайд хэлсэн стандартын үзлэгийг бид жил бүхэн 5 жил тутамд хийж байгаа. Энэ дээр барилга, эрүүл мэнд, хүнсний чиглэлийн стандартыг ингээд бид ингээд үзлэг хийсэн. Тэрнээс хойш 3 жилийн хугацаа өнгөрч байхад стандартын шинэчлэлийн ажил ерөөсөө хийгдэхгүй одоог хүрчихсэн байгаа асуудал ярьж байгаа. Нийт шинэчлэх зайлшгүй шаардлагатай стандартын 80 гаруй хувь нь одоог хүртэл ингээд хийгдээгүй ингээд хүлээгдэж байгаа.

Тэгэхээр энэ хуулиараа юу зохицуулж өгөх гэж байгаа вэ гэхээр энэ стандартын шинэчлэлийн асуудал бол эргээд улс орны хөгжил дэвшилтэй шууд холбоотой байдаг. Стандарт чинь өөрөө олон улсын түвшинд батлаад нотлоод гаргаад ирсэн шилдэг технологи, шилдэг инновац өөртөө шингээчихсэн байдаг. Тэгэхээр энэ стандартын ажлыг тухайн салбарын байгууллагууд нь өөрсдөө анхааралдаа авч энийг шинэчлэх ажлыг эрчимжүүлэх ажил энэ хуулийн төсөл дээр тусгагдсан байгаа гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Гүйцээж яриулах уу? Шадар сайд хариулт өгье.

С.Амарбаясгалан: Сайнзориг гишүүн маш чухал асуудлуудыг хөндөж байна. Түрүүн Цогтгэрэл гишүүн ч ярьсан. Энэ ерөөсөө зөвшөөрлийг нэмэгдүүлж, хүнд суртлын бий болгох гээд байгаа зүйл ерөөсөө биш. Энэ зөвшөөрөл нь ч мэдэгдэхгүй, лиценз нь ч мэдэгдэхгүй энэ олон ойлгомжгүй асуудлуудыг цэгцэлж, харин энэ стандарт нь өөрөө зөвшөөрөл байдаг, зөвшөөрөл нь өөрөө стандарт байдаг ил тод, нээлттэй ийм тогтолцоо руу шилжье гэж байгаа юм. Тийм учраас хэрвээ стандартаа л хангачихсан бол тэр нь өөрөө үйл ажиллагаа явуулах боломж нь зөвшөөрөл нь өөрсдийнх нь аюулгүй байдлын хэрэглээний баталгаа болдог байж гэж. Стандарт өөрөө хүнд суртал бөгөөд авлигал, хээл хахуулийн хэрэгсэл байж

болохгүй учраас энэ шинэчлэлүүдийг хийе гэж байгаа юм. Стандартын хяналтыг хэн тавих ёстой вэ гэхээр хуучин мэргэжлийн хяналт гэж байсан. Одоо салбар бүрд яамандаа харьяалагдаж байгаа хяналтын байгууллагууд нөгөө сонирхлын хувийн биш жинхэнэ стандартын хяналтаа тавьчихвал.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Пүрэвжавын Сайнзориг гишүүн тодруулж асууя.

П.Сайнзориг: Тэгэхээр энэ хуулийг хэлэлцээд явъя гэдэг дээр байгаа. Тэгээд 1 зүйлийг хэлмээр байна. Сая ингээд социализмын гэдэг юм уу, төлөвлөгөөт эдийн засагтай орны хувьд технологи, инновац ямархуу түвшинд байлаа тэр үед. Тэр үед батлагдсан 1900 стандартад мөрдөгдөөд явж байна гэдэг бол хэцүү. Стандартыг сайжруулж чадвал төсвийн хөрөнгө оруулалтыг ч гэсэн үр нөлөөтэй хэмнэлттэй төлөвлөж чадна. Бид хэд магадгүй зам гүүрний барилга байгууламж стандартыг сайжруулж чадвал энэ өнөөдөр бараг танк явах зам хийгээд байгаа байхгүй юу гүүрний хувьд. Энийг бид стандартаа сайжруулж чадвал хөнгөн хийцлэлтэй, орц найрлага нь зөв орж чадвал тэр гүүр барих 100 төгрөгийг бид магадгүй 50, 60 луу ч буулгах бололцоотой. Тэгэхээр энэ зүйлүүдийг чухалчлах нь төсвийн хөрөнгө оруулалтыг, төсвийн хөрөнгийг ч гэсэн хэмнэх энэ нөхцөл байдал байгаа шүү гэдэг зүйлийг хэлмээр байна. Тэгээд би энэ стандартын хууль дээр захиргааны хэмжээний акт дээр Хууль зүй, дотоод хэргийн яам жил болгон хяналт хийгээд, энэ, энэ болохгүй байна гэдэг зүйлийг ЗГ-т танилцуулж, шийдвэр гаргуулдаг. Яг үүн шиг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Отгоны Саранчулуун гишүүн асуулт асууя.

О.Саранчулуун: Маш олон стандарт, тэгээд дагалдаад техникийн хороо гэж байдаг. Техникийн хороон дээр илүү тодруулах гэж байгаа зүйл нь эрүүл мэндийн үйлчилгээнүүд дээр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний стандартын техникийн хорооны шилжилт энэ дээр ямархуу өөрчлөлт харагдах вэ гэдэг дүр төрхийг мэдмээр байгаа. Техникийн хороонд орж байгаа хүмүүсийн хувьд дагаад шинэчлэгдэх, өөрчлөгдөх процесс болох уу?

Хоёрдугаарх нь стандартын орчуулгын баг, орчуулгын баг нөгөө талаасаа Стандартын техникийн хорооны гишүүд дунд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ч юм уу, яг тэр бэрхшээлтэй хүмүүстэй холбоотой үйлчилгээ дээр энэ хүмүүсийн оролцоо нэмэгдэх үү гэдгийг тодруулмаар байгаа. Яагаад гэвэл хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй холбоотой маш олон стандарт байгаа. Тэр дотор орчуулгын үгийн алдаатай зүйлүүд их байсан өмнө нь. Тэгэхээр энэнтэй холбоотой төлөөллийг нь оруулах ийм ахиц харагдах болов уу гэдэг дээр тодруулъя. Тэгээд дараа нь.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье 4 дүгээр индэр.

С.Батбаатар: Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Одоогийн яг хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуулиар энэ техник 64 техникийн хороо, энэ 64 техникийн хороонд 700 гаруй гишүүнчлэлтэй үйл ажиллагаа явуулж байна. 700 гаруй гишүүнчлэлийг ингээд аваад үзэхээр төрийн байгууллагаас 50 орчим хувь нь, үлдсэн нь ААН, иргэн, тэгээд мэргэжлийн байгууллагуудаас ингээд орж байгаа. Одоогийн энэ стандарт чинь Техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль дээр энийг бүүр олон улсын түвшин буюу олон улсын тохирлын үнэлгээний бодлогын хорооны яг жишгийг оруулаад аж үйлдвэр, худалдааны салбараас оруулах, Засгийн газрын төлөөллөөс оруулах, хэрэглэгчээс

оруулах, ажил олгогч буюу хувийн хэвшлээсээ оруулах, сургалт, эрдэм шинжилгээний судалгааны байгууллагуудын төлөөлөл оруулах, стандартыг хэрэгжүүлэгч байгууллага, төрийн бус байгууллага гэсэн 7 категориор ингээд оруулахаар ингээд хуулийн төсөл боловсруулагдаад явж байгаа гэдгийг нь хэлье.

Д.Амарбаясгалан: Саранчулуун гишүүн тодруулж асууя.

О.Саранчулуун: Яах вэ ойлголоо. Энэ дээр яах вэ би зүгээр нэммээр байгаа зүйл нь ер нь нэр томьёоны нэгдсэн сантай болох хэрэгтэй гэдэг санаа хэлэх гээд байгаа. Яагаад гэхлээр яг энэ хөгжлийн бэрхшээлтэй хүнийг жишээ аваад үзэхлээр тэнд хэрэглэгдэж байгаа үйл ажиллагааны стандарт, нэр томьёо чинь орчуулгын алдаатай юм уу, зөрөөтэй ойлголтууд байна. Нөгөө талаасаа эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний стандарт гэхээсээ илүү guideline байдаг. Бид энийг хурлын үеэр зөндөө ярьж байсан. ДЭМБ-ын guideline, ер нь guideline дагаж байгаа. Тэгэхээр энийг дагаад нэр томьёоны маш их хөдөлгөөн явж байгаа. Ялангуяа эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ тэр дотроо нөгөө хэрэглэгч нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс байгаа. Таяг, тэргэнцэр, алхуулагч, налуу зам гэдэг чинь өөрөө янз бүрийн орчуулгатай, нөхөн сэргээх гэхэд сэргээн засах засах гээд ингээд хөдөлчихсөн байгаа шүү дээ. Тэгэхээр нэр томьёоны санг энэ хуулийг дагаж шинэчлэх тухай орсон бол сайн байна. Ороогүй бол би энэ дээр зориуд санал болгож хэлж байгаа юм.

Д.Амарбаясгалан: Шадар сайд хариулт өгье.

С.Амарсайхан: Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд багачууд, ахмад буурлууд гээд энэ амьдрах орчин, аюулгүй байдлын орчин нөхцөл асар эрсдэлтэй байгаа. Тийм учраас Саранчулуун гишүүний хэлсэн энэ асуудлуудыг бид ажлын хэсэг байгуулагдаад явахаар илүү саналуудыг нарийвчилж тусгана. Одоогийн энэ томьёолол, хуулийн зүйл, заалтууд орж ирж байгаа шалтгаан бол ерөөсөө л энэ асуудал хүндрэлийг шийдвэрлэх 1 дүгээр ийм заалт бий.

2 дугаарт энэ техникийн хороодын чиг үүрэг тодорхой байдаг. Гэсэн ч гэсэн энэ өөрөө олон улсын салбарыг хамарсан ийм хороо байдаг ч зохион байгуулалт, мэргэжлийн ур чадвар, хувь хүмүүс, мэргэжилтнүүдийн өөрсдийнх нь хүлээн зөвшөөрөгдсөн байдал дээр анхаарах зайлшгүй шаардлага бий. Цаашлаад бид энэ салбар бүгд тусгайлсан техникийн хороонуудыг илүү нарийвчилж, мандатчилах шаардлагатай. Шалгуур үзүүлэлтүүдийг нь гишүүн бүрээр нь шинэчилж, шалгуурыг өндөр болгох ёстой. Төрийн байгууллага, ТББ, шинжлэх ухааны байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгэм.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуулт асууя.

О.Номинчимэг: Өдрийн мэнд хүргэе, 3 асуулт байна. 1 дүгээрт энэ үзэл баримтлалын хувьд стандартыг нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ болгож ер нь заавал дагаж мөрдөх гэж орж байгааг би ер нь жоохон ойлгохгүй байна. Тэгээд бид чинь ингээд юу яаж байгаа шүү дээ хуулиар ер нь нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээг бид чинь хуулиар, тэгээд хууль тогтоогчийн зүгээс эрх мэдлээ шилжүүлж бид захиргааны гүйцэтгэх засаглал руу өгч байгаа. Тэгээд стандарт гэдэг юмыг бид ерөнхий ингэж нэг тодорхойлчихоод, тэгээд стандарт нь заавал дагаж мөрдөх хэм хэмжээ байна гээд тэгэхээр ингээд зэрэгцээ нэг баахан дагаж мөрдөх ийм нэг систем үүсэх гээд байна гэж харж байгаа. Тэгээд олон улсад стандарт гэдэг чинь юу

юм бэ гэдгийг заавал дагаж мөрдөх хэм хэмжээг хууль, тэр regulation юу байдаг юм захиргааны хэм хэмжээний актаараа хийдэг. Стандарт бол өөрөө салбарын эсвэл юуны бүтээгдэхүүний л ийм юунууд байгаа шүү дээ. Тэгээд салбар салбартаа энэ чинь гол нь нөгөө нэг аюулгүй байдал, тохиромжит байдал, үр ашигтай байдалд зориулаад процессын стандарт байж болно, менежментийн стандарт байж болно, аюулгүй байдлын стандарт байж болно, бүтээгдэхүүний стандарт гэж байж болно. Тэгээд энэ стандарт гэдэг юм маань өөрөө зарим хэсэг нь заавал дагаж мөрдөх хэм хэмжээ болчихоор бид нарын хуулийн нөгөө хуулийн дагаж мөрдөх хэм хэмжээний системчлэл дунд их гажуудал гарах гээд байгаа юм шиг санагдаад байна. Тэгээд энэ дээр та бүхэн маань яагаад ингэж сонгосон юм бэ гэдэг нэг эхлээд хариулт авъя.

2 дахь асуулт бол таны Амарсайхан сайдын хэлж байгаа яг зөв. Бид нарт энэ төрийн хянан шалгалтын асуудал маш их ийм тархай бутархай, яг хяналт шалгалтаа хийх ёстой газар дээрээ хяналт шалгалт явагдахгүй байх нөхцөл байдал үүсчихсэн байна. Тэгээд энэ хуулийг харахаар 29 дүгээр зүйл дээр төрийн хяналт гэдэг ийм шинэ зүйл, заалт байна л даа. Уншихаар яг нөгөө энэ юуг техникийн зохицуулалтын хэрэгжилт, стандартын хэрэгжилтийг хянах эрх бүхий улсын байцаагч хэрэгжүүлнэ. Энэ ингээд нөгөө улсын байцаагч, хүн, малын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, нийтийн ашиг сонирхолд хохирол учруулж болзошгүй бүтээгдэхүүн энэ бусад хуулиар хэрэгжүүлэхээр заасан бүтээгдэхүүний тохирлын баталгаа хэсэгт хяналт тавина гээд нэлээн ийм чиг үүрэгтэй. Зохион байгуулалтын хувьд энэ улсын байцаагчид хаана харьяалагдах юм бэ? Одоогийн тархай бутархай янз бүрийн яамнууд юу байдаг юм энэ дээрээ байх гээд байна уу эсвэл энэ стандартын газрынхаа доор байх гээд байна уу, ямар хүрээнд энийг харж байна гэдэг 2 дугаар асуулт байна.

3 дугаар асуулт уг нь яг энэ таны энэ хуулийн үзэл санааны нэг чухал юм маш дэмжүүштэй юм нь ийм байгаа юм л даа. Энэ хүн, малын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, нийтийн ашиг сонирхолд хохирол учруулж болзошгүй юман дээр заавал тохирлын үнэлгээтэй эсэхийг нь хийнэ. Гаалиар гадаадаас Монгол Улс руу орж ирэх гэж байгаа бол энэ дээр нь заавал гаалийн байгууллага хяналт шалгалт хийнэ гээд. Бид угаасаа хүний ам руу ордог хүнс байдаг юм уу, эм байдаг юм уу, тэр тамхи нь байдаг юм уу энэ бүх юман дээрээ хяналтаа ерөөсөө хийж чадахгүй болчихсон. Ялангуяа гаднаас орж ирж байгаа юман дээрээ ямар ч хяналт алга. Энэ дээрээ хууль дээрээ бид гаалийн байгууллага хийнэ гээд оруулчихаж байгаа юм байна. Тэгтэл би Тамхины хяналтын хууль дээр ажиллаад гаалийн байгууллагатай ажиллахаар гаалийн байгууллага маань энэхүү стандартыг хэрэгжилтийг эд нар шалгаж чаддаг лабораторитой эсэх нь их тодорхойгүй байгаа байхгүй юу. Үгүй ээ энэ тамхи чинь ингээд их хямдхан байна, энэ чинь дотор нь янз бүрийн юм байгаа юм уу, хуурамч тамхи байгаад байгаа юм уу, энийгээ та шинжилж чаддаг юм уу гэхээр мэдэхгүй тэгээд гааль манай лаборатори чинь их муу шүү дээ гээд. Тэгэхээр энэ лабораторийн хүчин чадал, энэ хянан шалгалтын хүчин чадлыг ер нь яаж хийж байж та бүхэн энэ хуулиа хэрэгжүүлж чадна гэж үзэж байгаа юм бэ? Энэ бол маш чухал юм. Би энийг дэмжиж байгаа. Гэхдээ энэ дээр тооцоо судалгаа байна уу гэдэг энэ 3 асуулт дээр эхлээд хариулт авъя. Тэгээд тодруулъя.

Д.Амарбаясгалан: Шадар сайд Амарсайхан хариулт өгье.

С.Амарсайхан: Номинчимэг гишүүн чухал, чухал асуудал ярьж байна. 1 дүгээрт бид олон улсын гэрээ хэлэлцээр конвенцод нэгдсэн олон шаардлагуудыг биелүүлэх шаардлагатай болдог. Энэ нь өөрөө зөвхөн олон улсын төдийгүй манай

улсын стандарт үйлчилгээ, бараа, бүтээгдэхүүнүүдийг зах зээлд дотоод төдийгүй гадаадад гаргахаас гадна, гадаадаас дотоодод орж ирэх бүтээгдэхүүн, үйлчилгээнд хяналт тавих ийм тогтолцоо бий. Жишээ нь манай улс ISO, IEC болон энэ стандартуудын байгууллагын гишүүнүүд, энийг хэрэгжүүлдэг, стандартыг заавал дагаж мөрдөх болон сайн дураар дагаж мөрдөх гэж 2 ангилдаг. Манайд ингээд сайн дураар мөрдөж мөрдөх тал руугаа орчихсон учраас өнөөдөр эрүүл мэнд, хорт хавдраар салахаа больсон, хүнс баталгаатай асуудал хөндөгдөөд зогсохгүй, хүний амь нас, эрүүл мэндийг заналхийлж байна. Байгаль орчин, утаа униар, хөрсний бохирдол гээд энэ бүхэн дур зоргоороо явсан, эмх цэгцгүй явсан. Хүсвэл биелүүлнэ, хүсэхгүй бол биелүүлэхгүй гэдэг ийм хил хязгааргүй дур зоргын асуудал явсан учраас өнөөдөр бид эрүүл мэнд, амь нас цаашилбал үндэсний аюулгүй байдлаараа хүртэл эрсдэлд орох ийм нөхцөл бий болчихоод байгаа юм.

Өнөөдөр энэ хууль үйлчилж байгаа хууль өөрөө зүгээр л хүсвэл дагаж мөрдөнө, мөрдөхгүй ч байж болно гэдэг ийм тогтолцоо байгаа учраас бид сонголтыг нь бий болгож байгаа юм. Хэрвээ бид би энэ усыг сонгож авсан бол энэ стандартыг сонгож авсан бол яг энэ стандартыг л хэрэгжүүлнэ гэж байгаа юм. Сонгож аваагүй бол үгүй ээ гэвэл тэр хүний өөрийн эрхийн асуудал. Тэгэхээр бид энэ хэн нэгний сонголтоос болоод хүн амаараа хохирдог, эрсэддэг, хорддог, тэгээд төрдөө ч итгэдэггүй, улс төрчдөдөө ч итгэдэггүй, явж, явж өөрсдөдөө ч итгэдэггүй ийм нийгмийг бий болгочихсон юм чинь л өөрөө энэ стандарт бий болчихоод байгаа юм. Барууны стандартуудыг бид толгой их толгойгүй л шуурцгаадаг бүгдийг нь хэрэглэдэг. Тэгсэн мөртөө өөрсдөө энийг хэрэглэж байгаа.

2-т нь хяналт хэн тавих ёстой вэ гэхээр энэ салбарт байгаа жишээ нь эрүүл мэндийн хяналтыг эмнэлгийн хяналтыг Эрүүл мэндийн яамны дэргэдэх хяналтын байгууллага тавих ёстой. Стандартаа өөрсдөө төрийн болон ТББ, хувь хүний боловсруулсан стандартыг Эрүүл мэндийн яам өөрсдөө техникийн хороотойгоо зөвлөж оруулж танилцуулаад Стандартын газраар батлуулах ёстой.

Тэгээд 3 дугаар асуудал түрүүн ярьсан энэ импортын лабораторийн асуудал Гаалийн ерөнхий газрын харьяа хорио цээрийн лаборатори хил дээр байдаг. Энэ өөрөө хангалттай хяналтаа тавих боломж нөхцөл нь бүрдээгүй гэж үзэж байгаа. Тоног, төхөөрөмжийг шинэчлэх ёстой. Бид системийн шинэчлэл хийж байна стандартыг цахимжуулъя гэж байгаа юм. Мэдээлэл технологи, хиймэл оюун ухаан дээр сууриалаад орж ирж байгаа бараа, бүтээгдэхүүнийг гарал үүслээр нь, нэр төрлөөр нь цаашилбал өнгө зүс, хэмжээ дамжаа, орц найрлагаар нь хүртэл шууд хил дээр хянаад болбол болно, болохгүй бол оруулахгүй гэдэг энэ тогтолцоогоо.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: 4 дүгээр индрээс нэмэлт хариулт өгье. 1 минут.

С.Батбаатар: Номинчимэг гишүүний асуулт дээр нэг тодруулга яачихъя. ЗГ-ын 291 дүгээр тогтоол гэж байдаг. Гадаад худалдааны барааны ангиллын жагсаалт буюу хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, улс орны аюулгүй байдалд сөрөг нөлөө учруулж болзошгүй бүтээгдэхүүнийг түүвэрлэн авч заавал тохирлын үнэлгээ буюу тохирлын баталгаажуулалтад орж, тэрийг улсын хилээр бид хэрэглэх ёстой. Одоогийн яг байдлаар болохоор Стандарт, хэмжил зүйн газраас бол нийт 27 бүлгийн 94 зүйлийн бол 256 төрлийн бүтээгдэхүүнийг тохирлын баталгаанд бид хамруулж чадаж байна. Бусад баталгаажуулалтын байгууллагын, хувийн баталгаажуулалтын байгууллагаас нийт 6 бүлгийн 25, 88 нэр төрлийн

баталгаажуулалтыг бид ингээд хамруулж чадаж байгаа. Энд тохирлын үнэлгээнд буюу хамруулж чадахгүй 17 бүлгийн 300 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнийг бид хамруулж чадахгүй байгаа. Энэ цаашид 291 буюу заавал тохирлын үнэлгээнд хамруулах бүтээгдэхүүнийг шинэчилж батлах, цаашдаа энэ дээр ажиллаж.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Одсүрэнгийн Номинчимэг гишүүн тодруулж асууя.

О.Номинчимэг: 2 юм байна. Манай Шадар сайдад тэр мэргэжлийн хүмүүс сайн зөвлөмөөр байна. ISO стандарт чинь зарим нь заавал дагаж мөрддөг, зарим нь заавал дагаж мөрддөггүй юм байдаггүй байхгүй юу. ISO стандарт чинь бүгдээрээ volunteer буюу сонгон хэрэглэх, ямар үед энийг заавал дагаж мөрдөх шаардлагатай болдог вэ гэхээр 1 дүгээрт хууль юм уу, захиргааны хэм хэмжээний актаар ISO-г заавал дагаж мөрдөнө гээд хууль юм уу, яг хэм хэмжээний акт дээрээ энийг оруулчихсан үед. 2 дугаарт мэдээж нөгөө иргэн хоорондын, олон улс хоорондын гэрээ хэлэлцээр, тендерт заавал энэ стандартыг хангасан байна шүү гэдэг нөхцөл оруулсан үед тэнд оролцож байгаа талуудын хувьд заавал дагаж мөрдөгдөнө. 3 дугаарт энийг тусгайлсан энэ industry practice буюу яг салбартаа энийг авъя гэдгийг энийг баталгааж өгсөн тохиолдолд. Тэгэхээр ерөөсөө анхнаасаа яахдаа ISO стандарт гэдэг юм чинь заавал дагаж мөрддөг юм бол биш байхгүй юу.

Д.Амарбаясгалан: Шадар сайд хариулт өгье.

С.Амарсайхан: Номинчимэг гишүүн буруу ойлгосон, би ISO-г заавал дагаж мөрдөнө гээгүй. Стандарт өөрөө дотроо үндэсний ч бай, олон улсын ч бай заавал зайлшгүй болон сайн дураараа дагаж мөрдөх гэж ерөнхийдөө олон улс, олон улс оронд ангилагддаг. Стандарт яагаад заавал дагаж мөрдөх ёстой байдаг вэ гэхээр ялангуяа эрсдэлд үндэслэсэн шаардлагууд өөрөө стандартууд заавал дагаж мөрдөх ёстой байдаг. Та өөрөө хуульч хүн маш сайн мэдэж байгаа байх. Манай улс оронд бид гараад явахаар ер нь эрсдэлгүй салбар байна уу, эрсдэлгүй сэдэв байна уу, эрсдэлгүй амьдрал байна уу? Тэгээд энэ асуудлуудаа бүгдээрээ ингээд буруу ойлгоод л, буруу яриад л, буруу тайлбарлаад л эхэлбэл өөрөө энэ дахиад л хэдэн 10 битгий хэл, 100 жилийн дараа ч бид энэ зовлонгоосоо ангижрахгүй. Ер нь ойрын зовлонгоо мартахгүй бол холын зорилгодоо хүрэхгүй гэдэг шиг бид ер нь энгийн бөгөөд.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Одсүрэнгийн Номинчимэг гишүүн тодруулж асууя.

О.Номинчимэг: Амарсайхан сайдаа би зарим стандартыг заавал дагаж мөрдөх үгүй ээ үгүй ерөөсөө болохгүй гэж хэлээгүй шүү дээ. Логик нь буруу байгаа байхгүй юу. Стандарт өөрөө дагаж мөрдөх, заавал дагаж мөрдөх баримт бичиг биш. Гэхдээ хуулиараа юм уу, дүрэм журмаараа хууль тогтоогчоос эрх өгсөн хүрээнд энийг заавал дагаж мөрдөнө гэдэг эндээ шигтгэж өгч байж анх нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ болно. Тэгээд энэ нэн чухал юмнуудаа заавал хуультайгаа, журамтайгаа ингэж эхийг нь авч, эндээ шигтгэх ёстой гэж байгаа юм.

2 дугаарт тэр төрийн хяналт гэдэг дээр энэ дээр хаана хаанаа анхаармаар байгаа юм. Та сая бол ер нь эмнэлгийн бүтээгдэхүүний тухай хэллээ. Хүнсээ тэгэхээр хэн хянах юм бэ? Ингээд нөгөө мэргэжлийн хяналт байхгүй болчихсон чинь орон нутагт босоо тогтолцоотой мэргэжлийн хяналт байхгүйгээс нөгөө дүүргийн Тамгын газартаа нэг мэргэжилтэн харьяалагддаг болчихсон. Нэгдсэн шалгалт гэдэг

юм байхгүй болчихсон. Тэгэхээр яг энэ бусад орнуудын жишгээр хамгийн хяналт байх ёстой хүнс, эм юу гэдэг юм өөр тэр нарийвчилсан юм байвал энийгээ хянадаг нэг тийм босоо тогтолцоо цөмөөрөө хийж авахгүй бол ингээд.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хариулт өгье 4 дүгээр индэр.

С.Батбаатар: Номинчимэг гишүүний асуултад хариулъя. Мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарын яамдад өгчихсөн. Мэргэжлийн хяналт гэдэг байгууллага бол байхгүй болоогүй, салбарууд өөрөө дороо мэргэжлийн хяналтынхаа чиг үүргийг хэрэгжүүлээд явж байгаа. Манай Стандартчилал техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль дээр одоогийн шинэчилсэн найруулгын төсөл дээр тэр салбарынхаа хяналтын байгууллагатай л хамтарч ажиллая гэж байгаа юм. Тийм, салбарын хяналтуудтайгаа хамтарч стандартын дагуу л хяналт тавья гэж байгаа юм. Тэгэхдээ бид стандартыг энэ дээрээ тавигдах тэр хяналтын хуудас гэж байдаг. Тэрэн дээр стандартын дагуу хяналтаа тавиад, тэрнийхээ дагуу хамтарч ажиллахад асуудал байгаа. Тэгээд тухайн салбар дээр ямар хэчнээн стандарт байна, тэрнийхээ стандартыг яаж хангуулж байна, түүн дээр нь бид нар л хамтарч ажиллах журмаар энийгээ асуудал дээр хандаад явбал асуудлыг энэ хууль дээр тусгаж өгсөн байгаа.

Д.Амарбаясгалан: Шадар сайд нэмж хариулъя.

С.Амарсайхан: Яах вэ ер нь мэргэжлийн хяналтыг өөрчлөн зохион байгуулах гол шалтгаан мэргэжлийн бус үзэл сонирхлын, дээрээс нь стандартын бус авлигын ийм л тогтолцоо хаа сайгүй бий болсон шүү дээ. Тэгээд бодлого гаргадаг газрыг нь хэрэгжүүлдэг газартай нь хяналттай нь нэгтгээ гээд л салбар салбарынхаа яаманд нь харьяалуулсан. Дээрээс нь аймаг, орон нутгийнх нь нийслэл, аймагт нь харьяалуулсан. Тэгээд тогтолцоо мянга сайн байгаад хүмүүс нь ажиллахгүй, албан тушаалтнууд нь өөрсдөө ажил эзэнгүйдэх, асуудал дундаа хаядаг ийм нөхцөл байвал ямар ч нөхцөл байдалд мөрдөгдөхгүй ийм асуудлууд, мэдээж бүх зүйл сайхан болчихсон гэж хэлэхгүй. Анхаарах, сайжруулах зүйлүүд бий. Хяналт, зохион байгуулалтаа бүх түвшиндээ хамгийн гол нь уялдуулах ёстой. Дээрээс нь тогтолцоогоо сайжруулах ёстой хяналт өөрөө, тэгээд ямар нэгэн эзэнгүй хариуцлага яригддаг биш, стандарттай хариуцлага байя гэдэг ийм асуудал ярьж байгаа юм. Тийм.

Д.Амарбаясгалан: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууя.

Ц.Идэрбат: Хэлэлцэх, хэлэлцэхийг нь бол дэмжиж байгаа. Ер нь тэгээд аливаа энэ эрсдэл, учрал тохиол, энэ олон зүйлүүдийг харахад ер нь стандартаа бид гаргаагүй, гаргасныг нь мөрдөөгүй, тэгээд хувь хүний хариуцлагагүй байдал гээд л олон зүйлүүдэд нөлөөлөөд байдаг юм байна лээ. Тэрэн дундаа би бол энэ стандарт алдагдсанаас болоод энэ харамсалтай үйл явцууд их болдог. Дараа нь ингээд судлаад ингээд янз бүр болоход олон юмнууд зөрчигдсөн байдаг гэдэг ийм л дүгнэлтүүд гарсан байдаг шүү дээ. Тийм учраас стандарт батлах нь зүйтэй, стандартаа шинэчлэх нь зүйтэй гэдэгтэй би санал нэг байгаа юм. Тийм учраас би дэмжинэ гэсэн ийм байр суурьтай байна.

Нөгөө талдаа энэ стандарт нэг л гарсан мөрдөх л ёстой. Ялангуяа энэ хүний эрүүл мэнд олон зүйлүүд байна. Тэгээд би яг энэ гишүүдийн хэлэхийг л хэлэх гээд байна л даа. Энийг чинь нөгөө мөрдөж байна уу, үгүй юу гэдгийг, ийм үйлчилгээ

явуулах боломжтой юу, үгүй юү гэдгийг хянаж шалгадаг тэр байгууллага маань бидний санасан шиг ажиллаж чадахгүй байна. Салбарын яаман дээрээ очсон л гэнэ, аймаг дээр байгаа хэлтэс рүүгээ, агентлаг руугаа очсон л гэнэ. Яг үнэндээ тэр би олон хүмүүстэй энэ мэргэжлийн хяналтад ажиллаж байсан хүмүүстэй холбогдоод ер нь хяналтаа яаж хийж байгаа юм бэ гэсэн хяналтаа хийж чадахаа больсон гэж байна. Тэгээд 1 айлын хатавчинд оччихсон юм шиг 2 нөхөр тэнд унах унаа ч байхгүй, бензин ч байхгүй. Нөгөө агентлагийн дарга нь хөдөө гадаа явуулах ямар ч бололцоогоор хангахгүй. Тэгээд л нэг аймгийн төв дээр байж байдаг 2, 3 хүн болж хувирсан байна. Тэгэхээр бид энэ стандарт батлах нэг хэрэг, стандартыг мөрдөж байна уу, мөрдөхгүй байна уу гэдэг тэр хяналтын систем чинь илүү сайжрахгүй бол явахгүй нь байна шүү дээ.

Одоо ингээд төсвийн тодотголоор улам машин унаа, бензин тос, хамаг томилолтыг нь хаана гэж байна, дахиад явахгүй гэсэн үг. Тэгэхээр бидний өнөөдөр энэ ярих гээд байгаа юм чинь хэрэгжихгүй болох гээд байгаа байхгүй юу. Тийм учраас энэ мэргэжлийн хяналтын байгууллагын үүрэг чиглэлийг авсан тэр төрийн байгууллага ажлаа сайн хиймээр байгаа юм. Урьд нь тэнд шалгуулж байсан нөхөр өнөөдөр тэр шалгадаг хүмүүсийг удирдаад сууж байгаа учраас эс үйлдэхүй хийгээд байгаа байхгүй юу. Энийг бүр орон нутгийн байгууллагуудаас энэ мэргэжлийн хяналтад ажиллаж байсан энэ байцаагч нараас та бүхэн бүр тодруулаарай. Тийм учраас би 1 дүгээрт энийг хэлмээр байгаа юм.

2 дугаарт ер нь энэ стандартыг мөрдүүлэх асуудал дээр энэ олон нийтийн хяналтын, энэ олон нийтэд сурталчлах, таниулах ажлыг бид яаж хийх ёстой юм бэ? Өнөөдөр Улаанбаатар хот ширэнгэ боллоо л гэнэ, тэр чинь ямар 5 ханатай гэр барьж байгаа биш нэг шөнийн дотор барьчхаагүй шүү дээ. Тэнд бас л стандарт алдагдсан. Тэгэхээр энэ олон нийтийн хяналтыг энэ стандарт руу чиглүүлэх энэ механизмыг сурталчлах ийм юмнуудыг бид хиймээр юм уу гэж хараад байгаа юм. Сая энэ хэд хоногийн өмнө Цагийн хүрдээр энэ аялал жуулчлалын асуудлууд ярьж байна лээ. Аялал жуулчлалын стандартыг мөрдүүлэх тал дээр юу туссан бэ гэдгийг би асуумаар байна. Жуулчид ирээд ямар ч стандартгүй юманд бид бол учраа олоод яваад байдаг байх. Гаднын өндөр стандарттай газраас ирсэн хүмүүс нүд нь орой дээрээ гараад л явна шүү дээ тэр чинь. Тэгээд бэртэж гэмтээд байна гэж байгаа юм. Тийм учраас энэ аялал жуулчлалын энэ асуудал дээр би энэ зүүн бүс бол аялал жуулчлалын бүс нутаг. Бид жуулчин оруулж ирмээр байгаад байдаг. Тэгэхээр стандартыг нь мөрдүүлэх тал дээр ямар юм туссан байгаа вэ?

Нөгөө талдаа би энийг яагаад асуугаад байна гэхээр төрийн бодлого ингээд нэг залгамж халаатай, уялдаатай явах ёстой. Тэгэхээр Монгол Улсын ЗГ-аас энэ аялал жуулчлалын бизнес нөгөө малчдад олгодог, бусад ЖДҮ-д олгодог ийм хөнгөлөлттэй зээлүүдийг олгоно гэдэг ийм чиглэл гарсан. Тэгээд би энэ хэвээрээ байгаа болов уу гэж бодож байгаа юм. Тэгэхээр тэр зээлийг авсан хүмүүс ямар стандартыг эхнээсээ мөрдөж явах юм бэ гэдгээ ойлгож, тэр бизнес төлөвлөгөө, тэр зээл юмаа авбал яадаг юм бол гэж? Би зүгээр энэ маш өргөн салбарын асуудал учраас энэ хяналтын асуудал, энэ аялал жуулчлалын асуудлыг, олон нийтийн хяналт гэдэг энэ 3 асуудлаар би асууя гэж бодож байгаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Шадар сайд Амарсайхан хариулт өгье.

С.Амарсайхан: Энэ асуудал зөвхөн өчигдөр хууль өргөн бариад өнөөдөр орж ирээгүй гэдгийг та хэд маань та бүхэн маань ойлгож байгаа байх. Энэ сүүлийн

3 жил 21 онд би Шадар сайдын ажлыг аваад хамгийн түрүүн ер нь энэ стандарт гэдэг зүйлээ бид шийдэхгүй бол, нэг мөр ойлгохгүй бол, нэгдсэн ойлголт уялдаа холбоог бий болгож, ялангуяа иргэд, олон нийтийн идэвх санаачилга, шаардлага дээр үндэслэж энэ орчныг өөрчлөхгүй бол бид мянган сайхан хөгжлийн бодлого боловсруулж, зорилт тавиад өчнөөн сайхан мөнгө зарцуулаад энэ хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого 2 хоорондох гүүр болсон стандартыг дагаж мөрдөхгүй бол замгүй явж төөрсөөр байгаад сүүлдээ ажил нь эзэнгүй, асуудал хариуцлага ярихаар явган хэрүүл болдог ийм байхгүйн тулд ажлыг нь эзэнжүүлье, асуудлуудыг нь хариуцлагажуулъя, хариуцлагыг нь стандартжуулъя, стандартыг нь өөрөө зөв хяналттай, гүйцэтгэлтэй болгоё гэж 21 аймаг, 330 сум, 9 дүүрэг нийт улс орон даяар 3 жилийн энэ хугацаанд 2 жилийн хэлэлцүүлэг хийсэн. 17 мянган санал авсан. Эндээс бараг 2 мянган саналыг нь авч, ажлын хэсгүүд дээр байгуулж, нэг улс нэгдсэн стандарт гэдэг хөтөлбөр батлуулсан.

Тэр хөтөлбөрийнхөө хүрээнд өнгөрсөн 24 оны өмнө Засгийн газар дээр хэлэлцүүлэгдэж, бүр 3 намын мөрийн хөтөлбөрт орж, ЗГ-ын 2024-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нэг улс нэгдсэн стандарт гэж тусаж, түүний зэрэгцээ энэ үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бий болгоё гэдэг энэ асуудалтайгаа уялдуулж, эдийн засгийн чадавхаа ч сайжруулъя, эрүүл мэндийн асуудлаа ч цэгцэлье, эрсдэлээ ч багасгая, хаана хаанаа хэзээ ч эцэс төгсгөлгүй хэрүүл хийгээд, өнөөдөр жижиг асуудал гэж явсаар байгаад хамгийн том уул овоо шиг хүндрэл болдог. Өнөөдөр энгийн асуудал гэж явсаар байтал хэн ч дааж давахгүй зовлон болж хувирсан энэ асуудлаа нэг мөр ард иргэдийнхээ оролцоотой болгоод, өдөр тутмын хэл, соёл, дадал зуршил, хэрэгцээ шаардлага, аюулгүй байдал, дээрээс нь хамгийн хатуу шаардлага бий болгоё гэж байгаа юм.

Тиймийн тулд иргэд, олон нийтэд сурталчлах энэ стандартын асуудал, тохирлын үнэлгээний асуудал, аюулгүй байдал. Жишээ нь шошгожилт, бид дэлгүүрт ороод бараа худалдаж авахаар үйлдвэрлэж байгаа ундаа дотоодын үйлдвэрлэлийн ундаануудын 4 хувьтай гээд сахрын багтаамж байхад тэр нь яг шинжилгээ хийхээр 16, 7 хувьтай хэд дахин илүү гарч байгаа ийм эрсдэлүүд байна. Шошгожилтын ажлын хэсэг хүртэл байгуулаад, шошгожилтоо тодорхой болгоё. Эрүүл мэндэд хортой юм уу, сахартай юм уу, эсхүл элдэв харшил өгдөг хүмүүст эрсдэлгүй юм уу гэдгээ хүртэл тэр агуулга найрлага, өөх тос, уураг тэжээл, дээрээс нь эрдэс баялгийнх нь хэмжээг хүн ойлгогдохуйц хэмжээнд, хүн заавал уншиж суугаад байхгүйгээр өнгийг нь хараад худалдаж авдаг энэ хэмжээ рүү хүртэл оръё гэдэг ийм асуудлууд яригдаад одоо хийгдээд явж байгаа юм. Тэгэхээр энэ бол энэ стандарт, хэмжил зүйн салбарын олон жил орхигдож, эзэнгүйдэж ирсэн энэ салбарын маш олон.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмэлт хариулт өгье, 4 дүгээр индэр.

С.Батбаатар: Стандартыг бол хууль дээр хэн ч боловсруулж болж байгаа иргэн боловсруулж болно, мэргэжлийн байгууллага боловсруулж болно, ААН. Тэгэхдээ энэ дээр салбарын бодлогын газар буюу салбарын төв байгууллага бол энэ дээр яам, тамгын газар энэ дээр гол үүрэг гүйцэтгэх ёстой. Аялал жуулчлалын стандарт ингэж жишээ татаад ярихад аялал жуулчлал дээр Монгол Улсад ерөөсөө 15-хан л стандарт байгаа. Олон улсын түвшинд хүрсэн нь 20 гаруй л хувьтай. Тэгээд аялал жуулчлалаа татъя гэвэл бид энэ стандартуудыгаа бүгдийг нь маш сайжруулах хэрэгтэй. Жишээ нь гэхэд БНХАУ-д 2 мянга гаруй аялал жуулчлалын стандарт байна. Энэнээсээ ингээд ямар үйлчилгээ үйлчилгээг, ямар бүтээгдэхүүн

үйлчлэх гэж байгаа гэдгийг ерөөсөө л стандартаар л зааж өгч байгаа. Тэрийгээ яг таг хэрэгжүүлээд явж байгаа, явах ёстой л гэдгийг Идэрбат гишүүн бол яг ингээд тодорхой хэлж байна гэдгийг тодруулаад хэлчихье.

Д.Амарбаясгалан: Идэрбат гишүүн тодруулж асууя.

Ц.Идэрбат: Тийм. Би бол стандартыг мөрдүүлэхийг дэмжиж байгаа. Тийм ч учраас энэ олон, олон энэ харамсалтай үйл явцуудын ард ердөө л стандарт байдаггүй юм гарч ирдэг учраас. Харин бид нэгэнт баталсан бол хэрэгжүүлдэг байх ёстой. Тэгээд Шадар сайдын ажлын алба ч тэр, Шадар сайд ч тэр энэ стандартыг маш сайн ярьж байгаа. Энэ Стандарт, хэмжил зүйн газрынхан ч гэсэн энэ дээр би нэлээн ажиллаж байгаа гэж ойлгоод байгаа. Тийм учраас бидний өнөөдрийн энэ хэлэлцэх эсэх нь дэмжигдээд цаашаа яваад энэ дэмжигдээд ингээд гарвал механизм нь төрийн механизм нь ч байг, иргэдийн механизм нь ч байг. Бид адаглаад төсөв батлахдаа, зам тавихдаа стандартад нийцсэн зам тавьдаг, стандартад нийцээгүй урт, том зам тавьснаас стандартад нийцсэн богинохон зам тавиад цаашаа үргэлжлээд явдаг л болох. Тийм учраас би стандартыг хатуу хэрэгжүүлдэг ийм юм руугаа бид орох ёстой гэсэн ийм санаа байгаа гэдгийг хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Болдын Уянга гишүүн асуулт асууя.

Б.Уянга: Өдрийн мэнд хүргэе. Сая асуулт, хариултуудыг ажиглаад сууж байхад нэг заавал асуух ёстой зүйл байгаад байна тэгээд Шадар сайд хариулах байх. Ер нь стандартыг яг ингээд тоогоор нь хараад үзэхээр аягүй олон байгаад байна тийм ээ? Яг хэрэгжилтийг нь хараад байхаар хангалттай биш ч юм шиг. Тийм болохоороо стандартууд нь олон байх ёстой юм уу, чанартай байх ёстой юм уу, хэрэгжилтийг нь сайн хангуулдаг механизм нь дутуу байгаад байдаг юм уу? Тэгээд энэ дээр нэг тийм яг тооны араас бүгдээрээ явах ёстой юм уу, эсвэл чанарын араас явах ёстой юм уу, хэрэгжилт дээр нь яг яаж анхаарах ёстой вэ гэдэг дээр Шадар сайд өөрийнхөө бодлыг энэ гишүүддээ хуваалцвал их сайн байна.

Энийг яагаад асууж байгаа юм бэ гэхээрээ энэ хуулийн бичиг баримттай, ирсэн гишүүдэд тараагдсан бичиг баримттай танилцахад одоо энэ хуулийн төслөөр стандартын хэрэгжилтэд анхаарна, зөвхөн төрөөс анхаарахгүй, төрөөс анхаарахаас гадна хяналт тавих иргэн байна, үйлдвэрлэгч байна, нийлүүлэгч байна, бүх талын оролцоог хангана гээд ингээд биччихсэн байгаа юм. Яг яаж хангах юм бэ? Нэг ийм жишээн дээр аваад танилцаач. Жишээ нь ингэвэл бүх талын оролцогчид ингэж хяналт тавих юм гээд.

2022 онд энд танилцуулгад дурдсанаар 159 стандартыг хүчингүй болгох, 1067 стандартыг олон улс, бүс нутгийн жишигт нийцүүлэн шинэчлэх шаардлагатай гээд мэдээлэл өгчихсөн байгаа. Тэгтэл өнөөдөр 204-ийг нь буюу 20 хүрэхгүй хувийг нь л шинэчлэн баталсан гэсэн мэдээлэл гишүүдэд тараагдсан байна. Тэгэхээр ер нь энэ ажлыг яг хэн хийх ёстой юм бэ? Стандартыг баталдаг нь болохоор яг мэддэг хүмүүс нь стандартуудыг нь бичиг баримтыг нь бэлдээд, тэгээд танай газар бол өөрийнхөө процессоороо баталдаг гэж ойлгодог юм. Гэхдээ нэг л тийм сул байгаа орчин учраас л хэрэгжүүлэх шаардлагатай байгаад байдаг, хэрэгждэггүй учраас л энэ хуулийн төсөл шинэчилсэн найруулга байдлаар орж ирж байна гэж үзээд, ер нь дэмжиж байна. Тэгэхдээ өмнөх хэлсэн агуулга дээрээ та, ажлын хэсгээс саналыг сонсмоор байна.

Тэгээд яах вэ зүгээр хуулийн энэ төслийн цааш цаашдаа олон л хуулиуд Их Хурлын гишүүдээр орж, Их Хурлаар орж ирэх байлгүй. Энэ бичиг баримтын бүрдэл, агуулга дээрээ маш сайн анхаарах хэрэгтэй байна. Ер нь энд сууж байгаа гишүүд үг бүрчлэн уншдаг шүү гэдгийг дахин нэг сануулахыг хүсэж байна. Жишээ аваад үзвэл үзэл баримтлал дээр өнөөгийн практик шаардлага гэдэг хэсэгт өнөөгийн байдлаар Монгол Улсад 6525 стандарт хүчин төгөлдөр байна гэххэж байгаа. Тэгснээ танилцуулга дээрээ 6730 гээд биччихэж байгаа юм. Тэгснээ дэлгэрэнгүй танилцуулга дээрээ 6733 гээд. Тэгээд тэгэхдээ сая Шадар сайдын танилцуулгаас 6730 гэхээр тэр тоо нь зөв юм байна гээд ингээд бодох жишээтэй. Тэгэхээр наад захын энэ 10 хүрэхгүй хуудсанд байгаа тоонуудаа ингээд жигдлээд орж ирэх хэрэгтэй. Тэгэхдээ ер нь хуулийн төслийг дэмжиж байна. Тэгээд саяын асуудлуудад Шадар сайдаас ерөнхий агуулга дээр нь, тэгээд сүүлийн тэр тоон дээр асуусан асуудал дээр тэгээд өөр бусад нэмэлт хариултуудыг авахыг хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Шадар сайд.

М.Амарсайхан: Уянга гишүүний ярьсан асуулт. Жишээ нь эрүүл мэндийн байгууллагад бид 680 стандарт батлагдсан байдаг. Гэтэл өнөөдөр 407-г нь шинэчлэх шаардлагатай, хэрэгждэггүй. Эмчилгээний арга зүйгээс эхлээд эм, тарианы стандарт, орц найрлага, тэгээд яаралтай түргэн тусламжийн машин тэргээс эхлээд, анхны түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэх, анхан шатны үйлчилгээнээс эхлээд, нарийн оношилгоо, эмчилгээний шат хүртэл стандартууд нь байр сав нь ч шаардлага хангадаггүй, эмч, сувилагчид нь хангая гэсэн ч орчин нөхцөл нь бүрдээгүй байдаг ийм нөхцөл бий.

Барилгын салбарт үндсэндээ бидэнд нийтдээ 642 стандарт байна. Тэгвэл энэний 400 гаруй нь хэрэгжихгүй байгаагаас өнөөдөр байр сав амьдралаа барьцаалаад үр хүүхдийнхээ хэдэн үеийн ирээдүйг барьцаалаад авсан орон сууц нь орж амжаагүй байхад шатдаг, нурдаг, ус, цахилгаан алддаг ийм эрсдэлүүд байна. Сүүлдээ ч асуудлууд нь хүндэрдэг ийм зүйлүүд бий. Тэгэхээр энэ Барилга, хот байгуулалтын яам жишээ нь энэ 404 стандартаа иргэн, ААН-үүдтэй мэргэжлийн байгууллагуудтай хамтраад шууд боловсруулж, олон улсын стандарт жишигт нийцүүлээд, дотоодын онцлогтойгоо уялдуулж хийх ёстой хэрэгцээ шаардлагатай. Эрүүл мэндийн яам энэ батлагдаагүй хэрэгцээ шаардлага хангахгүй байгаа 400 гаруй стандартаа яаралтай хувийн хэвшил, хувийн эмнэлгийн эрүүл мэндийн байгууллага, шинжлэх ухааны байгууллага, эрдэмтэн судлаачид, эмч, сувилагчтайгаа, үйлчлэгчтэйгээ нийлээд энийгээ боловсруулах ёстой үйлчилгээний стандартаасаа эхлээд.

Хэн, яаж хэрэгжүүлэх юм бэ гэдэг энэ зөвхөн хууль батлах бичдэг бичиг баримтын асуудал огт биш. Энэ хууль хэрэгжүүлэх боломжийг нь орчин нөхцөлийг нь бүрдүүлэхээс гадна салбар салбарт нь бид хариуцлагыг нь даалгаж, төрийн хяналтаа ч тавина, дотоод хяналтаа тухайн байгууллага, иргэн тавих ёстой. Жишээ нь мах, сүүний үйлдвэр бол үйлдвэрлэлийн дотоод эрүүл ахуй, аюулгүй байдал, стандартын хяналт, лабораторио өдөр тутам хяналтаа хийдэг, тэрийгээ баталгаажуулдаг. Жишээ нь хүнсний аюулгүй байдал лавлагаа лаборатори бол хүнсний чиглэлээр түүврийн шинжилгээгээ хийх ёстой. Өнөөдрийн байдлаар хийж байгаа шинжилгээнүүд саяхныг хүртэл намайг энэ асуудал ажлыг аваад явж иртэл зөвхөн ААН-үүд авч ирвэл лавлагаа лабораторийн үйл ажиллагаа явуулдаг. Тэгээд ирэхгүй бол тэр хэн, ямар бүтээгдэхүүн тухайн лабораториор оруулаад явж байгаа нь хяналтгүй юм явдаг байсан бол одоо орон даяар түүврийн шинжилгээ хийдэг

болсон гэх мэтээр ингээд тухайн иргэн, ААН асуудлуудаа өөрсдөө үйлчилгээ хэнд, ямар аюулгүй байдлын үйлчилгээ нийлүүлж байгаа юм гэдгээ өөрсдөө авсан стандартаараа дагаж заавал мөрдөж баталгаажуулна. Тэрийг нь хөндлөнгийн стандартын итгэмжлэлийн байгууллагууд хувийн ААН-үүд бий, мэргэжлийн байгууллагууд итгэмжилж баталгаажуулна. Дээрээс нь төрийн хяналт давхар хянаж байх ёстой. Энэ бүгд уялдаж байж энэ өөрөө хэрэгжинэ. Тэрнээс ганцхан хүн, нэг байгууллага, нэг төрийн байгууллага энийг бүрэн хянаж.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмэлт хариулт өгье, 4 дүгээр индэр.

С.Батбаатар: Уянга гишүүний асуултад тодруулъя. Ер нь стандартын тоо 6733 гээд стандартын тоо хэлээд байгаа энэ их юм шиг санагдаад. Олон улсын түвшинд ингээд аваад үзвэл БНХАУ гэхэд 14 мянган стандарттай, ОХУ гэхэд 44 мянган стандарттай, Канад улс гээд тэгэхэд 180 мянган стандарттай, АНУ гэхэд 200 гаруй мянган стандарттай, Европын холбооны улсууд 25-аас 28 мянган стандарттай байдаг ийм тоон мэдээлэл байдаг. Стандартын тоо бол өөрөө өөрчлөгдөж байдаг. Энэ жил ингээд аваад үзэхэд манайх нийтдээ 59 стандарт баталсан, тодорхой тооны стандартыг хүчингүй болгосон. Өнөөдөр л, өчигдөр л гэхэд би 3 стандарт батлаад л гарч байгаа юм. Энэ тоо динамик учраас байнга өөрчлөгдөөд явдаг юм шүү гэдгийг энд хэлэх нь зүйтэй болж байна. Тэгээд стандартыг шинэчлэх ажлыг бол боловсон хүчний ажил, салбарын манлайллын асуудал байна. Дээрээс нь хөрөнгө мөнгө, хүч, мэргэжлийн байгууллагуудын тэр оролцоо. Аль түрүүний хэлдэг тэр 7 категориос хүмүүсээ татаж оролцуулаад шинэчлэх асуудлыг энэ хууль дээр тодорхой хэмжээнд тусгаж өгсөн.

Д.Амарбаясгалан: Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн асуулт асууя.

Д.Үүрийнтуяа: Та бүхэндээ өдрийн мэнд хүргэе. Хуулийн үзэл баримтлал дээр ЗГ-ын 218-н 200, 2018 оны 291 дүгээр тогтоолыг дурдсан байна л даа. 644 нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний тохирлын үнэлгээг заавал хамруулах шаардлагатай байгаа гээд. Ер нь тохирлын үнэлгээнд заавал бүгд хамрагдах ёстой юм уу гэдэг зүйл практик дээр гарч ирээд байна шүү дээ. Та бүхэнд олон байгууллагаас энэ саналууд очиж байсан байх. Би нэг жишээ авч хэлье. 2018 онд баталсан энэ журмаар орсон бүтээгдэхүүн дотор зэсийн баяжмал байгаа. 2024 оны 1 сарын 24-ний өдрийн Шадар сайдын 10 дугаар тушаалаар батлагдсан журам дээр зэсийн баяжмалд тохирлын үнэлгээ авахад үнийг нь 3 дахин нэмэгдүүлсэн. 4500 тонн тутамд нэг тохирлын үнэлгээ авдаг байсныг 500 тонн тутамд нэг тохирлын гэрчилгээ авдаг болгож өөрчилсөн. Жилд тохирлын гэрчилгээ авахын тулд 20 сая төгрөгийн зардал гардаг байсан бол өнөөдөр жилдээ 200 сая төгрөгийн зардал гарч байна. Шаардлагатай бол гаргая хамаагүй зардлыг нь.

Гэтэл энэ тохирлын гэрчилгээг хаана ашиглаж байна, хаана ч ашиглагдахгүй, баахан цаас, баахан хөдөлмөр, 200 сая төгрөг хийгээд л дараа нь устгадаг нэг ийм цаастай боллоо. Бодит байдал ийм байна шүү үнэнийг хэлэхэд. Яагаад гэхээр зэсийн баяжмалыг экспортод гаргахад Геологийн төв лаборатори, мөн Гаалийн ерөнхий газрын дэргэдэх лабораториор шинжилгээ хийгдээд уул уурхайн бүтээгдэхүүний борлуулалтад төрөөс тавих хяналтыг хэрэгжүүлээд яваад байгаа юм. Төрөөс тавих хяналтыг хийж байна гэвэл үүнтэй давхардаад байна 1. 2-т худалдан авагч талаас чанарын хяналт гэж үзвэл Лондоны металлын биржид бүртгэлтэй олон улсын лабораториудаар энд чанарын хяналтуудыг хийлгээд, баталгааныхаа дүгнэлтүүдийг бүгдийг нь гаргаад аваад явж байгаа. Яг үнэндээ энэ

тохирлын гэрчилгээ хаана ч ашиглагдахгүй байна. Хаана ч хэрэглэхгүй байна. Гаалийн ерөнхий газрын лабораторийн дүгнэлтээр үндэслээд АМНАТ-ыг тооцоод явчхаж байгаа юм. Тэгэхээр ер нь энэ тохирлын үнэлгээ гэдэг зүйл чинь заавал бүх бүтээгдэхүүнд байх ёстой юм уу 1 дүгээрт?

Ер нь стандартыг ойлгож байна. Стандарт, техникийн зохицуулалт 2 бол нэг нь заавал дагаж мөрдөх, нөгөөдөх нь дагаж мөрдөх баримт бичгээ гээд хуулийн төсөл дээр орсон байна лээ. Тохирлын гэрчилгээ маань үндсэндээ тодорхойлсон шаардлагад нийцэж байгаа эсэхийг тодорхойлсон баримт бичиг буюу зөвшөөрөл олгодог баримт бичгийн хэлбэр лүү шилжчихсэн байна шүү дээ. Тэгээд энэ чинь өөрөө эргээд нөгөө аж ахуйн нэгж, байгууллагадаа дарамт болоод байгаа юм биш үү, хий дэмий ажил болоод байгаа юм биш үү? Ер нь энэ төрийн байгууллагуудын давхардсан хяналт, төрийн оролцоотой давхардсан үйл ажиллагааг багасгах чиглэлээр энэ хуулийн үзэл баримтлал, хуулийн төсөлд ер нь хэрхэн яаж тусгасан юм бэ? Олон улсын зах зээлд одоо үйл ажиллагаа явуулдаг тухайлбал уул уурхайн бүтээгдэхүүн олон улсын зах зээл дээр борлуулахад баримталдаг нийтлэг зарчмыг баримтлаад итгэмжлэгдсэн лабораторитой тухайн аж ахуйн нэгж өөрөө, олон улсын итгэмжлэгдсэн лабораторитой, гадна талдаа итгэмжлэгдсэн лабораториор худалдан авагч нь авч байгаа. Төр өөрөө хяналтаа хийчхэж байгаа. Ийм олон хяналтын давхардал байхад тохирлын гэрчилгээг үүнд орлуулан тооцдог механизм байж болдоггүй юм уу?

Дараагийн асуудал 2 дахь асуулт бол стандарт тогтоож байгаа бүрэлдэхүүн өөрөө техникийн хороод тогтоож байгаа тийм ээ. Яг энэ техникийн хороодын нарийвчилсан зүйл, заалт хуулийн үзэл баримтлалд ч тэр, хуулийн төсөл дээр алга байна. Ер нь стандарт тогтоож байгаа бүрэлдэхүүн маань өөрөө стандартын шаардлага хангаж байгаа юм уу? Энд ямар бүрэлдэхүүн орох ёстой гэдгийг нарийвчлан зааж өгөхгүй юм уу? Мэргэжлийн хувьд, туршлагын хувьд, ур чадварын хувьд нарийн төвөгтэй стандарт, техникийн тодорхойлолт, техникийн шаардлагыг тавих гэж байгаа энэ бүрэлдэхүүн өөрөө.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Шадар сайд хариулт өгье.

С.Амарсайхан: Стандарт баталж байгаа бүрэлдэхүүн өөрөө шаардлага хангаж байгаа юм уу гээд. Би энэ салбарыг хариуцаж байгаа хүний хувьд үгүй гэж хэлнэ. Дээрээс нь энэ тохирлын үнэлгээтэй холбоотой хэд хэдэн юунууд бий л дээ үзүүлэлтүүд гэдэг юм уу асуудлууд. Жишээ нь аюулгүй байдал, хэрэглээний баталгаа, итгэлцэл, дээрээс нь хууль ёс, дүрэм журам гэдэг юм уу, тэрнээсээ илүүтэй зах зээлийн зарчмаараа захирагдах ёстой ийм тогтолцоонууд байхгүй байгаад байна. Тийм учраас энэ асуудлуудыг бид цэгцэлье гэж энэ хуулийг оруулж ирж байгаа юм. Жишээ нь хүнсний аюулгүй байдал, эрүүл мэнд, тэгээд үндэсний аюулгүй байдалтай холбоотой салбарууд дээр зайлшгүй тохирлын гэрчилгээ авах ёстой. Импортоор авч байгаа, экспортолж байгаа ААН-үүд улс орнууд ч энийг шаарддаг.

Тодорхой уул уурхайн бүтээгдэхүүн саяын Үүрийнтуяа гишүүний ярьсан зэсийн баяжмал, төмрийн хүдэр, нүүрсний асуудал гэдэг бол олон улсад тодорхой, зах зээл нь ойлгомжтой, орц найрлага нь ч тодорхой байдаг асуудал дээр бид иймэрхүү зүйлүүдийг эргэж харах ёстой. Дундуур нь янз янзын нугалаа явж байхыг үгүйсгэхгүй. Тэгэхээр хаана хаанаа хэн нэгний мэдэх, мэдэхгүй тайлбар хэлж, тодорхой хуулиудаа дундуур нь ойлгомжгүй болгодог, уялдаа холбоогүй байдаг ийм

нөхцөл байдлыг цэгцэлье гэж л энэ хуулийн үзэл баримтлал, үндсэн судалгаа, хуулийн зүйл, заалтуудыг оруулж ирж байгаа. Хууль өөрөө 34 орчим 8 орчим зүйл, заалттай ингэж шинэчлэгдэж орж ирж байгаа. Тэгэхдээ энэ бол бүх юм болчихсон гэсэн үг биш. Энийг ажлын хэсэг байгуулагдаад гишүүдийн оролцоотойгоор илүү цаашаа нарийн санаанууд тусгагдах ёстой гэж бодож байгаа. Хууль, эрх зүйн орчнуудтайгаа уялдуулах зүйлүүд бий.

Ер нь түрүүн би хэлсэн дээ. Энэ стандарт баталж байгаа техникийн хороо, батлуулж байгаа хүмүүс хоорондоо өөрсдөө мэргэжлийн байх, илүү чадварлаг байх, илүү ёс, суртахуунтай байх, илүү нийгмийнхээ эрх ашгийг боддог байх. Тэгэхийн тулд хувийн хэвшил, аж ахуйн нэгж, хөрөнгө оруулагчид, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдаас эхлээд, эрдэмтэн судлаачид, энэ судлаачид, шинжээчдээ оролцуулж, шинжлэх ухааны ул суурьтай, амьдралд нийцсэн, асуудлын гүнд орсон ийм тогтолцоог л бий болгохгүй бол өнгөцхөн харж явсаар байгаад энэ өөрөө техникийн хороо нь хүртэл нэг хэлбэрийн болчихсон асуудлууд бий. Энийг дахин энэ хууль шинэчлээд гараад ирэхээр бид магадлан итгэмжлэх, чадамжийг нь шалгуулах, тэрийг хэн, ямар салбарын, ямар стандартыг батлаад байгаа юм гэдгийг олон нийт нээлттэй харж байж, ил тод хяналтаа тавьдаг, буруу, зөвийг нь шүүдэг хүртэл тийм иргэдийн хяналт руу оруулъя л гэж байгаа юм тогтолцоо руу. Ингэж байж бид стандартыг өдөр тутмын хэрэгцээ, шаардлага болгоод зогсохгүй, бүүр ийм зарчим бөгөөд амьдралын хэмнэл болгоё, соёл болгоё л гэж байна. Шинэ соёлыг тогтооё гэж байгаа юм. Хуулиараа дамжуулж, энэ тогтолцоогоороо дамжуулж.

Д.Амарбаясгалан: Нэмэлт хариулт 4 дүгээр индрээс өгье.

С.Батбаатар: Үүрийнтуяа гишүүний асуултад товчхон хариулъя. Энэ батлаад байгаа стандарт чинь стандартынхаа шаардлагаар хангаж байгаа юм уу гэдэг асуулт. Олон улсын ISO-ийн байгууллагаас бидэнд бол guide болоод бид зөвлөмж, дүрмийг нь дагаж ажилладаг. Тэгэхээр олон улсын стандарт бол MNS 1.1, 1.2-ын дагуу бид техникийн хорооны бүрэлдэхүүн, техникийн хорооны хурлын холбогдох дүрэм, журмыг бүгдийг нь дагаж барьж ажиллаж байгаа гэдгийг хэлье.

Тохирлын гэрчилгээний асуудлыг зөвшөөрөлтэй холиод явчихлаа. Энэ бол тохирлын гэрчилгээ чинь тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээ стандартад тохирч байна уу, үгүй юү гэдгийг л нотолж гаргаж ирж байгаа юм. Тэрнээс бол энэ бол ерөөсөө тэр зөвшөөрөл биш гэдгийг бас энэ дээр ойлгох ёстой. Аль түрүүн тэр зэсийн баяжмалын асуудал байна. Олон улсын зэсийн баяжмал дээр 500-аас 600 тонн нэг удаагийн тохирлын гэрчилгээ олгож, тэрийг хил гаалиар гаргах тийм дүрэмтэй байдаг гэдгийг нь энэ дээр дурдсан нь зөв байх гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Энэ стандарт дээр гишүүд нэг зүйлийг их сайн ойлгомоор байгаа юм. Хэдий хэр хэмжээний олон тооны стандарттай улс байна, тэр улс төдий чинээ их хүний эрхийг зөрчихгүй, үндсэн эрхийг нь зөрчихгүй, эрүүл, аюулгүй орчинд амьдруулах боломжийг нь олгож өгч байна гэдэг л ойлголт. Манай Монгол Улсад байгаа 6700, 6800 стандартын 50 хувь нь хэрэгжилттэй байна гэдэг нь өөрөө бид хүний эрхийг хангах тал дээр төдий чинээ сул байна гэсэн үг болчихож байгаа юм. Дээрээс нь аливаа төрлийн стандартыг шинэ тутамд нэвтрүүлж чадахгүй байна гэдэг бол бидний хувьд үндсэндээ зах зээл дээрээ нэлээн хоцрогдолтой явж байгаагийн том илрэл юм байна.

Дэлхийд Канад улс хамгийн олон тооны стандарттай гэж байгаа юм. Канадын энэ олон тооны стандарттай болсон үндсэн шалтгаан бас л 1980-аад, 70-аад оны сүүл, 80-аад оны эхэн үеэс энэ хүний эрхийн асуудлыг илүү их хөндсөн, хүний эрхийг хангах чиглэлээр баталсан хууль тогтоомж нь Үндсэн хуулийн ар дээр бичигддэг том хууль. Тэрний хэрэгжилтийг хангахын тулд нийгэмд стандартыг бүрэн дүүрэн бүх түвшинд нэвтрүүлэх гэдэг зорилгыг тавьсан дээрээс өнөөдөр 140, 50 мянган стандарттай болчихсон зүйл болчихож байгаа юм. Нөгөө талдаа Монголд нэг асуудал байсан нь мэргэжлийн хяналт гэдэг нэг айхтар ойлголт байсан. Ерөөсөө л мэргэжлийн хяналт бүгдийг нь хянадаг юм шиг, мэргэжлийн хяналт бүх стандартыг нь мэддэг юм шиг л ойлгож, хүлээж авдаг байсан. Харамсалтай нь бид мэргэжлийн хяналтын байгууллага муудсан махыг очоод чанаж идэж байхыг харсан шүү дээ. Тэр өөрөө стандарт биш, тэр өөрөө ямар хяналт тавьж байгаа гэдэг ойлголт байхгүй болж эхэлсэнтэй холбоотой асуудал байж байгаа.

Уг нь анх мэргэжлийн хяналтын байгууллага зорилго нь зөв тавигдаад салбар салбарын мэргэжлийн хүмүүсээр бүрдсэн хяналтын байгууллага гэж бүрдсэн чинь хөгжлийнхөө явцад 20 жилийн дараа салбарын бус хүмүүс салбарт хяналт тавьдаг болж эхэлсэн. Тэр нь өөрөө нөгөө авлига, нөгөө хүнд суртал гэдэг зүйлийн чинь үндэс нь болсон. Сүүлдээ мэргэжлийн хяналтын байгууллагын талаарх ойлголт олон нийтийн дунд маш сул болсон. Судалгаа явуулаад үзэхэд судалгаанд оролцож байгаа иргэдийн 15-хан хувь нь мэргэжлийн хяналт байх ёстой гэж үзэж байгаа юм. Тэгэхээр бид эхлээд хяналт тавина гэхээсээ илүүтэйгээр байх ёстой стандартыг нь гаргаж өгч чадвал тэр стандартыг дагаж мөрдөх гэдэг нь өөрөө хувь хүн, иргэн, аж ахуйн нэгж, төрийн байгууллагын үүрэг болж эхэлж байгаа юм.

Өнөөдөр амьдрал дээр тохиолдож байгаа явдал гудамж талбайн засалт тохижилттой холбоотой асуудлыг иргэд байнга шүүмжлээд ярьж л байдаг. Хот, дүүргийн удирдлагууд, ажил хариуцаж байгаа хүмүүс нь өөрчлөлт, шинэчлэлт, сайжруулалтыг хийгээд явж л байдаг. Гэхдээ энэ бүгдийн цаана үзэмжээр биш, ийм байх ёстой гэж үзэхээрээ биш, одоо тулгаад өгчихсөн байгаа стандартын дагуу хийж чадаж байна уу, үгүй юу гэдгээрээ хяналт тавьдаг тэр зүйлийг бид гаргаж өгөх нь их чухал гэдэг үүднээс энэ хуулийн төсөл бол 2022 оноос хойш бэлтгэгдэж, өнөөдөр ингээд Улсын Их Хурлаар орж ирж хэлэлцэгдэж байгаа. Үүрийнтуяа гишүүн тодруулж асууя.

Д.Үүрийнтуяа: Шадар сайд энэ үүсээд байгаа асуудалд ойлгож хандаж байгаад талархалтай байна. Ажлын хэсгийн хариулж байгаа хариултад уучлаарай, би нэг зөвшөөрөл, гэрчилгээ хоёроо одоохондоо ялгахтайгаа. Тэгээд асууж байгаа юм. Танай олгож байгаа тохирлын гэрчилгээ зөвшөөрлийн хэлбэртэй болчихоод байгаа байхгүй юу амьдрал дээр. Энэ чинь нийцэхгүй байна гэдгийг би хэлээд байгаа юм. Энийгээ өөрчлөх юмаа хуульдаа оруулаач энэ шинэ хуульдаа. Стандарт батлаад байгаа, тэр стандарт боловсруулаад байгаа техникийн хороод чинь стандартын шаардлага хангаж байгаа юм уу гэж би яагаад асуугаад байгаа юм гэхээр тэр заалт чинь хуулийн төсөлд чинь байхгүй байгаад байна шүү дээ. Хуулийн үзэл баримтлалд чинь байхгүй байгаад байна шүү дээ. Олон улсын байгууллагын зөвлөмжийг мөрдөж дагаж болно. Тэрийгээ үндэсний стандарт, үндэсний мөрдөх дүрэм журам болгоё гэж байгаа юм бол хуульчил л даа. Хэн нэгэн дуртай хүн нь тэрийг нь аваад өөрчилдөг байж болохгүй биз дээ? Стандарт байх ёстой юу байх ёстой. Түүнийг хэрэгжүүлэгч нь дахиад өөрөө.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ганбатын Очирбат гишүүн асуулт асууя.

Г.Очирбат: Гишүүддээ өдрийн мэнд хүргэе. Энэ стандартчилал, техникийн зохицуулалттай холбоотой энэ хууль бол их чухал хууль байгаад байгаа юм. Тэгэхдээ энэ дээр яг энэ хуулийн хэрэгжилтийн үр дүнгийн судалгааг хэрхэн яаж, ямар салбараар хийсэн бэ гэдгийг хамгийн түрүүнд сонсмоор байгаа юм. Хөнгөн үйлдвэрлэл, хүнд үйлдвэрлэл, үйлчилгээний салбар, иргэд, мэргэжлийн холбоод тэндээс ямар санал, дүгнэлтүүд гарсныг сонсмоор байгаа юм. Яагаад гэхээр энэ стандарттай холбоотой асуудал бол өөрөө дандаа ардаа эдийн засагтай холбоотой байдаг. Бид ISO 9001-ийг нэвтрүүлэх ISO 22000-г нэвтрүүлэх 2 шал өөр. Энэ манай стандартынхан сууж байна, ... үзээгүй байх, шал өөр асуудал. Тэгээд ард нь дандаа эдийн засаг нь дагаж явдаг. Тэгэхээр Амарсайхан сайд энэ дээр сүүлийн 2, 3 жил ажилласан байх гэж би бодож байна хувь гишүүнийхээ хувьд. Тэгээд бид ингээд стандартыг ингэж хатуу тавих тусам манай эдийн засаг ямар байгаа билээ, манай аж үйлдвэрийн салбар ямар байгаа билээ, үйлчилгээний салбар чинь ямар байгаа билээ, тэгээд энэ зохицох уу, зохицохгүй юу?

Дараагийн асуудал. Бас нэг харамсалтай юм байгаад байгаа юм. Уг нь энэ хуулийг ингээд 3 удаа шинэчилсэн байгаад байгаа юм. Тэгээд нэг юмыг ингээд авч яваад байсан байхгүй юу. Стандартыг сонгон хэрэглэх баримт бичиг гэдгийг авч яваад байсан юм. Тэгээд энэ дээр болохоор энэ шинэчилсэн найруулга дээр стандартыг иргэн, хуулийн этгээд дагаж мөрдөх баримт бичиг байхаар тусгачхаад байгаа юм. Тэгээд энийг аягүй тодорхой хэлээд өгчихмөөр байгаа юм. Тэгж байж нөгөө гаднын хөрөнгө оруулагчид чинь, дотоодын хөрөнгө оруулагчид чинь үйлдвэрлэлийн салбарт, үйлчилгээний салбарт шинээр орж ирэх гэж байгаа хүмүүс аль стандартыг бариад байгаа юм гэдгээ харах ёстой. Бид Японы хасабыг нэвтрүүлэхэд хэдий хэмжээний хөрөнгө оруулалт хийх гээд байгаа юм. Магадгүй ISO 9001-ийг нь зөвшөөрөөд явах юм уу, 22 мянгаа бариад байгаа юм уу гэдэг дээр хардаг болохоор яагаад энэ ингэж бодитой ингэж оруулж ирсэн юм бэ гэдэг дээр нэг хариулт авчихмаар байгаад байгаа юм.

Стандартыг хэрэгжүүлнэ гэдэг чинь Монгол Улсад асуудал болчихоод байгаа шүү дээ. Яг өнөөдрийн нөхцөл байдал бол. Асар олон стандартууд байдаг, бүгд ярьдаг, социализмын үеэс авхуулаад явсан, шинээр үйлчилгээний салбар, үйлдвэрлэлийн салбарт нэвтрүүлсэн стандартууд ингээд л явдаг. Тэрийг нь ингээд батлаад өгөөд л ингээд явдаг, анхны юмнууд болохоор батлахаас өөр арга байхгүй ингээд явдаг. Хэрэгжилт нь ямар байгаад байгаа юм бэ? Энэ чинь л хамгийн чухал. Энийгээ л яаж сайжруулах юм. Ингээд чадвал бид эхний стандартыг давбал дараагийн хөрөнгө оруулалт хийгдээд л, дараагийн стандарт ингээд л явдаг, олон улсын жишиг ерөөсөө тэр шүү дээ. Яагаад энэ Канадууд, одоо энэ Хятадууд стандартыг аягүй сайн мөрдүүлээд байна гэдэг чинь бусад улс эх орнуудыг манай юмыг худалдаж ав гэж тулгаж байгаа шүү дээ. Хамгийн энгийнээр бол. Энэ бол хүний эрүүл ахуйн шаардлагыг хангачихсан юм. Энэ бол технологийн давуу талыг шингээчихсэн юм. Энэ шинэ know how, шинэ инновац ороод ирчихсэн юм, энийг авах ёстой, яагаад гэвэл энэ энийг хийгдсэн. Тэгээд бусад дэлхийн орнуудтай л тэр худалдан авалтыг нь энэ стандартчиллаар дэмжиж цаашаа явж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ тал дээр ямар судалгаа байгаад байгаа юм бэ? Үндсэн 4 асуулт асуучихъя, тэгээд тодруулъя даа.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Шадар сайд.

С.Амарсайхан: Стандарт өөрөө сая Очирбат гишүүн хэллээ, зүгээр ер нь бүтээгдэхүүн, үйлчилгээний аюулгүй байдал, цаашлаад энэ үндэсний аюулгүй байдал, тэгээд найдвартай сэтгэл ханамжийн үндэс болдог гэдгээрээ бид асуудалд хандаж энийг нэлээн тийм зоригтой өөрчлөхгүй бол яг өнгөрсөн хугацаанд энийг шаардчихвал хөрөнгө оруулалт нь байхгүй учраас яах вэ тэгсхийгээд яваг, энийг хийчихвэл энэ хүн, энэ компани чадахгүй учраас тэгээд л нэг оромдоод яв гэсээр байтал эргээд хэнд ч итгэх итгэл энэ нийгэмд хэрэглээний талаасаа, бүтээгдэхүүн, үйлчилгээний талаасаа бараг байхгүй болчихлоо гэж. Мэдээж бүгд хар зүйл, болохгүй зүйл байхгүй гэж байгаа биш. Энэ стандарт шаардлага хангаж байгаа олон үйлдвэр, аж ахуйн нэгж, дотоод, гадаадын ААН үйлдвэрүүд байна, үйлчилгээнүүд байна, чадах ядахаараа л зүтгэж байна.

Тэгэхдээ энэний цаана өөрөө энэ эдийн засгийн үр дагавар мэдээж байгаа. Тэгэхдээ бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар буурах, итгэл сулрах нь иргэдэд хохиролтойгоос хажуугаар бизнест хохиролтой байх уу, эсвэл стандартаа мөрдөөд, зах зээлээ тэлээд илүү урт хугацаанд, тогтвортой иргэд, хэрэглэгчдийн итгэл үнэмшилд нийцсэн бараа, бүтээгдэхүүн сэтгэл ханамжуудыг бий болгодог үйлчилгээ байх уу гэдэг талаасаа бизнес нь ч бодох ёстой, ААН нь ч бодох ёстой 1 дүгээрт, төрийнх нь ч бодох ёстой.

2 дугаарт энэ судалгаа шинжилгээний ажлыг бол ер нь бүх салбарын оролцоотой бид хэсэг хэсгээр өнгөрсөн 2 жилийн хугацаанд 21 аймаг энэ үндэсний хэмжээнд зохион байгуулсан. Худалдаа, аж үйлдвэрийн танхим, тэгээд төрийн бус байгууллагууд. Одоо гэхэд яг энэ Стандартын хуулийн шинэчлэлт, хэрэгжилт дээр энэ Канад бид, Англи, БНХАУ, тэгээд бусад энэ хөгжингүй улс орнуудтай хамтарч ажиллаад, өнөөдөр гэхэд энэ хөгжингүй улс орнуудын яг энэ чиглэлийн 2 зөвлөх ирчихсэн Стандарт, хэмжил зүйн газар дээр энэ шинэчлэл, өөрчлөлттэй холбоотой олон улсын стандартад нийцүүлэх, үндэсний онцлогтой уялдуулах энэ ажлуудаа хийгээд явж байгаа. Сая хэллээ энэ БНХАУ ч бай, манай хөрш ч бай, ер нь хөгжингүй улс орнуудын хөгжсөн нууц биш нууц нь өөрөө стандарт. Тийм учраас бид Герман стандарт гэж ярьдаг, Япон стандарт гэж ярьдаг, бүүр Америк стандарт гэж ярьдаг, урд, хойд хөршүүдийнхээ стандартыг ч ярьдаг. Тэгсэн мөртөө өөрсдөө тэрийгээ шаардаж чаддаггүй, хангаж чадахгүй явсаар байгаад өрсөлдөх чадваргүй болж байгаа. Бүх эрсдэлүүд бий болчихсон. Алхаж байгаа газар, амьсгалж байгаа агаар, амьдарч байгаа орон сууц, ажлын байрнаасаа эхлээд бүгд эргэлзээтэй болчихоод байгааг л энэ тогтолцоо, хамтын ажиллагаагаар иргэдийн оролцоотой өөрчилье гэж ингэж яваад байгаа нь энэ л дээ. Тийм.

Д.Амарбаясгалан: Нэмэлт хариулт өгье, 4 дүгээр индэр.

С.Батбаатар: Үр нөлөөллийн үнэлгээ дээр энэ бол маш тодорхой хэлсэн. Нэр томьёо буюу энэ хуулийн ойлголтыг олон нийтэд ойлгомжтой болгож өөрчлөх шаардлагатай, чиг үүргийн давхардлын асуудал гарч ирсэн. Дээрээс нь итгэмжлэлийн байгууллагын чиг үүрэг, статусыг тодорхой бус байсан гэж хэлсэн. Мэдээллийн нэгдсэн сан зохицуулалт ерөөсөө байхгүй байна. Тусгай зохицуулалт хуулиараа зохицуулаагүй байна гэж хэлсэн. Тохирлын үнэлгээний байгууллагын нарийвчилсан асуудал байхгүй байна. Салбар дундын зохицуулалт нөгөө техникийн хорооны гишүүдийн хэлээд байгаа техникийн хорооны асуудал энэ дээр бас тусгагдаж өгсөн гэдгийг хэлье.

Стандартын хэрэгжилтийн асуудал дээр энэ 22 яам, 30 гаруй агентлагуудаас стандартын хэрэгжилтийн асуудал дээр хэдүүлээ 24 онд ингээд стандартынхаа хэрэгжилтийг гаргаж өгөөч гэсэн. 2 яам, тамгын газраас бусад нь стандартынхаа хэрэгжилтийг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Очирбат гишүүн тодруулж асууя.

Г.Очирбат: Тийм, энэ стандарт үнэхээр чухал л даа. Тэгээд хамгийн бодит жишээ бол та бүхэн маань бүгд л мэдэж байгаа. Олон улсын стандартыг авч хэрэгжүүлдэггүй мөртөө манай Тавантолгой түлш компани өөрөө өөртөө MNS шахмал түлшний стандартыг батлаад, тэрийгээ хэрэглээд, энэ Улаанбаатар хотын, 21 аймгийн, ялангуяа энэ Улаанбаатар хотын утааг ингээд бүүр ингээд тавиад туучихсан байхгүй юу. ISO бариагүй, гаднын ямар ч стандарт бариагүй, өөрөө өөртөө зориулаад стандарт батлаад, тэгээд тэрийгээ хэрэгжүүлээд явсан. Тэгэхээр энийг сайжруулах нь чухал шаардлагатай.

Тэгэхдээ нөгөө талдаа аль салбар дээр нь Амарсайхан сайдаа аль салбар дээр нь гэдгээ аягүй сайн бодоорой. Барилга дээр гэхэд 2 давхар байшин дээр яах юм бэ, 9 дээр яах юм, нөгөө 20 дээр яах юм. Зам барилаа гэхэд 2 эгнээтэй зам дээр яах юм, 4 дээр яах юм, хурдны зам дээр яах юм гэдэг стандартуудыг тус тусад нь шаардлагын дагуу тавьж тавьж өгөхгүй бол яг зүгээр нэг энгийн 4 эгнээтэй зам дээр хурдны замын стандарт тавьчихаад тэрийгээ нэхээд байвал ажил явахгүй шүү. Аягүй сайн бодоорой л гэж захъя даа.

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж 15 цаг 43 минутаас хуралдааныг даргалав.

Б.Пүрэвдорж: Шадар сайд Амарсайхан хариулъя.

С.Амарсайхан: Очирбат гишүүний хэлж байгаа яг үнэн. Одоо яг энүүгээрээ л бүгдээрээ ерөөсөө энэ өнгөрсөн хугацааны алдаа оноо, тэгээд асуудал, хүндрэл, ирээдүйн сорилт бэрхшээл болсон олон асуудлуудаа нэг мөр ойлголцоод, нэг мөр цэгцлээд, ямар нэгэн нугалаа нуугдмал зүйл байхгүйгээр бүх оролцоо, хяналт, дээрээс нь хэрэгжилт ил, далд нээлттэй байх хэмжээнд асуудлуудаа яриад, ангилж ялгая гэж байгаа юм. Яг ингээд цахилгааны утас нь ямар байх юм, тэр барьж байгаа барилга нь хөөс байх юм уу, шатдаг хөөс байх юм уу, эсвэл галд тэсвэртэй бусад материал байх юм уу, зургаар шатдаг галд тэсвэртэй чулуун дулаалга гэхээд хийхээрээ зардлаа хэмнээд хөөс болгочихдог, тэр нь барьж дуусаагүй байхад шатчихсан олон гашуун түүхүүд бидэнд бий шүү дээ. Өнөөдөр хүртэл хаа сайгүй бий болж байна. Зам, дэд бүтцийн асуудалд нэг зүйлээ хийчихээд дахиад л нураадаг, дахиад л нураадаг байх уу, эсвэл нэг мөр.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Хосбаяр гишүүн асуулт асууна.

Г.Хосбаяр: Стандарт, техникийн зохицуулалтын хуулийг хэлэлцэхийг дэмжиж байгаа. Би энэ ажлын хэсэгт орж ажилласан. Тэгээд ер нь яах вэ нөгөө процессыг нь л маш тодорхой болгож өгөх хэрэгтэй байгаа юм. Стандартыг хэн боловсруулах вэ, ямар нөхцөлөөр нутагшуулах вэ, хаанахын ямар стандарт оруулж ирэх вэ? Энэ дэлхий дээр чинь Евро стандарт, Америк стандарт, Ази стандарт гээд олон стандарт байна шүү дээ. Тийм учраас аль стандарт нь манай орны энэ онцлог цаг уур, манайд ер нь тохиромжтой юм, аль нь ер нь байгаль орчин, эдийн засаг,

хүн ардад хэрэгтэй юм. Энэ талын юмыг нэлээн сайн судлах хэрэгтэй. Судалгааны байгууллага судалгааг сайн хийдэг байх ёстой гэсэн ийм бодолтой байгаа.

Тэгээд мэдээж стандарт сайжирснаар ард иргэд эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах таатай орчин бий болно. Нөгөө талдаа хувийн хэвшилд ээлтэй, хувийн хэвшилд хөрөнгө мөнгө хэмнэсэн, цаг хугацаа хэмнэсэн ийм олон талын ач тус байгаа. Жишээ нь барилгын салбарт гэхэд мянга гаруй норм стандарт, норм дүрэм, стандарт байгаа. Үүний 40 орчим хувийг нь шинэчлэх шаардлагатай болсон гэж салбарын яамнаас мэдээлж байгаа. Аль 1978 оны гост стандарт хүртэл энэ барилгын салбарт мөрдөгдөөд явж байгаа. Тийм учраас эдгээрийг энэ орчин үеийн техник, технологи энэ цаг үетэйгээ нийцүүлж шинэчилж явах ийм зайлшгүй шаардлага байгаа. Тэгээд хамгийн гол нь тэр процесс нь хурдан байхгүй бол нэг норм стандарт батлуулах гэдэг, тэгээд л өгчихсөн хүлээж байгаа, техникийн хороогоор орж байгаа, хэлэлцэгдэж байгаа, техникийн хороо хуралдахгүй байна гээд ингээд байгаад байвал цаг хугацаа яваад байдаг.

Барилгын салбарт бол стандартын тухайд барилгын материал дээр их яригддаг. Өнөөдөр жишээлбэл БНХАУ-аас ч юм уу энэ импортоор маш их тийм стандартын биш, манай стандарт, Монгол хүний эрүүл ахуйд тохирохгүй ч юм уу ийм олон бараа, материал орж ирдэг. Энэ бүгдийг нэг тэр хил гааль дээр орж ирэхэд нь барьж аваад ингээд байхад төвөгтэй байх. Тэгэхээр энэ буцаагаад нөгөө салбарын хяналт иргэд, олон нийт, тэр дундаа энэ салбарын төрийн бус байгууллагуудын хяналт, мэргэжлийн хүмүүс, эрдэмтэн судлаачдын хяналт гээд ингээд маш олон төрлийн ийм олон нийтийн хяналтын доор энэ бараа, материалын стандарт юмыг баталдаг шаардлага байх ёстой л гэж үзэж байгаа. Өнөөдөр барилгын салбарт нормчлолын сан гээд байдаг. Өнөөдөр хувийн ч бай, улсын ч бай бүх баригдаж байгаа барилгаас шууд зардлаас нь 0.18 хувийн шимтгэл Норм дүрэм, стандартын санд ингээд төвлөрүүлдэг, Нормчлолын сан гээд.

Өнөөдөр Барилга, хот байгуулалтын яам, Барилгын хөгжлийн төв дээр зөвхөн энэ салбарт жилд 6 орчим тэрбум төгрөгийн нормчлолын сан бүрдэж байгаа. Энэ сангийн мөнгөөр тэр салбарт юу хийх ёстой вэ гэхээр зэрэг энэ суурь норм дүрмээ шинэчлэх, шинэ стандарт энэ эрүүл ахуй, шаардлага хангасан, хүн ардад ээлтэй, мөн энэ ААН-үүддээ ээлтэй ийм стандартыг нутагшуулах, оруулж ирэх ийм зорилтод зарцуулах ёстой хөрөнгө байдаг. Гэтэл энэ хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулдаг тухай мэдээллүүд ирж байгаа. Мөн хадгалаад байгаад байдаг тухай ярьж байгаа. Тэгэхээр зэрэг энэ хувийн хэвшил чинь барилга барихдаа шууд зардлаасаа 0,18 хувийг өгөөд байна шүү дээ шимтгэлд. Энэ мөнгийг юунд зарцуулах ёстой вэ гэхээр зэрэг энэ барьж байгаа байшингийн тэр чанар стандартыг хангасан материалыг оруулж ирэхэд боломж бололцоог нь нээгээд өгөөч, стандартыг нь батлаад өгөөч, хөрөнгө мөнгө хэмнэе, цаг хугацаа хэмнэе, бидний ажлыг хөнгөвчлөөд өгөөч гээд ингээд шимтгэл төлөөд байхад энэ мөнгийг нь зориулалтын дагуу зарцуулахгүй байна гэдэг харамсалтай. Тийм учраас.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Амарсайхан сайд хариулъя.

С.Амарсайхан: Хосбаяр гишүүн маш чухал асуудал ярьж байна. Энэ хувийн хэвшлийн энэ шимтгэл авдаг, тэгээд зохиогчийн хяналт тавьдаг, дээрээс нь нөгөө гүйцэтгэлийн хяналт тавьдаг хэдий ч чанар, аюулгүй байдлын асуудал хурц хэвээр байсаар байгаа. Тэгэхээр тэр аюулгүй байдалдаа энийг зарцуулах ёстой, хувийн

хэвшлээ дэмжих ёстой, жижиг, дунд бизнес, асуудал амьдралаа аваад явж байгаа, ажлаа хийгээд явж байгаа иргэдийг оруулж байгаа хөрөнгө оруулалт болох нь үнэ цэнтэй, капитал хөрөнгө болж, цааш нь үнэ өсөх, аюулгүй байдал нь баталгаатай, тэгээд өөрсдийнх нь амьдрал ч баталгаатай байх талаас нь асуудлыг хараад байгаа юм.

Жишээ нь бид ингээд Америкийн стандарт гэж ярьдаг. FTA гэдэг юм уу, Европын стандартууд бий, олон төрлийн стандартууд бий. Тэрийгээ бид ярьдаг. Тэгэхдээ олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, амьдралд нотлогдсон зүйлийг бид дахиад л нэг шинэчилж шинээр зохиох гээд цаг хугацаа алдаад байх ямар ч шаардлага байхгүй. Тэгэхээр олон улсын Европын тэр EU, ISO, IEC гэсэн стандартуудыг нь амьдралд болж байгааг нь бид оруулаад ирчихсэн байгаа. Бүр болохгүй гээд цаг уур, орчин нөхцөл энэ үндэсний онцлогтойгоо уялдуулаад, үндэсний стандарт болж батлах энэ асуудлуудаа тэнцвэртэйгээр явуулаад, тэгээд хэрэгжилтийг нь бүрэн хангах энэ тал дээр л анхаарах нь зайлшгүй шаардлага бий. Тэгээд аль стандартыг хэн хэрэгжүүлэх вэ гэдгийг бид шууд хэрэгжүүлэхийг хянах ёстой, тэр нь сонгоод авчихсан бол. Гэхдээ хэн боловсруулах вэ гэдгийг хязгаарлах боломж байхгүй. Түрүүн ярьсан тоо гэдэг бол өөрөө хэн, ямар бараа, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх гэж байгаа юм, энэ улс орны хөгжлийн бодлого, үндэсний тогтвортой хөгжил, нийгэм, эдийн засгийн зорилт нь юу юм, иргэдийн амьдралын суурь хэрэглээ нь юу байгаа юм, аюулгүй байдлынх нь суурь асуудал нь юу юм, юуг бид эрэмбэлж, дараалж чухлаас нь авч үзэх юм гэдгээ энэ дотор ангилж, ялгаж л шийдэх гээд байгаа санаа нь энэ юм. Тэгэхгүй бол зүгээр нэг хууль тогтоомж, дүрэм журам гээд цаас боловсруулах талаас нь асуудалд хандаж ирсэн зүйлүүддээ бид орхих ёстой.

Стандарт, хэмжил зүй, тэгээд энэ тохирлын үнэлгээ, итгэмжлэлийн байгууллагууд яах вэ өөрсдөө тэгээд өнгөрсөн энэ шилжилтийн үед байдаг хүчээрээ ажиллаж ирсэн. Техникийн хороо нь ч гэсэн чадвартай, мэдлэгтэй олон хүн байгаа хэдий ч ерөнхийдөө энэ бол шаардлага хангахгүй ийм асуудлууд, боловсон хүчний дутагдалд энэ салбар орсон. Шинэ залуучууд энд ажиллахгүй байгаа. Цалин хөлс нь гэхэд л 1 сая 200 мянга, 300 мянган төгрөгтэй өнөөдөр Стандарт, хэмжил зүйн салбар энэ бидний хүнсний аюулгүй байдлыг хангаж байдаг лавлагаа лаборатори, энэ итгэмжлэлийн өнөөдрийн цалин бол 1 сая 300-аас 1 сая 500 мянган төгрөгийн хооронд байна. Гэтэл бусад салбарууд нь нэмэгдээд яваад байдаг. Шинжлэх ухааны энэ салбараа бид үйлчилгээний салбарт оруулчихсан байсныг нь өнгөрсөн төсвөөр бид өчнөөн асуудал болж байж шинжлэх ухааны салбарт нь нэг хэсгийг нь 300 гаруй ажилтныг.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Ганбатын Хосбаяр гишүүн тодруулъя.

Г.Хосбаяр: Барилга, хот байгуулалтын сайд Бат-Амгалан сайд байхгүй байна. Би яах вэ сайдыг байсан бол энэ салбарынхаа тэр суурь норм дүрэм, стандартад онцгой анхаараарай. Энэ салбарын энэ стандарт, суурь норм дүрмийг шинэчлэх санхүүгийн нөөц боломж бол байгаа шүү. Энэ салбарт ажиллаж байгаа энэ олон боловсон хүчин, компаниуд, энэ барилгачид чинь хангалттай шимтгэл тэр Нормчлолын санд төвлөрүүлж байгаа. Жилд 6 тэрбум төгрөг орчим. Тэгээд энүүгээр энэ салбарынхаа норм дүрэм энэ шинэчлэл энэ ажлыг сайн хийгээрэй гэж хэлэх гэж байсан юм. Тэгээд одоо сайд маань байхгүй байна.

Ер нь цаашдаа энэ салбар салбарын тэр шинэчлэлийг сайн хийж, тэр техникийн хороод нь яг ажлаа хийж, техникийн хороодыг байнгын ажиллагаатай болгох ч юм уу, тодорхой сард 1 удаа хуралддаг, 2 удаа хуралддаг гээд ийм зохицуулалт хийхгүй бол ингээд стандарт батлуулах гэж цаг хугацаа алддаг зүйлүүд байгаа шүү гэдгийг тодруулж хэлье.

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Мэндбаярын Мандхай гишүүн асуулт асууна.

М.Мандхай: Энэ хуулийг сайжруулах ёстой. Тэгээд энэ хуулийг сайжруулаад илүү явах байх гэж бодож байна. Тэгээд энэ хуулийг ер нь дэмжиж байгаа. Гэхдээ энэ хууль дээр нэлээн сайжруулалт хийх шаардлагатай харагдаж байгаа. Ер нь бүр ажлын хэсэгт дахиад зарим заалтуудыг буцааж боловсруулах энэ тэр шаардлагатай харагдаад байгаа. Энэ 4.1.6 дээр баталгаажуулалт гэж бүтээгдэхүүн тогтолцоо нь тогтоосон шаардлагад нийцэж байгааг эрх бүхий хөндлөнгийн байгууллага нотолно гэж байгаа юм. 1 дүгээрт энэ өөрөө процессын шинж чанартай нэр томъёо дээр утга агуулга орсон байна. 2 дугаарт хөндлөнгийн байгууллага нотолно гэдэг нь яг юугаа хэлж байгаа юм бэ? Энэ чинь баталгаажуулалтын схемээрээ дамжуулаад баталгаажуулалтын байгууллага нь өөрөө хийдэг процессыг эрх бүхий хөндлөнгийн байгууллага гэдэг нь хэнийг хэлж байгаа юм бэ? Энэ хаана ч байхгүй шүү дээ. Энийг тодруулмаар байна.

2-т нь нийлүүлэгчийн мэдэгдэл гээд нэг юм яваад байгаа юм. Би энэ дээр харин жоохон тодруулахгүй бол нийлүүлэгчийн мэдэгдэл гэж бүтээгдэхүүн тогтоосон шаардлагад нийцэж байгаа талаар үйлдвэрлэгч эсвэл нийлүүлэгчээс бичгээр гаргасан нотолгоо гэхчээ байгаа юм. Үндсэндээ хэн тогтоож байгаа юм бэ гэхлээр энэ бүтээгдэхүүнийг чинь байгууллага дотоод хяналт. Тэгэхээр энэ хэн хянах нь өөрөө тодорхойгүй. Тэгээд энэ дээр ингээд харахаар тохирлын баталгаа нь тохирлын гэрчилгээ болон нийлүүлэгчийн мэдэгдэл хэлбэртэй байна гээд нэг тохирлын баталгаа дээрээ оруулчихсан. Тэгэхлээр энэ үндсэндээ байгууллага өөрөө стандартаа гаргаад, мэдэгдэл явуулаад л энэ стандарт нь ингээд хэрэгжээд явах юм уу? Энийг би тодруулъя, энэ нэг тийм нуугдмал санаа яваад байгаа юм шиг харагдаж байна.

3 дугаарт энэ аюулгүйн тэмдэг гээд 4.1.11 дээр. Би өмнө нь Байнгын хороон дээр хэлж байсан. Энэ хүнсний Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд яг үндэсний аюулгүй байдлын хэлбэрүүд байгаа. Үүний нэг нь өөрөө хүнсний аюулгүй байдал буюу food security гэж байгаа. Энэ дотроо 3 шинж агуулагдаж байгаа. Хүнсийг хүртээмжтэй байлгах, хангамж хангамжийг нь хангах, шим шимт байдлыг нь хангах гээд. Тэгэхээр энэ нь өөрөө ерөөсөө бүтээгдэхүүний баталгаат байдлыг яриад байгаа юм. Тэгэхлээр энэ аюулгүйн тэмдгийг баталгаат байдлын тэмдэг гэж болгож өөрчилье гэдэг саналыг би илэрхийлсэн байгаа. Тэгээд энэ дээр анхаараарай. Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль дээр энэ хүнсний аюулгүй байдлыг өөрчлөөд, хүнсний баталгаат байдал болгож олон улсын ийм жишгээр явж байгаа. Тэгэхээр энийг өөрчлүүлмээр байна.

Дараагийнх нь болохоор байгууллагын стандартыг Стандартчилал, тохирлын үнэлгээний төв байгууллага, түүний харьяа аймаг, нийслэл дэх байгууллагад бүртгүүлнэ гэж. Аль нь яг бүртгэх юм бэ, төв байгууллага бүртгэх шаардлага байгаа юм уу? Энэ аймаг, нийслэл нь өөрсдөө бүртгээд явчхаж болдоггүй юм уу гэж асуумаар байгаа юм. Яагаад гэхлээр энэ яг энийг аль нэг нь бүртгэх, яаж бүртгэх юмнууд нь журам нь өөрөө тодорхойгүй яваад байгаа учраас. Тэгэхлээр энийг ингэж

тохирлын үнэлгээний төв байгууллага нь ч бүртгээд л, аймаг, нийслэл гэхгүйгээр нэг талдаа яг энэ доод нэгждээ өгвөл яадаг юм бэ? Аймаг, нийслэл нь бүртгээд явах боломжтой гэж харж байгаа.

13.2 дээр хүн, малын эрүүл мэнд гэдэг. Би энэ байгааг Байнгын байнгын хороонд хэлж байсан. Одоо бол үндсэндээ энэ one health гэдэг том зарчим явж байгаа. Тийм учраас энэ хүн, мал, ургамал, амьтан гэсэн заалтыг оруулж цогцоор нь авахгүй бол энэ заалт дээр дандаа хүн, малын эрүүл мэнд гэсэн байдлаар яваад байгаа. Тэгэхээр бид олон улсынхаа жишигтэй нийцүүлээд энд өөрчлөлт оруулъя гээд оруулсан байгаа. Тэгээд 31.1.1 дээр энэ мэдээллийн сантай байх асуудлыг дурдсан байсан. Одоо энэ мэдээллийн санг цахимжуулж болохгүй юм уу? Тэгэхгүй энэ.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Асуултад Шадар сайд Сайнбуянгийн Амарсайхан хариулна.

С.Амарсайхан: Мандхай гишүүн сая энэ мэдээллээ цахимжуулахгүй юу гэж. Яг энэ стандартыг цахимжуулах ажил эрчимтэй явагдаж байна. Бид энэ Гаалийн ерөнхий газар, Татварын газар, Стандарт хэмжил зүйн газар, бусад энэ байгууллагуудын мэдээллийн өгөгдөл мэдээлэл датаг нэг платформ дээр мэдээлэл технологи, хиймэл оюун дээр суурилсан ийм үндэсний хэмжээний системийг хөгжүүлэх ажил ингээд дуусах шатдаа явж байгаа. Энэ систем ашиглалтад орсноор бүх бараа, бүтээгдэхүүнүүдийн стандартуудыг цахимд шууд ингээд цахимаар хянах боломж бүрдэнэ. Стандарт өөрөө цахимжаад ил тод, нээлттэй болоод цахимаар авдаг болсон. Энэ шинэ систем бий болсноор бид барилгын материал, хүнсний, эм хэрэглэл гээд ер нь Монгол Улсад импортоор орж ирж байгаа болон дотоодод үйлдвэрлэгдэж байгаа, гадаадад экспортолж байгаа бүх бараа, бүтээгдэхүүнүүдийг цахим хяналтад оруулаад, тухайн, тухайн үед нь гарал үүсэл, чанар стандарт, аюулгүй байдлыг нь хянаад болж байвал хилээр нэвтрүүлнэ. Мэдээж олон улсын итгэмжлэлээ хоорондоо хүлээн зөвшөөрчихсөн 160 гаруй улс орон манайтай хамтарч ажиллаж байгаа. Манай итгэмжлэл стандартыг энэ улс орнууд хүлээн зөвшөөрөөд, ажлыг саяхан гэрээ хэлэлцээрээр бий болгосон. Энэ өөрөө цаашаа асар том олон улсын зах зээлд нэвтрэх итгэлцэл учраас бид энэ хяналтуудаа тавина.

Тэгээд зогсохгүй ер нь барилгын материал обой гээд, хүнсний бүтээгдэхүүн орж ирвэл орж ирсэн тэр бүтээгдэхүүнийг хэн оруулж ирээд, хаана худалдаж байгааг хүртэл тэр код мэдээллээр нь хянаад, 100 айл дээр юм уу эсвэл тэр юун дээр Драгон төв дээр гэдэг юм уу, нэг бол энэ хүнсний зах дээр зарагдаж байгаа юм уу, үгүй юу гэдгийг нь хүртэл худалдан авагч ороод худалдаж авах байрныхаа обой, шал нь хүртэл хэний оруулж ирсэн, ямар үйлдвэрийнх юм гэдгийг худалдаж авахаасаа өмнө хүртэл хянадаг ийм тогтолцоог бид бий болгоё гээд асар их мэдээллийн бааз суурийг нэхдэг ажлууд хийгдэж байгаа. Тэгээд энэ үе шаттай явна.

Бусад тэр итгэмжлэлийг мэдээж итгэмжлэлийг баталсан байгууллага баталгаажуулалтаа хянаана. Дээрээс нь зөвхөн төр гэхээсээ илүүтэй олон улсын байгууллага бий. Энэ итгэмжлэл, тохирлын гэрчилгээг олгодог хөндлөнгийн байгууллагууд бий. Тэрний ойлголт мэдээллийг нэгтгэж, хэн ямар үүрэг хариуцлагыг хүлээж, хэн юуг гүйцэтгэдэг юм бэ гэдгийг л илүү ил тод процесс явж байна л гэж ойлгож болно. Тийм.

Б.Пүрэвдорж: Нэмээд Батбаатар дарга хариулчих тийм, болчихсон уу? Нэмж нэг минутаар хариулъя. Амарсайхан сайд. 4.

С.Батбаатар: Мандхай гишүүний асуултад хариулъя. 4.1.1 гэж энэ бол, биш ээ 4.1.6 уучлаарай. 4.1.6 баталгаажуулалт бүтээгдэхүүн тогтолцоонд тогтоочихсон шаардлагад нийцэж байгаа эрх бүхий хөндлөнгийн байгууллага гэдэг нь нөгөө тохирлын үнэлгээний байгууллагаа хэлж байгаа юм. Тухайн бүтээгдэхүүн тогтолцоо нь стандартын шаардлагад нийцэж байна уу, үгүй юү гэдгийг тохирлын үнэлгээний байгууллагаар нотлох л тэр баталгаажуулалтыг хийхэд тэр үйл ажиллагаа. Аюулгүйн тэмдэг гэдэг заалт орж ирсэн. Аюулгүйн тэмдэг бол, аюулгүйн тэмдэг нь техникийн зохицуулалт буюу нөгөө стандарт шаардлагыг бүрэн хангаж байгааг тодорхойлсон тэмдэглэгээ. Энэ олон улсад хэрэглэгдээд явдаг тийм л заалт байгаа. Техникийн зохицуулалт, аюулгүйн үзүүлэлтийг нь тодорхой тусгасан байдаг тул аюулгүйн шаардлагыг хангасан илэрхийлэл нөгөө худалдааны тэмдэг тэр тухайн бүтээгдэхүүн.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Тодруулах уу? Цаг нь дуусчихлаа. Мэндбаярын Мандхай гишүүн тодруулъя.

М.Мандхай: Хөндлөнгийн байгууллага гэдэг юм нэр томьёо дээр огт тусгагдаагүй байгаа. Тэгэхлээр ийм нэршлээр орж ирэхээр дараа нь энэ хууль яаж ч хэрэгжилт дээр гуйвж болохоор харагдаж байна. Тийм учраас ийм нэгэнт нэр томьёо дээр тусгагдаагүй тодорхойлолт байхгүй байгаа нэрийг яг өөрсдөө тохирлын үнэлгээний төвөөр нь л бич гэж хэлмээр байна. Тэгэхгүй бол хөндлөнгийн байгууллага гэхлээр хувийн байгууллагууд хүртэл орж ирээд үндсэндээ баталгаажуулалт хийгээд явах боломж үүсэхээр харагдаж байгаа байхгүй юу. Тэгэхлээр энийг нь өөрчилмөөр байна.

2 дугаарт нийлүүлэгчийн мэдэгдэл гэдэг дээр энэ нуугдмал санаа энэ яг тодорхой бол, ингээд жишээлбэл үйлдвэрлэгч өөрсдөө стандартаа гаргаад танайд мэдэгдэл өгчихвөл энэ стандарт хэрэгжээд явах юм уу? Үндсэндээ яг тэгж харагдаж байна шүү дээ. Гэрчилгээ ба тохирлын баталгаа нь тохирлын гэрчилгээ болон нийлүүлэгчийн мэдэгдэл хэлбэртэй байна гээд орчхож байгаа. Тэгэхээр энэ дээр нэг нэмэлт хариулт авъя.

Б.Пүрэвдорж: Индрийн 4 дүгээр микрофон.

С.Батбаатар: Нийлүүлэгчийн мэдэгдэл гэж бүтээгдэхүүн тогтоосон шаардлагад нийцэж байгаа талаар үйлдвэрлэгч эсвэл нийлүүлэгч бичгээр гаргасан нотолгоо гээд. Энэ бол яг одоогийн хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль дээр авсан заалтыг л яг тэр чигээр нь аваад явж байгаа. Тэгэхдээ энийг засаж сайжруулж олон улсын түвшинд хүргэхэд өөрчлөлт хийх боломжтой гээд агуулгыг хэлье. Тэгээд таны хэлж байгаа энэ санаануудыг манай хууль дээр өөрчлөлт хийх, ямар байдлаар 2 салаа утгагүй ингээд сайжруулах тийм боломжтой байгаа.

Б.Пүрэвдорж: Бадамдоржийн Пунсалмаа гишүүн асуулт асууя.

Б.Пунсалмаа: Сайн байцгаана уу, та бүхэнд энэ өдрийн амар амгаланг айлтгая. Стандартын хуулийн нэмэлт, өөрчлөлт орж ирж байгаад туйлын их баяртай байна. Ер нь стандарт гэхээр зэрэг л энэ нэг аж ахуйн нэгж, хувийн компаниуд, үйлдвэрүүдэд холбоотой юм шиг ингэж ойлголт төрөөд байгаа юм. Ер нь төр нь

өөрөө ер нь бид ямар стандарт дагаж мөрдөх ёстой юм, ямар стандарт төрийн өмчийн компаниуд мөрдөж байна вэ гэдэг чинь өнөөдөр том асуудал болчихоод байна. Яагаад гэхлээр ард иргэд төрд итгэдэг, төрийн үйлчилгээ, төрийн бүтээгдэхүүн гэдэг бол өөрөө итгэл даах ёстой гэдэг томоохон ойлголт байгаад байгаа юм. Өнөөдөр тэгтэл энэ асуудал энэ Тавантолгой түлш гэдэг компани дээр 100 хувь өөр байгаад байна. Энэ төрийн өмчит энэ компанийн төлөвлөлт нь, гүйцэтгэл нь, хяналт нь яаж ажилладаг юм бэ? Энэ Тавантолгой түлш гэдэг компани өнөөдөр тэр хяналт сул байснаас болоод ахуйн хэрэглээний түлшиндээ энэ гангийн үйлдвэрт зориулалттай ийм өндөр түвшний энэ мидлинг барьцалдуулагчийг хэрэглэхчхсэн байгаа байхгүй юу. Үр дүнд нь болохлоор маш их хүний, олон хүний амь нас, эрүүл мэнд, төсвийн асар их том үргүй зардал болсон. Төр өөрөө энэ өөрийнхөө үйл ажиллагааг хэр хянаж байгаа юм бэ, төлөвлөж байгаа юм гэдгийг ерөөсөө энэ асуудал энд байна гэдэг ингэж харагдаж байгаа юм.

Энэ жил болохлоор энэ өвөлжилтөд бэлтгээд хувийн компаниуд энэ утаагүй түлшийг үйлдвэрлэх байх гээд найдаж байсан чинь импортоор авах болчихлоо. Ерөөсөө үндэсний компаниудаа бид яаж дэмжиж байгаа юм бэ? Стандарт, хэмжил зүйн газар стандарт Монгол Улсад байдаг юм бол энэ стандартаа үндэсний үйлдвэрлэгч компаниуддаа өгчих. Энэ стандартыг чинь дагаад л бид үйлдвэрлэж чадна. Угаасаа Тавантолгой түлш компанийг нээгдэхээс өмнө маш олон үндэсний компаниуд байгуулагдаад, өөр өөрсдийнхөөрөө утаагүй түлш үйлдвэрлээд эхэлж байсан юм шүү дээ. Тэрийг төрийн өмчийн компани орж ирээд шууд байхгүй болгосон. Одоо өөрсдөө үйлдвэрлэж болохоо болингуут шууд гаднаас захиална. Ийм баймааргүй байна.

Тэгэхээр зэрэг стандарт гэдэг ерөөсөө төрийн өөрийнх нь байгууллагууд дээр яаж энэ төлөвлөх юм, яаж гүйцэтгэх юм, хянах юм, стандартын байгууллагууд нь яаж ажиллах юм бэ? Хувийн байгууллагуудаар хэрвээ төрийн тендер аливаа зүйл зарлагдаж байгаа бол энэ тендерийг стандарт нь яаж энэ стандартаа тавиад, энэ хувийн компаниудаа энэ тендертээ оролцуулж байх юм гэдгээ бид энэ Стандартын хуулиараа маш тодорхой болгож өгөх хэрэгтэй байна. Ингэж байж Монгол Улсын эдийн засаг өснө, ингэж байж нийтээрээ Монгол Улс үйлдвэрлэгч, бүтээгч болно. Монгол хүн чинь Монгол хүндээ л үйлдвэрлэж чадна шүү дээ. Тэр Монгол хүний онцлогт тохирсон үйлдвэрлэлийг Монгол хүмүүс л сайн үйлдвэрлэнэ. Тэгэхлээр энэ үйлдвэрлэл дээр манай энэ Стандартын тухай хууль онцгой дэм болж ажиллаасай гэж ингэж хүсэж байгаа. Ингээд хуулийн үйл ажиллагаанд нь амжилт хүсье.

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Үг хэлэхээс өмнө нэг зүйлийг анхааруулчихъя. Энэ хуулийг өнөөдөр хэлэлцэж, санал хураалт явуулж, анхны хэлэлцүүлгийг хийхгүй бол долоо хоногоор хойшилно. Долоо хоногоор хойшлохлоор Их Хурлын чуулган дахиад долоо хоногоор хойшлохоор байгаа. Тийм учраас 2 бүлгийн дарга нар, дэд дарга нар ирцээ сайжруулж, сайжруулаарай. Одоо 3 хүн асууна, танхимд 2 нь байгаа, 1 нь асуухгүй юм шиг байна. Тэгэхээр 2 хүний дараа 10 хэдэн зарчмын зөрүүтэй санал байгаа. Гишүүдийн ирцийг нэмэгдүүлээрэй. Бадарчийн Хэрлэн гишүүн асуулт асууна.

Б.Хэрлэн: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр 2017 онд энэ хуулийн шинэчлэл хийгдэж байсан юм байна. Өнөөдөр шинэчилсэн найруулга нь орж ирж, үзэл баримтлалын хувьд нэлээн томоохон суурь шинжтэй өөрчлөлтүүдийг агуулсан шинэ хувилбар орж ирж байгаа юм байна гэж харж байна. Ялангуяа энэ дээр болоод ирэхээр ерөнхийдөө талуудын сонирхогч талуудын оролцоотойгоор стандартыг

тогтоодог болгоё, зааг. 2 дугаарт нь болоод ирэхээр энэ нэгэнт тогтоосон стандартыг ААН-үүд, иргэд дагаж мөрддөг байя. Тэр тусмаа техникийн зохицуулалтыг заавал дагаж мөрддөг байя гэсэн ийм зарчмын санаа орж ирж байгаа юм байна. Гуравдугаарх нь ер нь төр, хувийн хэвшлийн оролцоотойгоор энэ стандартыг хэвшүүлэх, хэрэглэх энэ үйл ажиллагааг стандартыг тогтоох энэ үйл ажиллагааг явуулъя гэсэн ийм зарчмын 3 гол санааг агуулсан ийм хуулийн шинэчлэлийн найруулга, шинэчилсэн найруулга орж ирж байгаа юм байна. Энийг би ерөнхийдөө үзэл баримтлалын хувьд дэмжиж байгаа юм. Тэр дагаж мөрдөх гэдэг тухай дээр нэлээн маргаан өрнөж байна л даа. Тэгэхээр ерөнхийдөө энэ стандартын тухай, чанарын тухай нэгдсэн ойлголтыг энэ нийгэмд бий болгож, энэ нийгэмд итгэлцэл гэдэг юмыг бий болгохын тулд өнөөдөр бид яах аргагүй чанарын талаар ижилхэн ойлголттой байхын тулд яах аргагүй энэ дагаж мөрдөх гэдгийг бүүр ингээд энэ хуульд тусгайлан оруулж ирсэн юм байна гэж би ойлгож байгаа. Энэ утгаар нь энийг дэмжиж байгаа.

Энэ дээр надад хэд хэдэн асуух зүйл байгаад байна. Ерөнхийдөө энэ хуулийн төслийг үзэхэд стандартыг тогтоох, стандартыг хэрэглэх гэсэн ийм 2 үндсэн хэсэгтэй байхаар юм байна уг нь агуулгын хувьд. Гэхдээ хуулийн дийлэнх яг ингээд хуулийн боловсруулалт талаас нь харахаар стандартыг тогтоох, стандартчилал тал руугаа түлхүү их анхаарчихсан. Хэрэглээ, түүнийг хянах, эргээд хариуцлага тооцох тухай асуудлууд нь арай жаахан сулхан тусчихсан юм уу гэсэн ийм зүйл анзаарагдаж байна. Тэгээд энийг мэдээж хэрэг явц дундаа илүү сайжруулах байх гэж би найдаж байна.

Надад 2 асуулт байна. Энэ дотор, 3 ч асуулт байна. Ер нь стандартын талаар ямар нэгэн санал хүсэлт, гомдол гарвал хэнд гаргах вэ, тэрийг нь хэрхэн, яаж шийдвэрлэх вэ гэдэг энэ хууль дотор ерөнхийдөө тусаагүй байна лээ. Өөрөөр хэлбэл тэр тохирлын үнэлгээ, баталгаажуулалтын энэ явцад чинь ямар нэгэн асуудал гарвал тэрийг нь хаана, хэнд, хэн хандах вэ гэдэг нь тодорхой биш байгаад байна.

Дараад нь нэг сонирхогч талуудын оролцоог хангах ийм зарчмын санаа оруулж ирж байгаа юм чинь түрүүн Идэрбат гишүүн хэлж байсан. Ерөнхийдөө энэ стандартын хэрэглээ, тэрийг хянах тухай дээр талуудын оролцогч талуудын тийм олон нийтийн хяналтыг энд хэрэглэх боломжтой юу? Та нар нөгөө үндэслэлдээ биччихсэн байгаад байгаа шүү дээ. Энэ хүн хүчний хувьд хүрэлцэхгүй байгаа учраас бид ингээд стандартыг мөрдүүлэхэд үнэхээрийн төвөгтэй байна гээд байгаа. Тэгэхээр чинь иргэд, олон нийтийн оролцоог, оролцоонд түшиглэж энэ хяналтыг хэрэгжүүлэх энэ санааг энэ хуульдаа тэр үндсэн зарчимтайгаа нийцүүлээд оруулж ирэх боломжтой юу гэж асуумаар байна.

Хоёрдугаарх нь энэ дээр хариуцлагын тухай асуудал ердөөсөө нэг илээд өнгөрчихсөн байгаад байгаа. Тэгэхээр стандарт, техникийн зохицуулалт 2 чинь болоод ирэхээр нэг нь бол яах вэ дагаж мөрдөнө, нөгөөдөх нь заавал дагаж мөрдөнө гэж байгаа. Мэдээж хэрэг хүлээлгэх хариуцлага санкцууд нь харилцан адилгүй байх ёстой байх. Тэгэхээр энийг хэр ялгамжтайгаар энд тусгах вэ гэдгийг асуумаар байна.

3 дугаарт нь би юу асуух гээд байна вэ гэхээр тэр нөгөө тохирлын үнэлгээг хийх гэж байгаа. Тэгэхээр энэ дээр чинь нөгөө хувийн хэвшлийн байгууллагууд нөгөө тохирлын үнэлгээг, хувийн хэвшлийн лабораториуд тохирлын үнэлгээг хийнэ

гээд тэгж байгаа. Тэд чинь өөр өөрсдийнхөө аргачлалаар хийгээд явчих юм уу, эсвэл нэгдсэн аргачлалаар хийх юм уу? Энэ нэгдсэн аргачлалыг нь энэ Стандарт, хэмжил зүйн төв байгууллага энийг боловсруулах, батлах ийм чиг үүрэгтэй байх уу, үгүй юү? Энэ тухай санаа энэ дотор байхгүй байгаад байгаа юм. Тэгэхээр энэ асуултуудыг хариулаад өгөх үү?

Б.Пүрэвдорж: Шадар сайд Сайнбуянгийн Амарсайхан хариулъя.

С.Амарсайхан: Манай Хэрлэн гишүүн маань энэ өөрөө судалгаа шинжилгээ, боловсрол, бусад олон улсын чиглэлээр ажиллаж байсан ийм туршлагатай, өөрөө энэ иргэдийн оролцоо маш чухал гэдэг маш чухал санааг гаргаж тавьж байгаад их баяртай байна. Ер нь өөрөө энэ хэрэглэгчийн аюулгүй байдал, иргэдийн өөрсдийн хэрэглээний чанар, стандарттай шууд холбоотой учраас энэ хууль тогтоомжоороо бид энэ хэрэглэгч, иргэдийнхээ, олон нийтийн хяналт, оролцоог илүү нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага байна гэж үзэж байгаа 1 дүгээрт.

2 дугаарт энэ асуудлуудаа бид засаж сайжруулах асуудлууд дээрээ манай Батнайрамдал гишүүнээр ахлуулсан, тэгээд Хэрлэн гишүүн, Энхнасан гишүүн, тэгээд нэлээн 15 гишүүний оролцоотой ийм ажлын хэсэг байгаа. Тэгээд ажлын хэсгүүд энэ дээр ажилласан учраас цаашдаа Их Хурлаар ингээд хэлэлцэх эсэх нь шийдэгдээд явахаар ажлын хэсгийн дарга томилогдож, гишүүд албан ёсоор захирамжлагдаж явах байх. Тэгээд энэ хүрээнд та бүхнийхээ санаа оноог тусгаад явна. Бусад асуудлыг Батбаатар дарга хариулчих.

Б.Пүрэвдорж: Индрийн 4 номер Батбаатар.

С.Батбаатар: Хэрлэн гишүүний асуултад хариулъя. Стандартын талаар санал гомдол бол одоо болтол гардаг. Энийг ямар асуудлаар шийддэг вэ гэхээр, ямар дүрмээр шийддэг вэ гэхээр Монгол Улсын үндэсний стандартчилал буюу MNS 1.1 гэдэг бидний барьж байгаа дүрэм олон улсын стандартын байгууллагаас барьж байгаа нөгөө guide-ээ барьж бид энэ асуудалд ханддаг. Энэ ямар, яаж шийдэх вэ гэхээр техникийн хороогоороо энэ асуудлыг хэлэлцүүлдэг. Техникийн хороогоороо хэлэлцүүлэхдээ тухайн гомдол буюу санал гаргасан сонирхогч талыг оролцуулаад, өөрийнх нь үндэслэл тайлбарыг сонсоод, тэр мэргэжлийн байгууллага, төрийн байгууллага, тэр судлаач тэр техникийн хорооны гишүүдээр энийг хэлэлцээд асуудлыг шийдвэрлээд явж байгаа. Энэ асуудал MNS 1.1-ээр зохицуулагдаад явж байгаа учир хууль дээр тусгагдаагүй байгаа гэдгийг танд хэлье. Тохирлын үнэлгээний байгууллагыг манай ISO 17 0 67 гэсэн.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: 1 гишүүний дараагаар санал хураалт явагдаж эхэлнэ шүү хэлэлцэх эсэх дээр. Гончигдоржийн Уянгахишиг гишүүн асуулт асууна.

Г.Уянгахишиг: Ер нь энэ хуулийг үзэл баримтлалын хувьд дэмжиж байгаа. Гол нь яг энэ үзэл баримтлалдаа тусгасан буюу яг зайлшгүй практик шаардлагын хүрээнд өөрчлөх шаардлагатай байгаа асуудлуудаа яг энэ хуулийнхаа төсөлд тусгаж чадсан уу, ойлгомжтой тусгаж чадсан уу, мөн энэ хуулийг хэрэглэж байгаа хэрэглэгчдэд илүү ойлгомжтой байх талаас тусгаж чадсан уу гэдэг дээр нэлээн саналууд байгаа. Тийм учраас өнөөдөр яах вэ хэлэлцэх эсэхээ хэлэлцэж байгаа учраас ер нь яг ажлын хэсэг байгуулагдахаар ажлын хэсэгт ороод ажиллана.

Яг өнөөдрийн хувьд 2 гол асуудал байгаад байгаа юм. 1 дүгээрт стандартыг дагаж мөрдөх тухайд заавал дагаж мөрдөнө гээгүйгээс болоод иргэд тэрийг дагаж мөрдөхгүй байна гэдэг асуудал тавигдаад байна. Гэтэл энийг жишээлбэл хуульчлаад бүгдийг нь заавал стандартыг дагаж мөрдөх ёстой гэдэг юм ороод ирвэл энэ өөрөө олон улсынхаа жишигт нийцэхгүй болоод ороод ирнэ шүү дээ. Тэгэхээр яг энэ тал дээр ямар байдлаар тэр заавал зохицуул, заавал мөрдөх стандартыг хаана тусгаж мөрдүүлэх юм бэ, тэр стандарт болгонд тусгачихсан байвал тэрийгээ заавал дагаж мөрдөх ёстой шүү гэдэг зохицуулалтаар зохион байгуулалтаар хийж байна уу, эсвэл ямар байдлаар энийгээ заавал мандатаар гэдэг болгож оруулсан бэ гэдэг эхний асуулт байна?

2 дугаарт мэдээж яг практик шаардлага, бид стандартуудаа өөрчилж амжихгүй байна, шинэчилж амжихгүй байна, тийм ээ илүү хуучирсан байна. Тэгэхээр дагаж мөрдөх боломжгүй байгаад байна. Нөгөө талаасаа хяналт тавьж чадахгүй байна. Төрийн эрх юу гэдэг юм бүтцээр гэдэг юм уу тийм ээ, төрийн байгууллагын бүтэц энд хангалтгүй, хүрэлцэхгүй байгаад байна гээд байгаа. Тэгвэл энийгээ сайжруулахын тулд төр, хувийн хэвшлийн түншлэл талаас, мөн хувийн хэвшил талаас яг ямар оролцоог бий болгож байгаа вэ? Батлах нь мэдээж ойлгомжтой. Энэ чинь хороо орж ирж байгаад бол талархалтай байна. Энэ хороонд хувийн хэвслээс болон мэргэжлийн багууд оролцох юм байна. Харин нөгөө батлаад гаргаж ирсэн стандартаа тохирлын үнэлгээнийхээ гэрчилгээгээ олгочихсон, тохирлын баталгаагаа олгочихсон, энэ нь яг тэр хэрэгжилт нь хэр байна вэ, стандартаа зөрчөөд байна уу, үгүй юү гэдэг хяналтыг хэн тавих вэ? Дахиад л зөвхөн төр хяналт тавиад эхэлбэл энэ дахиад л хүн хүч хүрэлцэхгүй. Тэгэхээр энэ дээр хувийн хэвшил талаасаа ямар оролцоог илүү түлхүү оруулж ирж байгаа вэ, санхүүжилт яаж орж ирж байна вэ? Буцаад энэ дээр яг ингээд халти оруулаад харахад төсвөөс санхүүжихээр, төсвийн байгууллага өөрөө төсвөөсөө санхүүжилтээ оруулаад явахаар ийм зохицуулалт харагдаад байна л даа. Тэгэхээр зөвхөн төсвийн санхүүжилтээр хийх гээд байна уу? Энэнээс өөр боломжит санхүүжилтүүдийг бий болгож байна уу?

Мөн түүнчлэн хувийн хэвшил орж ирсэн тохиолдолд тухайн стандартыг боловсруулаад, батлуулаад, хэрэгжилтэд нь өөрсдөө хяналтаа тавиад, харин тэр стандартыг хэрэгжүүлэх, хяналт тавих, боловсруулсныхаа тэр үнэ хөлсийг буцаагаад тэр стандартыг дагаж мөрдөж байгаа, стандартынх нь дагуу үйл ажиллагаа явуулж байгаа субъектүүдээс авах санхүүжилтийг юу гэдэг юм, fee гэж хэлдэг шүү дээ. Стандартыг дагаж мөрдөж байгаа, хяналт тавиулж байгаагийнхаа үйлчилгээний хөлс гэдэг шиг иймэрхүү нөхцөл байдлууд оруулж ирсэн үү? Өөрөөр хэлбэл олон улсад байдаг сайн жишгийг яг энэ хуулийн төсөл дээрээ буулгаж оруулж ирж байгаа юу гэдэг ийм 2 гол асуултыг асуумаар байна.

Б.Пүрэвдорж: Шадар сайд Сайнбуянгийн Амарсайхан хариулна.

С.Амарсайхан: Стандартыг түрүүн хэлсэн сонгож авна, сонгохыг хэн ч тулгахгүй. Нэгэнт сонгоод авсан бол зайлшгүй дагаж мөрдөх ёстой. Жишээ нь яагаад гэхээр жишээ нь сүү, тараг, талх ч гэдэг юм уу, бидний өдөр тутмын хүнсний хэрэглээнд хангагддаг энэ хүнстэй холбоотой MNS стандарт бий. Гол нь Монгол стандарт бий. Энэ стандартаа сонгоод авчихсан бол та дэлгүүр ороод худалдан тэр сүү, махыг худалдаж авахад, лаазалсан бүтээгдэхүүн худалдаж авлаа гэхэд яг тэр стандартаар гэдгээ л эргэлзэхгүйгээр таны эрүүл мэнд, бидний эрүүл мэнд, аюулгүй байдалд эрсдэлгүй гэдгийг л баталгаажуулахын тулд, итгэлтэй байхын тулд

хэрэглэгчийн аюулгүй байдлыг хангахын тулд л бид энэ нэгэнт энэ MNS стандартыг эсхүл ISO-г сонгож авсан зайлшгүй хэрэгжүүл гэдэг асуудал ярьж байгаа. Ингэж зайлшгүй хэрэгжүүлээгүйгээс болоод л бид авч байгаа бүтээгдэхүүн, хэрэглэж байгаа эд хогшил дээрээ итгэлгүй болчихсон, эм биш хор, хоол биш аюул болчихоод байгаа учраас энийг хэлээд байгаа юм 1 дүгээрт.

2 дугаарт сая тэр хэрэглээний аюулгүй байдлын асуудлуудтай холбоотой зүйлүүдээс гадна энэ хууль журмын хэрэгжилтийг хангах тэр хяналтыг тавих асуудлуудыг яг мэргэжлийн байгууллагаас гадна энэ холбоод хяналтаа тавина. Жишээ нь Хүнсний холбоо гэж бий. Газар тариалан эрхлэгчдийн холбоо гэж байна. Тарьж байгаа тариа, хүнс, хүнсний ногоон дотор пестицид буюу ургамал хамгааллын бүтээгдэхүүн хэт их хэрэглэгдээд хоол биш хор болж байна уу, эсвэл асуудал аюулгүй стандартын хүрээнд байна уу гэдгийг төрөөс гадна мэргэжлийн холбоод, тэгээд ААН-үүдээр гүйцэтгүүлдэг байх энэ тогтолцоо руугаа илүү оръё гэж байгаа. Мэргэжлийн байгууллагууд нь мэргэжлийн салбараа дотооддоо зах зээлийнхээ зарчмаар оролцоо, хяналтаа тавиад явдаг байх ийм тогтолцоо руу. Барилгыг бол Барилгын ассоциаци холбоо гэж байдаг. Яг тэр мэргэжлийн байгууллага. Тэгэхдээ хөндлөнгийн хяналтаа төр тавьдгаараа тавиад явна. Тэр нь өөрөө итгэмжлэл, баталгаажуулалт, тохирлын үнэлгээнийхээ хүрээнд стандарт, хэмжил зүйн үйл ажиллагааныхаа чиглэлээр хийгдээд явна л гэдгийг хэлье. Ингээд Батбаатар дарга нэмээд хариулчих.

Б.Пүрэвдорж: Индрийн 4 дүгээр микрофон Батбаатар дарга.

С.Батбаатар: Уянгахишиг гишүүний асуултад хариулъя. Хууль тогтоомжийн хуулийн дагуу манай стандартын энэ хуулийг энгийн ойлгомжтой болгох талаас нь нэлээн сайн ажилласан. Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль маань нэлээн мэргэжлийн түвшинд мэргэжлийн хүмүүс ойлгохоор байсныг энийг энгийнчлэх, энгийн хүн ойлгохоор болгож нэлээн сайн ажилласан байгаа гэдгийг танд хэлье. Төр, хувийн хэвшлийн оролцооны асуудал дээр энэ дээр тохирлын үнэлгээний байгууллага. Тохирлын үнэлгээний байгууллага ерөөсөө хувийн хэвслээс, хувийн хэвшлийн байгууллага. Тэгэхээр энэ тохирлын үнэлгээний байгууллагаар очоод тухайн стандартад нийцсэн үү, үгүй юү гэдгийг нотолж байгаа асуудлыг одоо энэ хуулиар төрийн хяналт шалгалт дээр шууд ашиглах тэр боломжийг нь нээж өгч байгаа. Тэгэхээр төр, хувийн хэвшлийн оролцооны асуудал энэ дээр явагдаж байна гэсэн үг.

2 дугаар асуудал стандартыг хэн ч боловсруулж болно, иргэн ч боловсруулж болно, ААН ч боловсруулж болно, сонирхогч ямар ч тал боловсруулж болно гэдэг асуудал энэ дээр орж байгаа. Олон улсын түвшинд ингээд аваад.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмж 1 минут тодруулъя. Индрийн 4 дүгээр микрофон.

С.Батбаатар: Олон улсын ингээд судалгаагаар аваад үзвэл Англид гэхэд 12 мянган стандартыг боловсруулдаг иргэн, иргэд ингээд сайн дурын ажилтан байж байдаг. Канадад гэхэд сайн дурын хувийн аж ахуйн 17 байгууллага ингээд стандартыг төрийн байгууллага, юу төрийн бус байгууллага ингээд боловсруулаад байж байдаг. Тэгэхээр Монголд яг стандартыг хэн боловсруулах юм бэ гэдэг дээр одоогийн байдлаар манай төрийн захиргааны төв байгууллагууд голлож оролцоод байгаа. Тэгэхээр энэ асуудлыг бол хувийн хэвшил ч боловсруулж болно, мэргэжлийн холбоо ч боловсруулж болно, иргэд ч боловсорч болно, ААН ч

боловсруулж болно гэдгийг ойлгомжтой хуульд энэ энгийн ойлгомжтой болгож тусгаж өгч байгаа.

Б.Пүрэвдорж: Гончигдоржийн Уянгахишиг гишүүн нэмж тодруулъя.

Г.Уянгахишиг: Тэгэхээр ямар ч байсан боловсруулалт, хяналт тавих дээр төр, хувийн хэвшлийн түншлэл ажиллаад явчих юм байна. Үүн дээр жишээлбэл яг дагалдах хууль дээр Зөрчлийн тухай хууль бол орж ирээгүй байна гэж харсан. Тэгэхээр хариуцлага талаасаа буюу хариуцлагын тогтолцоо ер нь дутагдаад байна уу даа гэж хараад байгаа юм. Өөрөөр хэлбэл бидэнд хангалттай олон стандарт байгаад байдаг. Хуулиараа жишээлбэл Хүнсний хууль, Эрүүл мэндийн тухай хууль тэр болгон дээр стандартыг дагаж мөрдөх ёстой хуулийн зохицуулалтууд нь байгаад байдаг. Гэтэл яг тэр стандартыг дагаж мөрдөхгүй байгаа дээр ямар хариуцлага хүлээх юм бэ, хэн хариуцлага хүлээх юм бэ? Үнэхээр жишээлбэл тохирлын үнэлгээний байгууллага тохирлын үнэлгээний гэрчилгээ олгочихсон бол тэр тохирлын үнэлгээ олгосон тэр стандартыг дагаж мөрдөж байгаа гэдгийг баталгаажуулж байгаа юу? Энэ нь явцын дунд тэр баталгаажуулалтыг хийж чадаагүй буюу тухайн стандартыг хангахгүй, үйл ажиллагаандаа хангахгүй байгаа нөхөрт хариуцлага тооцох.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Индрийн 4 дүгээр микрофон Батбаатар дарга нэмж хариулна.

С.Батбаатар: Уянгахишиг гишүүний асуултад хариулъя. Энэ Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль буюу стандартыг ингээд зөрчсөн тохиолдолд Зөрчлийн тухай хууль руугаа л эргээд орчихно. Энэ дээр яг энэ бид нэмэлт, өөрчлөлт дээр энэ Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээнэ гэсэн заалтыг оруулж өгсөн байгаа. Тийм. Энийг бол ингээд л хэлэлцүүлгийн явцад бүүр боловсронгуй болгох боломжтой байгаа л гэдгийг хэлье.

Б.Пүрэвдорж: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. 2 гишүүн Их Хурал, үг хэлэх ёстой байсан. Тэгэхээр манай парламент олон хүнтэй болсон учраас хуулийн хэлэлцүүлгийг тодорхой минутаар хязгаарлаж байгаа. Тэгээд гишүүдийн өмнүүр авч, үг авчхаад яг хэлэх болохлоор алга болчихдог хүмүүс бусад гишүүдийнхээ эрхийг битгий боомилоорой гэж хэлмээр, захимаар байна. Бусад гишүүд нь үг хэлмээр байдаг, асуулт асуумаар байдаг. Гэтэл нэр нь гүйцчихсэн гээд хойшлуулаад байгаа. Асуулт асууж, хариулж дууслаа. Одоо үг хэлэх гишүүд байхгүй байна.

Гишүүд ирцдээ, санал хураалтад бэлтгээрэй, кнопоо дараад, тэгээд гишүүд. Амарсайхан дарга, сайд гишүүдийнхээ ирцийг наад хуулиа батлуулах гэж байгаа бол жоохон идэвхтэй байгаарай. Засгийн газрын оруулж ирсэн энэ хууль дээр Иргэний Зориг ногоон нам гишүүд чинь алга байна, хүмүүсээ дуудаарай. Замира гишүүн байгаа юм уу. Зарим гишүүд бүртгэлийн хурууны хээгээ уншуулаарай. Энэ өнөөдөр хэлэлцэж, хэлэлцэх эсэхийг нь дэмжиж санал хураалт явахгүй бол энэ ирэх долоо хоногийн хуваарь дээр энэ Байнгын хороодоор орохгүй учраас бүтэн долоо хоногоор хойшилж таарна. Ингэвэл чуулган 7 сарын 10-ны орой тарахаар болчихоод байна шүү. Санал хураалтад бэлтгээрэй, хүмүүс хурууны хээгээ уншуулаарай. Бүртгэлийн санал хураалт явуулъя.

Байнгын хорооны саналаар Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль шинэчилсэн найруулгын төсөл

болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна. Санал хураалт. 1.Байнгын хорооны саналаар Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль шинэчилсэн найруулгын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураая. 51 гишүүн дэмжиж, 53,1 хувиар хууль хэлэлцэх эсэх дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн Авто тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналаар санал хураая. 53 гишүүн дэмжиж, 55,2 хувиар хэлэлцэхийг дэмжлээ.

Гуравдугаарх нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн төсөлд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураая. 8 байгаа. 54 гишүүн дэмжиж, 56,3 хувиар хууль хэлэлцэхийг дэмжлээ.

Дөрөвдүгээрт нь Баяжуулсан хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураая. 54 гишүүн дэмжиж, 56,3 хувиар хууль хэлэлцэхийг дэмжлээ.

5.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураая. 54 гишүүн дэмжиж, 56,3 хувиар хууль хэлэлцэхийг дэмжлээ.

6.Монгол хэлний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураая. 53 гишүүн дэмжиж, 55,2 хувиар хууль хэлэлцэхийг дэмжлээ.

7.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураая. 54 гишүүн дэмжиж, 56,3 хувиар хууль хэлэлцэхийг дэмжлээ.

Тамхины хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураая. 54 гишүүн дэмжиж, 56,3 хувиар хууль хэлэлцэхийг дэмжлээ.

9.Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураая. 52 гишүүн дэмжиж, 54,4 хувиар хууль хэлэлцэхийг дэмжлээ.

Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураая. 55 гишүүн дэмжиж, 57,3 хувиар хууль хэлэлцэхийг дэмжлээ.

11.Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураая. 53 гишүүн дэмжиж, 55,2 хувиар хууль

хэлэлцэхийг дэмжлээ. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ.

16.37 цаг

Яасан хөгжөөнтэй байна. Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА